

Их Багшийн ярысан члээр түүх



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Их Багшийн ярьсан

үлгэр түүх

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани

ГАРЧИГ

1.	Хоёр төмсний үлгэр	7
	Бразил 1989 оны 6-р сарын 16 (Эх нь англи хэлээр)	
2.	Зэн багш хийгээд таван зуун фламинго шувуу.....	10
	Йлан, Формоса 1989 оны 3-р сарын 31 (Эх нь хятад хэлээр)	
3.	Сармагчин - лам	12
	Шихү, Формоса 1996 оны 2-р сарын 20 (Эх нь англи хэлээр)	
4.	Тоть шувууны зөвлөгөө.....	14
	Пиндүн, Формоса 1993 оны 1-р сарын 24 (Эх нь хятад хэлээр)	
5.	Эмээлийн түүх	21
	Тайбэй, Формоса 1994 оны 5-р сарын 22 (Эх нь хятад хэлээр)	
6.	Билиг ухаан угүй ид шидийн хүчний аюул.....	26
	Шихү, Формоса 1996 оны 2-р сарын 22 (Эх нь англи хэлээр)	
7.	Шуналын тулам.....	28
	Шихү, Формоса 1991 оны 9-р сарын 22 (Эх нь хятад хэлээр)	
8.	Энэ бол хөл толгойгоо алдсан өртөнц	35
	Тайбэй, Формоса 1990 оны 3-р сарын 2 (Эх нь хятад хэлээр)	
9.	Моисей шавилж ахуйдаа үг дуугүй, хүлцэнгүй номхон байсан нь	38
	Шихү, Формоса 1996 оны 2-р сарын 18 (Эх нь англи хэлээр)	
10.	Ой модыг аварсан шувуу	43
	Шихү, Формоса 1995 оны 12-р сарын 17 (Эх нь хятад хэлээр)	
11.	Их Багшийн дотоод мэдрэмж	
a)	Шувууны тухай түүх.....	48
b)	Ялааны тухай түүх	49
	Панам 1991 оны 1-р сарын 28 (Эх нь англи хэлээр)	
12.	Хааныг сонгосон охин	53
	Сидней, Австрали 1993 оны 3-р сарын 16 (Эх нь англи хэлээр)	
13.	Хайр сэтгэл ба үзэн ядалт	55
	Шихү, Формоса 1993 оны 1-р сарын 17 (Эх нь хятад хэлээр)	
14.	Бүх зүйл амнаасаа болдог.....	66
	Пиндүн, Формоса 1992 оны 12-р сарын 26 (Эх нь англи хэлээр)	
15.	Их Багшийн хүчинд итгэ	70

Шихү, Формоса 1990 оны 9-р сарын 28 (Эх нь хятад хэлээр)	
16. Гэгээрсэн шидэт дагинас	72
Шихү, Формоса 1990 оны 3-р сарын 4 (Эх нь хятад хэлээр)	
17. Эхийн зөвлөгөө	74
Шихү, Формоса 1995 оны 10-р сарын 27 (Эх нь англи хэлээр)	
18. Ханхүү Виктор ба таван зуун гүйлгачин	78
Шихү, Формоса 1996 оны 2-р сарын 19 (Эх нь англи хэлээр)	
19. Тэвчээртэй гүнж	85
Пиндүн, Формоса 1993 оны 1-р сарын 10 (Эх нь хятад хэлээр)	
20. Харамч эмгэн	93
Шихү, Формоса 1995 оны 1-р сарын 5 (Эх нь англи хэлээр)	
21. Зөрүүд гурван зарц	97
1996 оны 3-р сарын 28-ны Камбожийн даяан (Эх нь хятад хэлээр)	
22. Даруу төлөв байдлаа сэргээе	100
Шихү, Формоса 1995 оны 2-р сарын 19 (Эх нь хятад хэлээр)	
23. Улаан, Ногоон буг.....	102
Сингапур 1995 оны 1-р сарын 10 (Эх нь англи хэлээр)	
24. Шидэтсандал	107
Шихү, Формоса 1994 оны 12-р сарын 31 (Эх нь хятад хэлээр)	
25. Бурханд итгэх бидний итгэл	110
Шихү, Формоса 1996 оны 2-р сарын 22 (Эх нь англи хэлээр)	
26. Бид Их Багшийн гаднах үйлдлийг дуурайх ёсгүй	112
Шихү, Формоса 1996 оны 2-р сарын 22 (Эх нь англи хэлээр)	
27. Бүх зүйл санаа бодлоос үүдэлтэй	114
Шихү, Формоса 1994 оны 12-р сарын 29 (Эх нь хятад хэлээр)	
28. Сүнслэг бясалгагчид өөрсдийнхөө хэрэгцээг хангадаг байх ёстой	118
Шихү, Формоса 1995 оны 12-р сарын 23 (Эх нь англи хэлээр)	
29. Том гутлын арга	121
Сөүл, Солонгос 1994 оны 4-р сарын 15 (Эх нь англи хэлээр)	
30. Бурханд өргөх жинхэнэ өргөл	123
Шихү, Формоса 1995 оны 1-р сарын 5 (Эх нь англи хэлээр)	
31. Гүйлгачин эмгэний билиг ухаан.....	127
Остин, АНУ 1994 оны 8-р сарын 27 (Эх нь англи хэлээр)	
32. Ялгavarлах үзэлгүй хайр	131

Шихү, Формоса 1995 оны 12-р сарын 25 (Эх нь англи хэлээр)	
33. Хулгайч бясалгал дадуулагч болсон нь	134
Шихү, Формоса 1995 оны 2-р сарын 19 (Эх нь хятад хэлээр)	
34. Бүхнийг Чадагч Бурхан бүгдийг зохицуулдаг	137
Шихү, Формоса 1994 оны 12-р сарын 31 (Эх нь хятад хэлээр)	
35. Мөнх амьдрах нууц арга.....	140
Шихү, Формоса 1995 оны 10-р сарын 27 (Эх нь хятад хэлээр)	
36. Өглөгийн урхи занга	144
Шихү, Формоса 1992 оны 7-р сарын 5 (Эх нь хятад хэлээр)	
37. Их Багшийн нөхцөл болзолгүй хайр	154
Каошюн, Формоса 1990 оны 10-р сарын 17 (Эх нь хятад хэлээр)	

Хавсралт

a) Авшиг хүртэхүй - Арьяабалын бясалгалын арга	161
б) Ном хэвлэлийн танилцуулга	164
в) Бидэнтэй хэрхэн холбогдох вэ?	176

Товч илгээлт

Ж зэн Бурхан болоод Дээд Сүнсний тухай ярихдаа Эзэн Бурхан эр эсвэл эм хүйстэй аль нь болох тухай гарч болох маргаанаас зайлс хийхийн үүднээс хүйсийн ялгаа заадагтүй, анхдагч нэр томьёо ашиглаж байхыг Их Багш бидэнд зөвлөсөн юм.

She + He = Hes (Bless гэдэгтэй адил дуудна)

Her + Him = Hirm (Firm гэдэгтэй адил дуудна)

Hers + His = Hiers (Dear гэдэгтэй адил дуудна)

Жишээлбэл: Бурхан хүсвэл, юмыг Тэрээр (Hes) Өөрийн (Himself) талаар, Түүний (Hiers) хүсэл зоригт нийцүүлж хийдэг юм.

Уран бүтээлч, юун санааны агуу хөтчийн хувьд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоод голийн аливаа илэрхийлэлд дуртай. Тиймээс ч Тэрбээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. Ау Лак нь Вьетнамын эртний нэр бөгөөд “Аз жаргал” гэсэн утгатай. “Үзэсгэлэнтэй” гэсэн утгатай Формоса хэмээх нэр нь арлын орон болон хүн ардынх нь голийн илүү төгс төгөлдөр илэрхийлдэг. Их Багш эдгээр нэрсийг хэрэглэх нь нутаг орон хийгээд оршин суугчдад нь бурханлаг хөгжил, аз хийморь авчирна гэж үздэг юм.

Хоёр Томсний Үлгэр

Θ нөөдөр би нэгэн Их Багш буюу Гүрүг-итгэн дагах нь хэчинээн хэцүү бэрх тухай нэг сайхан үлгэрийг та бүхэнтэй хуваалцмаар байна. *Их Багшийн хэцүү*. *Их Багшийг эрж олох ч тун хэцүү*. *Тийн атал тэр Их Багшийг итгэх, найдах, мөн түүнийг итгэн дагах нь бүүр ч хэцүү*. Үлгэрт энэ тухай өгүүлнэ.

Нэгэн агуу их, төгс төгөлдөр Их Багш байжээ. Гэвч тэрээр “Их Багш” ийм байдаг гэж бидний төсөөлдөгтэй адилгүй хүн байв. Заримдаа шавь нараа аашилж загнана. (Инээлдэв) Түүгээр барахгүй, ер нь ганц, хоёр цохиод авдаг ч байсан байж мэднэ, яг л Төвөдийн аугаа йогч Мял бодг болон түүний Их Багш шиг. Тэр Багш бол Их Багш хүн хэзээ ч хийх ёсгүй гэж бидний үздэг янз бүрийн зүйлийг хийдэг байж. Жишээ нь: Хэрэв бид “Их Багш хэзээ ч уурладаггүй” гэж хэлэх бол тэр харин ч их уурладаг.

Их Багшийн хэвэл бид галзуу байх ёстой болдог. (Инээлдэв) Хэрэв та нар хэвийн хүн бол Их Багшийн хэвэл чадахгүй, яагаад гэвэл энэ өртөнцөд бүх юм эсрэгээрээ, эмх замбараагүй байдал. Сайн юмыг муу гэж бодно, муу юмыг сайшаах буюу сайн гэж бодно. Та нар зөвхөн төгс гэгээрэхээрээ л энэ өртөнц дэх бүхий л зүйлийн хөгжилтэй байдлыг нь харж чадна. Тэгээд та нар галзуу болно, нэн жаргалтай галзуу – нэн амарлингүй солиот болно.

Нэг өдөр тэр “солиотой” Их Багш шавь нарынхаа нэгэнд хоёр төмс өгөөд ид гэжээ. Тэр өнөөх шавьдаа хоёр төмсөө заавал хоёуланг нь идэх ёстой шүү гэж ахин дахин онцлон анхааруулаад байж. Тэгээд шавиа дахин дуудаад “Чи хоёр төмс идэх ёстой шүү!” гэжээ.

Шавь нь Их Багшийнхаа гараас хоёр төмс аван гадаа гарч суугаад идэж эхлэв ээ. Ингэхэд үнэндээ хоёр төмс идиэ гэдэг чинь маш амархан хэрэг биш үү? Та нар үүнийг тийм ч хатуу сорилт биш гэж бодож байгаа. Хоёрхон төмсийг хэн ч идчихэж чадна. Тэгээд идэх зуураа “Их Багш ингэдэг нь яаж байгаа юм бол?” гэж өөрөөсөө асууж суужээ.

Иймэрхүү л зүйл бодож байж. Гэхдээ эдүгээг хүргэл маш урт хугацаагаар Их Багшийгаа дагаж байгаа тул юутай ч Их Багш нь хэлсэн болохоор үүнд ямар нэг учир шалтгаан байгаа, тиймээс

дуулгавартай дагах ёстойгоо мэдэж байв. Иймээс тэндээ суугаад идэж л байж. Нэгийг нь хэдийнээ дуусгачаад нөгөөг нь хальсалж эхлэв. Тэгтэл их өлсөж, хариугүй үхэх шахсан гүйлгачин ирээд “Энэ төмсөө над өгөөч, тэгээч дээ, та нэгийг нь идчихсэн шүү дээ, би очион хоног юу ч идээгүй,. Хэрэв та үүнийг надад өгөхгүй бол би үхэх нь!” гэжээ.

Ингэвэл одоо та нар яах вэ? Та нар өрөвч сэтгэлээ дагах уу, эсвэл Их Багшийгаа дагах уу? Их Багш нь хоёр төмсөө заавал хоёуланг нь идээрэй гэж онцлон анхааруулсан бөгөөд дүрэм ёсоор бол та нар хэзээ ч үгнээс нь гажиж болохгүй. Гэтэл тэр өлссөн хүнд идэх юм өгөхгүй байх нь дэндүү хунигүй явдал болно. Тэгж суухад нь ухаан санаа нь Их Багш, гүйлгачин хоёрын дунд нааш цааш тээнэгэлзэн байв. Гэтэл гүйлгачин орилон чарлаж, газар унаад үхлийн ирмэгт тулсанд өнөөх шавь нь үлдсэн төмсөө түүнд даруйхан өгчхөв. Тэгээд гэр лүүгээ явмагц, гүйлгачин ч бас үзэгдэхээ больжээ.



Мань хүн гэртээ ирээд Их Багшдаа болсон явдлаа илтгэжээ. Гэтэл харин Их Багш нь загнаж гарав. Шавиа үгнээс нь зөрлөө гэсэн дээ биш, харин шавиа өрөвдсөндөө, харамссандаа хашхичин загнажээ. Тэр хоёр дахь төмс бол оюун санааны гэгээрлийн дээд дэсийн, төгс гэгээрлээр адислагдсан байтал харин эхнийх нь төмс энэ өртөнцийн эд хөрөнгө, ололт амжилт, алдар нэрийн адистай байжээ. Их Багш нь “Чи минь ямар мунхаг юм дээ?” гэжээ. “Энэ тэгээд хувь тавилан чинь л юм байлгүй дээ. Тэгээд л хоёр дахь адислалыг хүртэж чадаагүй байх нь” хэмээн санаа алджээ.

Хожим нь өнөөх шавь нь энэ өртөнцөд үргэлж од хийморьтой байж, алдар нэрд хүрч, маш их мөнгөний орлоготой болсон боловч Их Багш болсонгүй, өөрөөр хэлбэл орчлон дахь хамгийн дээд байр суурь, хамгийн эцсийн зорилгодоо хэзээ ч хүрээгүй аж.

Энэ бол бидний ихэнхэд байдаг асуудал. Бид өөрсдийгөө бүгдийг ойлгож мэддэг, бүгдийг зохицуулж чадна гэж боддог. Бас өөрсдийгөө ямар ч “би” гэх үзэлгүй гэж боддог. Бид Их Багшийг дагах буюу Түүнд бууж өгөх нь маш амархан гэж боддог. Гэтэл үгүй юм аа, энэ нь тийм ч хялбар биш аж. Хоёрхон төмс идэхэд л

асуудал учирч байна шүү дээ. (Инээлдэв)

Иймээс бусад хүнд сорилтыг давж чадна гэж мөрөөдөхөд ч хэцүү. Яагаад гэвэл бидэнд хэдэн мянган жилийн турши хураасан мугуйд зан, нийгмийн ёс заниш, суурь мэдлэг дэндүү их байна. Тэгээд энэ нь бидний тархинд нэвчсээр ирсэн бөгөөд түүнийг ахархан хугацаанд угааж арилгахад хэцүү болжээ.

Бид өөрсдийгөө зөв, бурууг ялгаж чаддаг гэж үргэлж боддог. Гэгээрэхэд маань энэ бүх мугуйд зан ямар хэрэгтэй вэ? Энэ нь бидний замд саад л болно. Их Багши нэг зүйлийг хий гэж хэлэх болгонд бид “Үгүй, үгүй, би үүнийг мэднэ. Ээж минь над ингэж хэлсэн, сургуулийн багши маань ч тэгж сургасан, сумийн лам маань ч тэгж номлосон” гэж боддог учраас өөрөөр хийдэг.

Их Багши биднээр хийлгэхийг хүссэн юмны яг эсрэгээр нь хийдэг, тэгээд Их Багши үргэлж бидний мугуйд зантай тэмцэх хэрэгтэй болдог. Бидний ихэнх нь сохор, дүүлий, дүйнгэ. Зөвхөн Их Багши л тов тодорхой харж чадна. Бусад нь зөвхөн бүдэг бадагхан хардаг, зарим нь юу ч хардаггүй. Бид харж байна, ойлгож байна гэж боддог ч тийм биш. Энэ бол энэ дэлхийн үнэхээр аугаа хуурамч үзэгдэл. Энэ бол Маяагийн үнэхээр гайхалтай, аугаа ажил.

Энэ ов мэх биднийг хууран мэхэлж, хэзээ ч итгэмээргүй юманд маань итгүүлчихдэг. Энэ хуурмаг байдлаас гаргах гэж нэгэн сэргж гэгээрсэн хүн ирвэл бид түүнийг маш үнэнч, эелдэг, хулиэнгүйгээр дагадаг. Гэхдээ бид бас тийм ч хурдан сэргэггүй. Яг л өглөө болж, сэргүүлэг дуугарахад бид “Аа... аан...,” гэж унтраачхаад эргээд унтичихдагтай адил.

Тиймээс бидэнд ийм олон шашин, бас гэтэлгэдэг гэгдэх маш олон зам мөр байна. Гэтэл бид юу харж байна вэ? Дэлхийн хүн ам өдрөөс өдөрт ихсэж байна. Энэ нь манай дэлхийгээс нэг ч хүн, эсвэл тун цөөхөн хүн чөлөөлөгдөж байна гэсэн уг. Тийм бишсэн бол юу гэж хүн ам өсөөд байх билээ дээ? Хэрэв олон хүн чөлөөлөгдөн гэртээ харьж, тэнгэрийн элч, Бурханы туслах, Бурханы хүү, охин болж, үүрд диваажиннд амьдардаг байсан бол энэ дэлхийн хумүүс бүр цөөхөн болох байсан юм.



ЗЭН БАГШ ХИЙГЭЭД ТАВАН ЗУУН ФЛАМИНГО ШУВУУ

*Д*арт дээр үед их сайн бясалгадаг нэгэн лам байжээ. Тэр хэдэн төрөлдөө лам хувраг байсан боловч үхэж төрөхийн хүрднээс чөлөөлөгдөж чадаагүй аж. Та нар сахилаа чанд мөрддөг, тун ариун явдалт лам байсан байж магад, хэрэв гэгээрэлд хүрч чадахгүй бол, дараагийн төрөлдөө дахин лам болох нь бидний хувьд хүсэж болох хамгийн эрхэм зүйл. Энэ нь угаасаа тун сайн хэрэг. Яагаад гэвэл дахин лам болж төрж чадахгүй ч юм билүү!

Өнөөх лам маань олон удаа эргэн төрөхдөө таван зуун жилийн турш дандаа л хуврагийн төрөл авчээ. Төрөл болгондоо хамба ламтан болж, буян хариулал нь асар их болжээ. Хэдийгээр тэрээр гэгээрээгүй ч сахилаа чанд сахиж, үнэхээр ариун явдалтай, үнэнч шударга байж л дээ. Хамгийн сүүлчийн төрөлдөө лам байж, хaa сайгүй бадар барин сургаал айлдаж явахад нь таван

зуун фламинго шувуу үргэлж дагаж явдаг байжээ. Үүнийг нь хүмүүс их гайхдаг байж. Билгийн нүдээрээ харж чаддаг нэг хүн тэр шувууд түүний урьд төрлийнх нь шавь нар гэдгийг нь хэлжээ. Тэр үед лам таван зуун шавьтай байсан бөгөөд сүнснийх нь хүч чадал хангалттай их байгаагүйгээс тэднийгээ чөлөөлж чадаагүй ажээ.

Өргөл барьц хүлээж авах, хүндэтгэлийн зоогт оролцох, ном тавих гэхчлэн гадуур гарах болгонд нь шавь нар нь хамт явахыг хүсдэг байжээ. “Хийдийн хүмүүс бүгд адил тэгш эрхтэй гэж та хэлдэг биш билүү! Тэгж хэлдэг хэрнээ та ганцаараа л гарч зугаацаад биднийг бараг авч явахгүй юм” хэмээн гомдоллодог байв.

Үнэндээ шавь нарт нь бусдад магтуулж, өргөл барьц хүртэх хангалттай буян байхгүй гэдгийг их багши нь мэддэг байж л дээ. Шавь нар нь үүнийг ойлгоогүй бөгөөд эгэл жирийн хүн болохоороо дандaa л материаллаг зүйлд дурладаг байж. Ингээд их багши нь аргагүйдэн гадагш явахдаа тэднийгээ дагуулж явдаг болов.

Хожим тэр таван зуун шавь нь өөд болсон бөгөөд дараа төрөлдөө эргээд лам болж чадалгүй харин фламинго шувуу болжээ! Зөвхөн их багш нь л эргээд лам болж чаджээ. Ийнхүү гадагш явах болгонд нь өнөөх таван зуун шавь буюу одоогийн фламинго шувуу хамт явдаг болсон нь тэдний хоорондын л асуудал.

Нэгэнт л тэр өөрийгөө ч, шавь нараа ч чөлөөлж чадаагүй юм чинь шавь нар нь өөрсдийнхөө үйлийн үрийг үүрэхээс өөр аргагүй. Хэрэв таны Их Багшиасар их хүчтэй бол хийсэн өчүүхэн үйл үрийн тань гай зэтгэрийг ч угааж чадна. Танд гэгээрсэн Их Багши хэрэгтэй байдгийн учир нь энэ!



САРМАГЧИН - ЛАМ

Эртээ урьд цагт нэгэн лам сармагчны төрөл аван төржээ. Буддаг дхарма буюу Үнэн Ёсыг номлохоор энэ дэлхийд залран ахуйд олон лам хувраг Түүнд шавь орж суралцсан гэнэ. Тэдний зарим нь архадын хутгийг хэдийнээ олсон байсныг ихэнх хүн мэддэггүй байв. Бусад лам нь заримдаа тэднээр доог тохуу хийнэ. Яагаад гэвэл тэдний зарим нь нүдэнд аятай бус, жаахан “инээдтэй” харагддаг байж л дээ.

Бас нэг тун дэггүй лам байжээ. Тэрээр архадын нэгийг толгодоор уруудан гүйж байхыг харах болгондоо “Чи яг л тэр толгодоор гүйж явдаг өнөөх сармагчин шиг харагдаж байна” гэдэг байжээ.

Тэрээр ламыг сармагчин хэмээн дуудан шүүмжилж

байсныхаа улмаас таван зуун төрөлдөө сармагчин болж төрөх ёстой болж гэнэ.

Ийнхүү тонк, тонkey гэдэг үгэнд хоёрхон үсгийн зөрөө байдаг. Иймээс лам хувраг хүнийг шоолж, дооглож болохгүй, ингэхээс болгоомжил. Хэрэв та жирийн ламыг доог тохуу хийвэл бүх юм зүгээр өнгөрч болох юм. Гэтэл тэр лам архадын хутгийг олчихсон бол та өнгөрөх нь тэр. Аль нь хэдийн архад болсон, аль нь бясалгалын өндөр түвшинд хүрснийг та хэзээ ч мэдэж чадахгүй. Иймд та нар анхаарал болгоомжтой байх хэрэгтэй.

Ялангуяа та бүхний хүсэлтийг ёсоор болгож, та бүхэнд үнэн ёсыг зааж сургахаар Миолигаас танай улс руу илгээсэн хуврагийг минь дооглож болохгүй, бас царай зусээрээ сэтгэлийг нь татах гэж оролдвол бүүр ч болохгүй. Буддын шашинд амьд Их Багшийн шавь болсон хуврагийг уруу татах гэж оролдох нь аймшигтай нүгэл гэж хэлсэн байдал.

ТОТЬ ШУВУУНЫ ЗӨВЛӨГӨӨ

Д нэ бол “Тоть шувууны зөвлөгөө” гэдэг еврей үлгэр.

“Хаан угсаат” гэгддэг нэгэн ер бусын totь ордонд амьдардаг байж гэнэ ээ. Тэр totь тун ганганд, нэн үзэсгэлэнтэй, зарим талаар “надтай” төстэй байж. (Инээлдэв) Эзэгтэй гүнж нь түүнд маш их хайртай байжээ. Totь үзэсгэлэнтэй сайхан харагдахын дээр зохих ёс журмыг ч сайн мэддэг учраас тэр хоёр хоорондоо сайхан зохицдог аж. Цай уухдаа ч явал сайхан янз төрхтэй байхаа анхаарч, явахдаа ч хааны төрх гарган гүя ташаагаараа найгалзан хөнгөхөн алхалж, нэг алхам урагшилж, зургаан алхам ухрах... мэтээр тэр totь туйлын дэгжирхэн чамирхдаг байв. Тиймээс түүнийг “Тоть авхай” гэж дуудьяа даа.

Учир нь totь хааны гэр бүлийнх болохоор түүнийг хачин сайхнаар гоёж гангалдаг байжээ. Хэдийгээр тэр totь ч гэлээ хааны ордонд амьдарч байгаа болохоор тэдний гэр бүлийн гишүүнд тооцогддог байв. Тэр totь ярьж чаддаг төдийгүй Ариун нэрсийг ч дуудаж чадна. Сэргэлэн цовоо тэрээр хүний хэлээр чөлөөтэй, сайн ярьж чадна. Торыг нь алтаар хийж, маш олон эрдэнийн чулуу; очир алмаас, сувд, шүрээр товруу гарган урласан аж!

Гүнж өдөр болгон бараа бологчдоо хэдэнтээ дуудаж, totь руу явуулан үйлчлүүлдэг байв. Түүнд дутагдаж гачигдах юу ч үгүй, өдөр бүр янз янзын малгай өмсөж, сүүлэндээ янз бүрийн сувд, жигүүртээ төрөл бүрийн бадмараг зүүдэг байв. Өдөр болгон сүүлэнд нь янз янзын эрдэнийн чулуу сүлжинэ. Бие нь бүхэлдээ гэрэлтэн гялалзана. Хоолны цаг болоход тор луу нь адистай хоол хүргэж өгнө. Хоол хайж явах хэрэг ч үгүй.

Удаг усыг нь Ян Мин уулын горхиноос авчрах бөгөөд энэ усыг маш сайхан амттай гэлцдэг юм билээ. Цаашилбал энэ ус маш зөөлөн, усанд ороход тун таатай. Тийм болохоор нэгэн тайган Ян Мин ууланд очиж, өдөр бүр нэг лонх ус авчирдаг байв. Үе үе, сар бүрийн эхний болон арван тав дахь өдөр, мөн ням гарагт өөр ус уулгахын тулд ондоо нэг тайган Мияоли руу явж, Нектар (Рашаант) голоос ус авчирна.

Totь өөрөө их өнгөлөг. Зарим өд нь ногоон, зарим нь цэнхэр бөгөөд тэр бүхэн нь гялалзан гэрэлтэж байдаг. Totийг бас их сэхүүн зантай гэж ярьдаг. Хэрэв эзэн нь тэр Нектар голын усыг

адисалж амжаагүй байвал уух ч үгүй. Тайганыг Ариун нэрсийг унш гээд Ариун нэрсийг олонтоо уншиж, Ян Мин уулнаас болон Нектар голоос авчирсан усыг адисалсаны дараа л тэр уудаг гэнэ. (Инээлдэв)

Хоолоо идэхийнхээ өмнө юун түрүүнд Бурханд өргөлгүй залгичихдаг та нарын заримтай адилгүй аж. Тийм уу. Хэрэв та нар аль хэдийнээ залгичихсан бол одоо яая гэхэв. Бурханд өргөхийн тулд буцааж гаргалтай нь биши. Тэр даруй наран сүлжээ хүрдэнд очсон хоолоо адислахыг дотоодын Их Багшдаа хандан залбирч гүй. Адислах хүч ялгаагүй л адисална. Шингэхгүйн зөвлөн байхгүй. Хоолойгоор давж, ходоод руу орсон ямар ч хоолыг энэ хүч адисална шүү.

За, одоо бүгдээрээ үлгэрийнхээ дараагийн хэсэг рүү орьё. Надад тэр тотьны билиг ухаан, гоо үзэсгэлэнг илэрхийлэх үг ч олдохгүй байна. Тоть энэ байдлаа хэрхэн хадгалахаа мэддэг бөгөөд тэгж байж л өдөр бүхэн үзэсгэлэнтэй сайхан харагддаг байлаа. Тэр ганцхан өдрийн дотор үзэсгэлэнтэй болчихоогүй хэрэг. Төрсөн цагаасаа л зөвхөн Нектар голын ус ууж, Бурханд өргөж, Ариун нэрсээр адисалсан амттай хоол идэж байсан учраас өдрөөс өдөрт улам улам үзэсгэлэнтэй болж өссөн аж.

Үүнээс гадна тэр тоть өдөр бүр хоёр цаг хагас бясалгадаг. Мөн цэвэр ургамал хоолтон тэрээр ганц ч өт мөт идэж үзээгүй. Санаандгүйгээр нэгийг залгичихвал тэр бяцхан авгалдайн үс бүрийг нь ч бөөлжин гаргаж чадна. Бага залуу байхдаа элэнц өвөг дээдсээ Арьяabalын аргаар бясалгадаг байсныг сонсоод ургамал хоолтон болохоор шийджээ. Тоть бясалгаад нэлээд өндөр түвшинд хүрсэн бөгөөд тиймээс гүнж үүнд нь их дуртай. Магадгүй түүнээс нь их сайхан энерги мэдрэгддэг биз. Гоо үзэсгэлэн нь дотроосоо гэрэлтдэг аж.

Нэг өдөр гүнж зайдуухан орших нэгэн улсад өөрт нь байдаггүй ховор сүрчиг байдгийг сонсоод тайганаасаа тэр сүрчгийг авчирч өгөхийг гүйжээ. Тэр тайган нь тотьны сайн найз нь бөгөөд өдөр бүр түүнтэй ярилцдаг байжээ. Ордон дахь тайганууд үргэлж л уйдаж байдаг. Учир нь тэд эмэгтэй найзтай болж чадахгүй юм чинь. Тэдний амьдрал юуны төлөө байдаг гэж та нар бодож байна? Үүнээс болоод өдөр болгон уйдаж байдаг түүнд хувийнхаа асуудлыг ярих тоть тэнд байж таарчээ. Гайхалтай! Тэр хоёр сайн найзууд бөлгөө!

Тайган явахынхaa урьд өдөр тэр тухайгаа мэдээжээр тотинд очиж хэлжээ! Хэдийгээр энэ нь нууц даалгавар байсан ч гэсэн хамгийн сайн найзаасаа нууж чадалгүй “Баяртай! Сайонара!” гэж

хэлэхээр очив. Тайганыг ийм хол явахыг сонссон Тоть түүнийг ихэд үгүйлэх нь дамжиггүй. Ийнхүү салах ёс нь сэтгэл хөдлөм байжээ.

Хэдийгээр тоть тайгантай нөхөрлөсөндөө ихэд баяргладаг боловч түүнээс ч илүү эрхэмлэдэг нэг зүйл байж, тэр нь юу вэ? (Танхимаас: Гүнж) “Эрх чөлөө”. Юуны чинь гүнж! Гүнж бол зөвхөн түүнийг дооши хүлжс байгаа л нэгэн. Юундаа гүнжийг нандигнах билээ? Зөвхөн та нар л сатаныг нандигнадаг байх. Энэ ертөнц та нарыг дооши хүлдэг, та нар үүнийг, энэ амьдрал, энэ биеийг хамгийн аугаа сайхан, хүчтэй гэж бодон нандигнадаг. Энэ бие бол бидний сүнсийг энд хүлж, цоожсилж байдаг зүйл шүү дээ.

Бид энэ бие дээрээ өглөөнөөс орой болтол төвлөрч, над шиг л улаан, ногоон өнгөөр будан гоёж байдал. Тэгээд л бид жинхэнэ Мөн Чанараа мартажс, би энэ бие бииш шүү гэдгээ ч умартааг. Одоо би сүнсээ мартжсээ. Яагаад гэвэл тэр маань зугтаад явчихсан. Одоо зөвхөн бие минь л улдсэн болохоор юу ч хийсэн хамаагүй.

Тиймээс ч тоть дээрхээс илүүгээр эрх чөлөөгөө л нандигнаж, нисэн одохсон гэж өдөржин, шөнөжин мөрөөддөг байв. Хэдийгээр тэр улаан, ногоон энгэсэг нялж, уруулын будаг мэтийн янз бүрийн зүйлээр будаж байвч сэтгэл зүрх нь зөвхөн эндээс нисэн одохос өөр юуг ч бодлогүй байв. Ордонд соёлтой, эелдэг боловсон байх ёстой тул мэдээж тоть тэр бүхнийг идэж ууж, өмсөж зүүхээс өөр аргагүй. Гэхдээ сэтгэл нь зөвхөн билгийн мэлмий дээрээ төвлөрч, өдөржингөө гагцхүү зугтах тухай л боддог байж.


Тиймээс тайганд “Өө. Бид чинь сайн найзууд. Би чамаасаа нэг тусlamж гүйя. Битгий мартаарай!” гэжээ.

Тайган хэлсэн нь: “Тэгэлгүй яах вэ. Би чиний төлөө юуг ч хийнэ.” Тэд ийм л сайн найзууд байжээ.

Тоть хэлсэн нь: “Аян замд явж байхад чинь надтай адилхан шувуу тааралдвал тэд миний ах дүү, анд нөхөд юм шүү. Тэдэнд маань намайг энд торонд орчихсон байна гэж хэлээрэй. Би үнэхээр эрх чөлөөгүй асар их зовж байна. Энэ бүх тансаг хоол унд надад юу ч биш. Тэр бүх үнэт эрдэнэ ч бас ямар ч үнэ цэнэгүй. Намайг аврах арга тэдэнд байгаа эсэхийг асуугаад өгөөрэй.”

Тайган “Тэгэлгүй яах вэ. Би чадах чинээгээрээ тусална аа. Заавал тоть шувуудыг олж уулзаад үүнийг чинь дамжуулья” гэжээ.

Тэр тайган ч гэсэн ордонд ажиллах болсноосоо хойш юугаар ч дутагдаагүй ч гэсэн бас л хэн нэгний боол шүү дээ. Иймд



эрх чөлөөний үнэ цэнийг сайн мэддэг тул тотийг тун сайн ойлгож, туслахаар шийджээ.

Гүнжийн сүрчгийг хайж удтал эзгүй байжээ. Замдаа байгалийн сайханд баясан явж байтал нэг өдөр ордны тотьтой тун адильтан сүрэг шувуутай тааралджээ. Тэгээд тотьны захиасыг санаж, очиж уулзан түүний хөөрхийлөлтэй байдлыг хэлжээ.

Сүргийн дунд нэгэн их багш төт байжээ. Тэр нь бусдадаа Аряябалын аргыг заадаг байж

л дээ. Ингээд тэд өөр өөр газар нутгаар явж, өдөр бүр хамтдаа бясалгадаг юмсанж. Тэр өдөр тэд Миоли руу явж, нийтийн том бясалгалд оролцох гэж байжээ. Өө! Өвөл байсан юм чинь Пиндуун явж байсан байх аа! Пиндуунд хамаагүй дулаахан шүү дээ. Энэ жинхэнэ их багш тун ухаалааг, маш их билиг ухаантай, хэдэн зуу, мянга, сая галавын турш бясалгасан болохоор нэн сүр жавхлантай, амар амгалан, билиг ухаан нь гэрэлтсэн, алтлаг гэрлээр гялалзсан, билгийн мэлмий нь аргагүй хурц тод гийсэн нэгэн байжээ.

Ордон дахь өрөвдмөөр байдлын тухай сонсмогцоо тэр дороо үхэдхийн унав. Далавчаа дэрлэн үхэдхийн унасан түүнд хүч чадал, амь амьсгал байгаа шинж огт үгүй байв. Тэр бүрмөсөн үхчихсэн мэт санагдаж байлаа. Хэчинэн хүчтэй сэгсээрсэн ч сэргж чадахгүй, ус авчраад аманд нь хийсэн ч нэмэргүй, идэх юм хийлээ ч идэхгүй, ганц ч өд нь хөдлөхгүй, хөмсөг, сормуус нь ч анивчихгүй, бүр сэргүйгээр үхчихжээ. Тайган ямар ч зөвлөгөө авч чадаагүй дээ, үхэхээс нь өмнө ярилцах боломж олдоогүйд ихэд урам хугарчээ. Ингээд түүнийг замын хажууд орхиод явжээ. Гэтэл тэр даруйхан төт маш хурдан дэрр, дэрр хийгээд нисээд явчхаж... Бясалгахаар түрүүлээд явчихсан нөхөдтэйгээ нийлэхээр Пиндуун лүү нисэн одлоо. Хөөх! Тайган бүүр гайхширч хоцров? Юу ч ойлгосонгүй. Ийм юм байж яж болох вэ? Болсон явдалд толгой нь эргэсэн тэрээр гайхширан удтал тэндээ зогсов.

Эцэст нь ордон луугаа буцлаа. Өдөржингөө л тэнд зогсоод байлтай биш. Ордны төт тайганаыг хараад ихэд баярлаж, гар, хөлөө барилцаж, тэврэлдэн үнсэлцэж, сайн сайхан зүйл олныг ярив.

“Чи турчхаж” гэж нэг нь хэлэхэд нөгөөх нь,

“Чи таргалчхаж” гэлцэн энэ дэлхийн аар саар хэрэггүй зүйл ярилцав.

Тайган түүнд замдаа таарсан ер бусын сонирхолтой олон зүйл ярих гэсэн ч үнэндээ тоть сонсьё ч гэсэнгүй. “Юу идсэн? Ямар тоглоом тоглосон? Чи аль караокед очсон? Ямар бүжиг хийсэн? Ямар сайхан охин харсан? гээд энэ бүхэн чинь бүгд хэрэггүй зүйл. Чи бол тайган, сайхан охидын тухай ярих хэрэг юун. Хэнтэй бүжиглэж цэнгэсэн чинь надад ямар ч хамаагүй, иймэрхүү юм битгий ярь!” гэж тоть хэлээд “Миний төрөл төрөгсөд, миний нөхдийн хэн нэгэнтэй уулзвав уу?” хэмээв.

Тайган: “Тэгсэн, тэгсэн. Би нэг сүрэг шувуутай тааралдсан. Тэд нийтийн бясалгальдаа явж байх шиг байна лээ. Тоть болгон их том, гялалзсан билгийн мэлмийтэй! Би бүр гайхсан! Би тэднийг маш их хүндэлсэн. Ихэд ариун буянтай харагдах тэд үнэхээр сүр жавхлантай. Эрүү нь доошлоход хэвлэж нь томорч, мөр нь тэвхийгээд агаарт нисэх нь яг л тэнгэрийн элчис мэт... гэхэд нь тотины тэвчээр алдагдаж, “Би чамаас тэднийг ямар харагдаж байна гэж асуугаагүй. Тэд чамд ямар нэг юм хэлэв үү? Тэд намайг яаж чөлөөлөгдөх талаар ярив уу? гэхэд тайган хэлсэн нь: “Үгүй, үгүй! Тэд чиний хэлээр ярьж чаддаггүй юм шиг байна лээ. Хэдийгээр билгийн нүд нь нээгдсэн ч ам нь нээгдээгүй, хүний хэлээр ярьдаггүй юм байна лээ. Тэгээд л над юу ч хэлээгүй. Харин чамайг одоо асуухаар чинь ойлгомжгүй нэг юм болсныг эргэн санаалаа. Юу вэ гэхээр, чиний тухай ярьсны дараа нэг нь миний гар дээр унаад өгсөн. Баярлахаас минь урьтаад тэр үхчихсэн.

Тэр үхсэн дүр эсгээд хэвтээд байсан. Яаж ч сэгсрээд нэмэр болоогүй. Би ус уулгаж, хоол идүүлэх гээд ч чадаагүй. Хачин сайхан үнэртэй тун ховор хоол өгсөн ч тэр идээгүй. Миаоли дахь Нектар голын сайхан усыг ч тэр тоогоогүй. Идэх ч үгүй, уух ч үгүй, үхсэн дүр эсгээд байсан.

Би түүнийг үхсэн гэж бодоод замын хажууд тавьсан юм. Тавьсны дараахан тэр шууд л эрх чөлөөтэй, эрхэмсгээр нисэн одсоон. Тэр бүр над баяртай гэж хэлсэн гээч. Баяртай гэдэг үгийг хэд хэдэн хэлээр хэлсэн шүү. Чухамдаа бол би түүнийг ярьж чаддаггүй гэж, бас үхчихлээ л гэж бодож байлаа. Тэгсэн чинь тэр ийм болчих юм. Ёстой хачин. Одоо хэр нь би ямар учиртай болохыг ойлгож чадахгүй явна.

Үүнийг сонсоод тоть үүнд автаагүй царай гаргав! “За! За! Чамд их баярлалаа! Над ч бас хачин санагдлаа. Наадах чинь хачин явдал байна. Яахаараа ийм сонин юм байдаг байна аа!” Тэгээд хоёул гэр гэр лүүгээ буцав. Тайган аахар шаахар ажилдаа завгүй,

харин тоть идэж уугаад бас л завгүй байв.

Харин гүнж өглөө бүр тогтоо харах гэж ирдэг байж! Маргааш өглөө нь тогтоо үзэхээр ирэхэд тоть нь торондоо үхчихсэн хэвтэж байв. Гүнж зарцдаа ихэд уурлан загнаж “Чи түүнийг алчихлаа, чи л алчихлаа!” гэлээ.

Юу ч хэлээд нэмэргүй болжээ. Эцэст нь үхсэн тогийг гадагш гаргаж хая хэмээн тушаав. Зарц түүнийг цонхиор гадагш хаях тэр мөчид л өнөөх тааралдсан тогийн санааг ойлгожээ.

Та нар юу ойлгов? (Танхимаас: Үхсэн дүр үзүүлэв.) Үхсэн дүр үзүүлэв! Зөв! Бид ч бас энэ ертөнцөд үхсэн мэт дүр үзүүлэх хэрэгтэй. Бид энэ ертөнцийн үнэ цэнийг мэдэж байгаа шүү дээ. Хүний биеийг олж авахад ямар хэцүү байдгийг мэднэ. Гэхдээ бид Маяагийн хаанд хэлж болохгүй. Маяагийн хаан гэж юу вэ? Энэ бол бидний уураг тархи. Түүнийг бүү сонс. Түүнтэй бүү тогло. Энэ ертөнц бидэнд сайн байдал гэж бодож болохгүй. Энэ дэлхий дээр үхдэл мэт байхад л сүнс маань дахин амьдарч эхэлдэг.

Тийм учраас эрт үеэс эдүгээ хүртэлх үе үеийн Их Багши бидэнд энэ дэлхийн юунд ч битгий хүлэгд, үхсэн мэт бай хэмээн сургадаг юм. Тэгж байж л бид эрх чөлөөтэй байж чадна. Гэтэл үнэндээ бид бусдыг голдоохоос айдаг, бусад хүн биднийг муу хүн гэж хэлэх вий гэхээс айж эмээдэг болохоороо л өглөөнөөс орой болтол хүмүүсийн өмнө үүрэг хариуцлага хүлээж, ичиж зовж, эелдэг боловсон байх гээд нэгээс нөгөөг дагалддаг. Үнэн шүү, бид асар их цагийг үрэн таран хийж байна!

Өнөөдөр бид тэр хүнтэй төрсөн өдрийнх нь үдэшилэгт бараа болно, маргааш өөр хүнтэй түүний гашуудлын ёслолд оролцено, нөгөөдөр нь бас бусдын гэрт өөр хэн нэгнийг даган хуримын ёслолд оролцено, тэр хосынхоо салах ёслолд гэрчээр байлцана, учир нь бид сайхан сэргэлтэй, эелдэг боловсон билээ г.м. Тэгэхээр бид яаж ч завтай байх вэ дээ?

Өнөөдөр бид тэр хүмүүсийн утсаар чалчихыг сонсоно, дараагийн өдөр нь бусад хүний утгагүй үг ярианд хариу өгнө. Түүнчлэн сонин уншина, зурагт үзнэ, ядахдаа л мэдээ харж, хэн нь хэнийгээ алсныг мэдэж авна. Тэгээд маргааш нь яах вэ? Хэрэв бид олон хамаатан садантай бол үхтлээ завгүй байх нь ээ. Тиймээс энэ ертөнцөд бясалгах цаг зав гаргана гэдэг их хэцүү! Бид хэрвээ энэ мэтчилэн өөрсдийгөө дооши нь уяад байвал ийм юмнаас гарч чадахгүй нь ойлгомжтой. Бид үхсэн мэт дүр үзүүлэхээс өөр арга зам байна уу? Байхгүй ээ!

Яаж үхсэн дүр үзүүлэх вэ? Бид хэлгүй, тэнэг, дүлий юм шиг


байж болно. Тэд биднийг буруу ойлгож л байг, зэмлэж л байг, энэ хамаагүй. Бидэнд зааг хязгаар байх ёстай, юу хамгийн чухал вэ? гэдгийг мэддэг байх ёстай. Бид юулхийж чадах байна, түүнийгээ л хий. Хийж чадахгүй юм өөр байвал тэр чигээр нь орхих ёстай. Бид үхсэн юм шиг дүр үзүүлж, эелдэг боловсон занг мэддэггүй юм шиг царайлж, өнөөдөр түүний төрсөн өдөр, маргааш түүний оршуулга гэдгийг мэдээгүй юм шиг байх ёстай.

Хэрэв бидэнд цаг зав хүрэлцээд амьдрал болоод байдагсан бол зүсэн зүйлийн эелдэг боловсон ёсыг дагаад л байхсан! Гэтэл амьдрал угаас зав чөлөөгүй, олон зүйлд уяулсан бид ядаж л хоёр гарсаа чөлөөлөхийн тулд уяа зангилааг тайллааг аргыг хайж олох ёстай. Тэгэхгүй бол хамаг юмаа уяж хүлүүлчихсэн бид яаж хөдлөх болж байна аа? Бид зуун хувь ухчихсэн мэт дүр үзүүлж чадахгүй бол ядахдаа наян хувь дур үзүүлж болно. Наян хувь бол бараг л чөлөөлөгдөнө гэсэн уг.

Яг өнөөх тоть шиг, бүрмөсөн үхчихсэн дүр үзүүлж чадахгүй ч наян хувь байхад л болчихно. Өвдсөн дүр эсгэсэн ч болно, тэд таныг эмчид аваачиж үзүүлэх нь лавтай. Тэгэхээр нь л чөлөөлөгдөх замаа бод. Гэхдээ энэ нь арай л аз турисан хэрэг болно. Буур үхчихсэн мэт дүр үзүүлбэл хамгийн сайн. Тэгвэл хумүүс таныг шуудхан л хаячихна. Тэгэнгүй нь л нисээд явчхаж болно.

Бясалгагч бид ч бас тэгэх хэрэгтэй. Бид энэ дэлхийд юугаар ч гачигдаагүй хэрнээ л дураараа байж чадахгүй байна. Хамгийн их хүсэж тэмуулж байгаа зүйл бол чөлөөлөлт. Чөлөөлөлт гэж юу юм бэ? Ай даа! Бидэнд ямар ч хүсэл шунал байхгүй байсан бол тэгээд л энэ төрөлдөө чөлөөлөгдчих байсан юм! Тэгээд амьдрал маань амар амгалан, сэтгэл тэнэгэр болж, дотооддоо нэн аз жаргалтай, гаднаа асуудал бэрхшээлээ зохицуулчих чадвартай болчих байсансан.

Нэгэнт л энэ амьдралдаа чөлөөлөгдчихсөн бид жинхэнээсээ үхсэн ч дараагийн төрөлдөө бас л чөлөөлөгдөнө. Амьд байхдаа энэ дэлхийд хүлэгдээгүй юм чинь үхэхдээ юу гэж юманд хүлэгдэх билээ. Яг өнөөх тоть шиг, торон дотор нь хэчинээн сайхан хоол байсан ч идэхийг хүсэхгүй байдагтай адилхан. Нисэж чаддаг болж, эрх чөлөөгөө олж авсны дараа тэр юу гэж торондоо хүлэгдэх вэ дээ? Тиймээс л бясалгагч хүн яг л тэр тоть шиг байдаг юм!



ЭМЭЭЛИЙН ТҮҮХ

Энэ бол эмээлийн тухай үлгэр. Анх моринд эмээл гэж байдаггүй байжээ. Хожим хүмүүс бясалгасны ач тусаар эмээл үүссэн байж магад.

Ляо Ху нэртэй нэгэн эр байж. Тэр бидэнтэй адил сайхан сэтглэлтэй биш, тун ч харамч, төрийн их харгис албатан байв. Тэрээр жаран хоёр настайдаа өөд болж, Эрлэгийн

Хаантай уулзжээ. Эрлэгийн Хaan Formosagийнх бөгөөд нэг талаар хачин өвөрмөц, биеийнх нь зүүн тал нь хар, баруун тал нь цагаан. Яагаад юм бүү мэд. (Инээлдэв)

Тэгээд Эрлэг Хaan түүний үхэхэсээ өмнө хийсэн нүгэл, буяныг нь харахаар сайн, мууг дэнслэгч номоо харж гэнэ. Тэгээд түүнийг маш их нүгэл хийсэн, дээр нь ямар ч өглөг өгч байгаагүйг нь олж харжээ. Ляо Ху хэзээ ч дүрвэгсдийг хамгаалж, Хонг Конг-т ирж байгаагүй аж. (Инээлдэв) Дээр нь сүм хийдэд ямар ч өргөл өргөж байгаагүй төдийгүй, очиж ч байгаагүй ажээ. Це-чи болон бусад буяны байгууллага хийгээд ядуу гүйлгачдад ер сохор зоос ч өгч байсангүй.

Ляо Ху ургамал хоолтон байгаагүй, гэхдээ тэр мах иддэггүй байж, учир нь тун харамч нарийн болохоор тэр. Гэгээнтэн болохыг хүссэндээ мах иддэггүй байсан юм биш. Би та нарт ургамал хоолтон байх нь таныг гэгээнтэн болгохгүй гэж хэлсэн шүү дээ. Энэ бол таны зорилгоос л хамаарах асуудал. Тэрээр гэрийнхэндээ мах худалдаж авч, мөнгө үрэхийг хүсдэггүй байсан болохоор л мах иддэггүй байжээ. Заримдаа мах идэх гэж тэсгэлгүй хүсэхээрээ угаалгын өрөөндөө нуугдан зүсэм мах идчихдэг байжээ. Идчихээд гараад ирэхэд нь гэрийнхэн мэддэггүй байжээ. Ямар олигтгүй хүн болох нь харагдаж байгаа биз дээ.

Тэр хэзээ ч Их Багш Чин Хайн лекцэнд очиж байсангүй. (Инээлдэв) Энэ мэтчилэн Эрлэгийн Хaan түүнийг аврах юу ч олж харсангүй. Ямар ч буян харагдахгүй, дан нүгэл л байгаад байж гэнэ. Бүр нэг удаа Их Багш Чин Хайн шавь түүнд үнэгүй тараадаг үлгэр дэвтрээ өгөх гэж оролдсон ч тэрээр дэлгүүр орох гэж байна,

цүнхэнд зай алга гээд аваагүй аж. (Инээлдэв) Ийм хүнийг хэн яаж аврах билээ?

Ингээд Эрлэгийн Хаан хэлсэн нь: “Хэрэг алга! Больё! Больё! Ганц гайгүй юм олох гэж хамаг чадлаараа хичээлээ. Гэвч бөөн хар нүглээс өөр юу ч алга. Одоо чамд морь болон төрж, нүглээ цайруулахаас өөр арга алга” гэжээ.

Ингэж хэлээд гар хөлийн чагж хийн өшиглөтөл Ляо Ху унахдаа морь болон төржээ. Тэр морины үнэмлэх дээр өөрийнх нь нэр байсан аж. Ингэж л Ляо Хугийн хойд дүр гэдгийг мэдсэн байна.

Ляо Ху хэмээх энэ морь улам бүр өсөж томроод л байж. Тэр их өвс иддэг бөгөөд үүндээ ч сэтгэл хангалуун байдаг байв. Өнгөрсөн амьдралдаа ч тэрээр мах худалдаж авах байтугай дүүфүү ч авахыг хүсдэггүй, зөвхөн ногоо иддэг байж, тэгээд л боллоо. Үүндээ ч тэр сэтгэл ханамжтай байдаг байсан, ногоо иддэгтээ хэзээ ч гомдоллодоггүй байж, түүнээс гадна энэ бүхэн үнэгүй шүү! Морь болсон хэдий ч тэр бас маш харамч гэнэ. Нэн хямд төсөр хооллоно. Өөрөө өмхөрсөн өвс идээд харин шинэ өвсөө хадгалж байгаад бусад мориндоо зардаг байлаа. (Инээлдэв)

Түүнийг өсөж томрох
үед эзэн нь ажилд тавив.
Энэ нь тулээ тулш, хоолны
тос, цагаан будаа гэх зэрэг
гэр оронд шаардлагатай
зүйлийг зөөх ажил юм.
Заримдаа тэрэг дүүрэн
дөч, тавин тарган хүнийг
чирэх болно. Аа, яа, яа.
Үүнийг тэвчихийн аргагүй.
Гэтэл явахгүй зогсчих
юм бол тэрэгч нь түүнийг
ташуурдана. Тэр энэ бүх
байдлыг үзэн ядаж, цаашид
тэвчиж чадахааргүй
болжээ. Тэр морин тэрэгчин



ч гэсэн өөдгүй амьтан. Тэднийг өшиглөмөөр, ташуурдмаар, харгис хэрцгий хандмаар санагдана. Урьд нь мань хүнийг морь унадаг байхад эмээл байдаггүй байсан нь тун тоогүй, биед тааламжгүй төдийгүй, морийг ч зовоодог ажээ. Энэ морь бол хүн байснаа эргэж төрөхдөө морь болсон. Иймд мэдээж морь болохдоо хүний зан авир нь тодорхой хэмжээгээр дамжсан байна. Ингээд маш

ур уцаартай, нэн гунигтай болж, эцэст нь өлсгөлөн зарлав. Тэр идэхээ болсноосоо хойш гурав, дөрөв хоногийн дараа ухэв. Сума Чин Хайн хэсэг шавь өрөвдсөндөө түүнд зориулж, ариун судар уншиж, Халейлуяа-г аялгуулж, түүний төлөө залбирчээ. Гэвч түүний үйлийн үр яаж ч байсан хэтэрхий хүнд байсан учраас тэр доош явж, Эрлэгийн Хаанд бараалхсан байна.

Эрлэгийн Хаан ууртай байсан бөгөөд түүн лүү: “Чи өөрийн муу үйлээс зугтахыг оролдож байна уу? Чи чадна гэж үү? Үгүй ээ, чи чадахгүй. Хэрэв би чамайг морь болгохыг хүссэн л бол чи морь л болно, хэрэв чамайг нохой болгохыг хүсвэл чи нохой л болно гэж би чамд хэлсэн шүү дээ. Чи энэ замаас мултарч чадахгүй. Чи муу үйлийнхээ төлөөсийг бүрэн төлж дуусахаас нааш буцах газаргүй гэдгээ одоо болтол ойлгохгүй байна уу?” гэж бархирчээ.

Эрлэг Хаан түүнийг загнасаар байтал нүүр нь мэнчийсэн улаан болов. “Чи намайг залилах гэж байна. Чи дээшээ явах цаг болоогүй, чиний үйл түйтгэр бүрэн төлөгдөөгүй, одоо чи яваад төрөл арилжихын тулд өөрийгөө өлбөрүүлнэ гэж бодож байгаа биз. Энэ чинь залилан.”

Ингээд Эрлэг Хаан түүнийг нохой болгожээ. Түүн лүү гараараа дохин өшиглөжээ. Тэгтэл мань хүн эх нохойны хэвлэйд байгаагаа мэдэрсэн бөгөөд удалгүй эхээсээ мэндлэв.

Хэдийгээр тэр нохой болсон ч Ляо Ху-гийн бага ч атугай оюун ухаан, мөн хүний шинж чанар хадгалагдаар байж... Тэр ихэд гуниглаж, ундууцаж, нэн золгүй, түгшсэн, дарамттай, арчаагүй, хүчгүй, залхсан (хятад хэлээр түүний Ху, Ляо нэртэй нь төстэй сонсогддог) байдлаа мэдэрч байв. (Багш болон бүгд инээлдэв.) Гэвч дахин амия хорлох явдал гаргаж зүрхлэхгүй. Эрлэгийн Хаан түүнийг бүр хүндээр шийтгэнэ гэдгийг тэр мэдэж байгаа.

Тэр суугаад бодсон нь: “Би одоо өөрийгөө өлбөрүүлж чадахгүй! Хэдийгээр энэ нохойн хоол үнэхээр дургүй хүрэм боловч түүнийг идэх л ёстой. Түүнээс гадна Эрлэг Хаан намайг өөрөөр яаж шийтгэхийг би мэдэхгүй байна!”

Тэр нохойн ухаанаараа бодоод л, бодоод л байж... Тэгтэл, Аан! Гэнэт тэр ухаарлаа! Тэр өөртөө хэлсэн нь: ”Хэрэв одоо би, эзнийгээ чанга хазчихвал тэр намайг ална. Ха! (Багш болон бүгд инээлдэв.) Би ингэж л амия хорлосон хэрэг үйлдэлгүйгээр үхнэ!”


Шуудхан л эхлэхээр болов. Тэгээд ариун судраас уншив. “Да, да, да, да, да....”. Өөрийгөө чөлөөлөх төлөвлөгөөний дагуу эзнийгээ эргэж ирэхийг түр хүлээх хэрэгтэй. Тамхia татаж, юм уусныхаа дараа эзэн нь буцан ирж байна. Нохой сүүлээ годгонуулж

байснаа эзнийгээ урд, хойноос нь хазчихав. Энэ нь түүнийг өвтгөж, тэр бас учихсан /архи/ байснаас их уурлаж, том цохиур аваад цохичхов. Тэр нохой ингээд дуусжээ.

Тэр дахиад л Эрлэгийн Вант улсад ирэв. Эрлэгийн Хaan ухаангүй уурлаж, мэдээж түүнийг дахиад хатуу ширүүнээр загнав. “Чи муу нохой. Чи намайг дахин залилах гэж яж зүрхэнэ вэ? Одоо хмм, чамайг эхлээд тавь ташуурдана даа.”

Ташуурдуулсныхаа дараа тэр могой болж төржээ. Бурхан минь! Нохой байх нь тийм ч муу байсангүй, гэтэл могой байх нь үнэхээр зовууртай ажээ. Тэр оргохыг хичээх тусам бүр муугаар эргэсээр... Нэгэнт могой болчихлоо, Эрлэгийн Хaan газар доорх шоронд түүнийг хаячхаад цоожилчихлоо л гэсэн үг, хаашаа ч гарах гарцгүй. Тийм боловч тэр ямар нэг цоорхой олж мултрахдаа чадамгай билээ. Одоо тэр амиа хорлох явдал гаргаж болохгүй, бусдыг хазаж бүр ч болохгүй, одоо зөвхөн бүр их гэмших л үлдлээ. Ийнхүү тэр могойн ухаанаар бодоод л, бодоод л... эцэст нь тэр шийдэмгийгээр мөлхөж, замын голд очоод хэвтчихэв, удалгүй унтлаа. (Багш болон бүгд инээлдэв) Тэр хүн санаа оноогоор дүүрэн ажээ. Орой болтол замын голд унтсаар! Энэ гудамж дээр үеэс л гэрэлгүй байсан. Ингээд түүгээр нэг машин явж байгаад түүнийг хэдэн хэсэг болгоод тасалчихлаа, тэр чөлөөлөгдлөө!

Түүний өрөвдөм байдлыг хараад Эрлэгийн Хaan шийтгэлийг нь хангалттай гэж үзжээ. Эцэст нь тэр ялалт байгууллаа! Эрлэгийн Хаанд түүний зовлон болон харамч нарийн байдал нь хөөрхийлөлтэй санагдаж, нэмж шийтгэл оногдуулахгүй байхаар болов. Аах! Эцэстээ энэ бүхний дараа Эрлэгийн Хaan нэлээд энэрэнгүй болсон байна. Тэр лав Арьяабалын бясалгалын аргаар бясалгадаг байж таараа. Хагас хугасхан, хатуу ширүүний хажуугаар зөөлөн сэтгэл. Яагаад түүний тал нь хар, тал нь цагаан байдгийн учир нь энэ! (Инээлдэв) Тэгээд тэр өршөөж, хүн болж төрөхийг зөвшөөрлөө.



Тэр дахиад засгийн газрын түшмэл болжээ. Гэвч Эрлэгийн Хаан түүнд, өөрийн хүмүүсээ элгэмсүү, сайн санаатай, ухаалгаар удирдаж, ачтай буянтай байхыг сануулжээ. Тэр ёс суртахунаар ялзарсан, бас хомхой шунахай байж болохгүй, мөн хүмүүстэй зүй бусаар харилцахгүй, харгис хэрцгий байж болохгүй. “Өөрөөр байвал”, Эрлэгийн Хаан түүнд урьдчилан сануулсан нь: “Чамайг өршөөхгүй шүү! Чи бас таван сахилыг сахих ёстой!” гэжээ.

Тэр ч байтугай Төгс Гэгээрсэн Их Баш Чин Хайг олж, авшиг хүрт гэж түүнд хэлсэн гэнэ! (Алга ташилт) Тоглосон юм! Ийм төрлийн хүмүүсийг аврах их хэцүү. Тэр бидэн рүү ирэхгүй байсан нь хамаагүй дээр!

Хэдий тийм боловч тэр үнэхээр Түүнийг олоод ирвэл, түүнд таван сахил сахих, ургамал хоолтон болох, өдөр болгон хоёр цаг хагас бясалгах, нийтийн бясалгалаid оролцох, үнэний төлөө тэмцэх зэрэг энэ бүгдийг зааж өгөх болно. Түүнээс хойш (хүн болоод) тэр үнэхээр сайн хүн байж, хожим нь засгийн газрын түшмэл, их буянтай түшмэл болжээ. Тэгээд захирагдагдаа мориндоо эмээл хий, морьдоо өшигчиж, давирч, дэндүү чанга ташуурдаахаа болихыг захижээ. Яагаад гэвэл тэр морины зовлонг сайн ойлгосон хэрэг, мөн маш өглөгч, эелдэг хүн болжээ, ингэснээрээ түүний бүх муу үйл түйтгэр нь арилсан байна.

БИЛИГ УХААН ҮГҮЙ ИД ШИДИЙН ХҮЧНИЙ АЮУЛ

Э нэ бол Их Багшаас суралцахыг хүсэн тэмүүлсэн хэсэг сурагчийн тухай өөр нэг үлгэр. Тэр Их Багш нь маш их ид шидийн хүчтэй учир тэд түүнээс нь жаахан сурч авахыг хүссэн байжээ. Гэвч Их Багш нь тэднийг ид шидийн хүч эзэмшихэд бэлэн биш байна гээд үргэлж л татгалзаад, татгалзаад л байдаг байв. Сайн санаа болон билиг ухаан үгүйгээр оюун ухааны хүчийг эзэмшвэл маш аюултай. Гэвч шавь нар нь энэ бүхнийг сонсохыг ч хүсдэггүй байлаа. Тэд Их Багшийнхаа янз бүрийн гайхамшигт үзүүлбэр үйлдэхийг хараад багахан хэсгийг нь ч атугай эзэмшихийг хүсжээ. Ялангуяа хүсэн хүнийг дахин амилуулан босгож байгаа нэг үзүүлбэрийг бүр их сонирхдог байжээ. Тэгээд Их Багшаасаа цаг үргэлж шалсаар байж. Нэг өдөр Их Багш нь хүсэн хүнийг буцаан амилуулах нууц аргаа зааж өгчээ.

Шинэ нээлт олж авсандаа тэд маш баяртай байж. Хүсэж тэмүүлсэн бүх зүйл нь энэгэж бодсоноос тэр доороол Их Багшийгаа орхиод явчихжээ. Тэгээд хамтдаа өөр нэг газар луу одож гэнэ. Аялсаар яваад нэг зэлүүд газар ирэв. Хэдэн зуун жилийн турш энд нэг ч хүн амьдраагүй бололтой. Зам дээр хэсэг яс байхыг хараад шинэ сурсан эрдмээ хэр хүчтэйг туршиж үзэхийг хүслээ.



Тэгээд гар хөлөө хөдөлгөн дохиж, чагж хийгээд бла, бла, бла гэх шиг юм үглэв. Гэнэт бүх яс агаарт нисэж, өөр хоорондоо шигдэн наалдаж, амьд амьтны жинхэнэ дүр төрх болон хэлбэржив. Биенд нь мах, соёо, эвэрлэг хайрс буцан ирж, ахин урган төлжлөө. Хэчинээн сая жилийн өмнөх үлэг гүрвэл бий болсон нь энэ. Энэ нь амьтан аварга том байлаа. Тэр араас нь хөөсөөр барьж идсэнээр тэд ангижирчээ.

Энэ бол бусдыг сохроор дуурайхын хор уригийн нэг жишиг юм.

Жинхэнэ гэгээрсэн хүний билиг ухаан үгүйгээр өөрсдийнхөө сониуч занд хяналт тавих чадвар үгүйгээр, бусдад таны тусламж хэрэгтэй яг тэр ашианд тусалдаг байх нийгүүлсэнгүй сэтгэл үгүйгээр, сониуч зангаасаа, эсвэл өөрийн хүч чадлаа үзүүлэх хүслээсээ болоод Их Багши нарыг дуурайх нь маш аюултай. Манай сүнслэг дадалд хүмүүсийг ид шидийн хүч хэрэглэхийг бид өөгшүүлж болохгүй гэдгийн учир нь энэ. Та нар улам сайн болоод ямар нэг юм мэддэг болболж түүнийгээ хэрэглэхгүй байсан нь дээр.

Энэ бол орчлонгийн хүчинээс зээлж байгаа очижүүхэн жсаахан хэсэг болохоос дээд түвшиний хүчтэй холбогдсон юм биш гэж би та нарт аль хэдийн хэлсэн. Тэгээд ч доод түвшинөөс зээлсэн бүхнээ та нар хүүтэй нь хамт буцааж төлөх ёстой. Хэрэв та нар энэ хүч чадлыг хамгийн дээд түвшинөөс, хамгийн дээд хүчин буюу дээд билиг ухаантай холбогдон түүнээс хүртсэн бол л энэ нь та нарт хамаарна. Бурханы хүчинд хамаарна, тэгээд та нар буцааж төлөх шаардлагагүй болно.

Нэгэн Их Багши байжээ, нэрийг нь би мэдэхгүй. Тэр хөгширч, ихэд өтөлжсээ. Тэгээд мэдээж наснаасаа болж, нүд нь бүрэлзэж, хараа нь муудаад, шавь нараа ч танихгүй, орчин тойрныхоо юуг ч харахгүй болжээ. Нэгэн далдын хүчтэй домч (заримдаа гараа хургээд л эмчилчихдэг тийм домч нар байдаг, түүнтэй адил) Их Багшид хэлсэн нь: "Та над руу хүрээд ир, өөрийгөө надад даатгачихвал би нүдийг чинь эмчилж, дахин хардаг болгож чадна" гэхэд Их Багши хэлсэн нь: "Үгүй, үгүй, би өөртөө хэрэгтэй бүхнээ хардаг, дотооддоо хардаг. Өөр юм ерөөсөө хэрэггүй" гэжээ.

Энэ нь аль ч оюун ухааны дадалтнуудын хувьд зөв хандлага шүү. Бидний хувьд ид шидийн домнох аргад, увдис шидийн хүчинд, бас тав тухтай байдлын бүх зүйлд хэзээ ч шунаж болохгүй. Энэ бүхэн нь түр зуурын, бага зэрэг сэтгэл тайтгаруулсан явдал болоод л өнгөрнө, тэгээд буцааж эргэнэ, бид их юмыг огоорох хэрэгтэй. Энэ гурван өртөнц дотор үнэгүй юм гэж юу ч үгүй. Зөвхөн тавдугаар өртөнцөд л бүх юм элбэг дэлбэг, үнэ төлбөргүй байдаг. Энэ өртөнцөд болон гурван өртөнцөд бүх юм өөр, бүгд материаллаг зүйлээр хийгдсэн. Хэрэв бид өөртөө дэндүү их зүйл авах юм бол өөр хaa нэгтээ хомсдолд орж байдаг. Тиймээс ид шидийн хүч нь хaa нэг газраас ямар нэг зүйлийг авч, түүнийг өөр газар руу хүргэхээс өөр зүйл биш юм.



ШУНАЛЫН ТУЛАМ


Д нэ бол Ау-Лак үлгэр. Олон жилийн өмнө нэгэн ядуу гэр бүл байжээ. Эцэг, эх нь нас барагдаа хоёр хүүдээ жижиг аж ахуй, бага сага хөрөнгө үлдээсэн байна. Ах нь сэргэлэн, илүү зальжин, бас энэ амьдралын тогтолцоог сайн мэддэг. Харин дүү нь тийм ч их ухаалаг бус боловч сайхан сэтгэлтэй, цайлган бөгөөд сүсэг бишрэлтэй юм гэнэ. Тэд эцэг, эхээ нас барсны дараа өмч хөрөнгөө хувааж эхлэв.

Ах нь гэрлэсэн, дүү нь харин ганц бие байжээ. Ах нь дүүдээ: “Энэ өмч хөрөнгийг харж хандах асуудлыг надад даалгасан нь илүү дээр. Одоо чи эхнэр хүүхэдгүй, бас өмч хөрөнгөндөө анхаарал тавьж мэдэхгүй учир чамд өгөх нь ашиггүй. Хэдий тийм боловч эдүгээг хүртэл чи их сайн дүү байсныг би мэдэх учраас чамд Од жимсний мод өгье. Од жимсний мод байгаа тэр булан бол чинийх, өмч хөрөнгөний үлдсэн нь бүгд минийх шүү. Тийм биз?” гэжээ.

Дүү нь ”Тийм ээ” л гэж. (Инээлдэв)

Ингээд ах нь өдөр бүр аж ахуйдаа ажиллаж, баяжиж чинээлэгжин сайхан амьдрах болжээ. Дүү нь ч гэсэн од жимсний модоо арчлан өөртөө л боломжийн амьдрах болжээ. Од жимс боловсорч гүйцхэд түүж аваад зарна. Тэр мод зэгсэн том тул

хангалттай их жимс өгнө. Хэрэв бүгдийг нь зарж чадахгүй бол үлдсэнийг нь буцааж авчраад од жимсний шүүс хийнэ, бас нөөшилнө. Тэр тун овсгоотой ажиллаж байлаа. Зарим жимсээ чихртэй, заримыг нь давсанд, эсвэл цагаан цуунд нөөшилдөг. Тэрээр од жимсний бүтээгдэхүүнээ олон төрлөөр нь хийсэн нь маш их алдаршжээ. Олон хүн түүнд нь дуртай болж, хүмүүс худалдан авахын тулд холоос ирнэ. Нэг угзэр хэлбэл, өөртөө боломжийн мөнгө олдог болж, аятай тухтай, сэтгэл хангалуун амьдарч байлаа. Маш баян болоогүй ч тухайн амьдралдаа үнэхээр сэтгэл ханамжтай байжээ.



Нэг өдөр од жимсээ нөөшлөхөд хэрэгтэй бага сага юм худалдаж авахаар гадагш яваад гэртээ буцаж ирэхэд нь жимснийх нь бараг хагасыг нь идчихсэн байжээ. Тэр үнэхээр харамсав. Тэгээд, модон дээр суугаад од жимсийг нь идсээр байгаа хэрэг харлаа. “Уухай” гэж уулга алдаад: “Энэ яаж чадаж байна аа” гэж бодоод хэрээнээс асуусан нь: “Чи яагаад миний од жимсийг идэж байгаа юм бэ?” гэхэд

Хэрэе: “Би өлсөж байна”. (Инээлдэв) Энэ бол үнэхээр энгийн зүйл. Хэрээ өлсөж байсан учраас л идсэн хэрэг. Хэрээг “Чи өлссөн үедээ иддэггүй гэж үү?” гэж асуухад

Тэр: “Мэдээж иддэг” гэв.

“Тэгвэл чи яагаад надаас асуугаад байгаа юм бэ?”

Тэр залуу хүү бол дүйнгэдүү хүн байсан учраас үгнээс нь зөрөх ухаанаа ч олсонгүй, ингээд бага зэрэг алмайрчээ. Тэгснээ бодож байнаа: “Мэдээж, хэрээ өлсөж байгаа юм чинь идэлгүй яах вэ. Би яагаад ингэж асуув аа? (Багш болон бүгд инээлдэв) Хэдий тийм ч энэ мод бол надад байгаа ганц өмч. Хэрэв үүнийг идчихвэл би дууслаа, идэх юмгүй болж, маргааш гэхэд л өлсгөлөнд нэрвэгдэх нь”.

Тэгээд энэ тухайгаа хэрээнд хэлжээ.

Тэр хэрээ бол тун жигтэй шувуу аж. Ердийн нэг хэрээтэй адилгүй. Хошуу нь их урт, (Хүмүүс инээлдэв) ер нь хэрээ чихгүй байдаг шүү дээ, гэтэл тэр хэрээ том чихтэйгээр барахгүй, түүнээс нь ээмэг санжигнаж байдаг гээч. (Багш болон бүгд инээлдэв) Өд

нь ч гэсэн буржгар бөгөөд их дэгжин. Өд сөд нь тун үзэсгэлэнтэй, хэдийгээр тэр хэрээ боловч элдэв өнгөөр солонгорон байх юм гэнэ.

Нөгөө залуу хүү маань хэрээнд: “Од жимсээ би танаас нарийлсандаа ингэж байгаа юм биш, мэдээж та өлсөж байгаа үедээ идэлгүй яах вэ. Та идэж байгаарай. Тийм боловч ний нуугүй хэлэхэд эцэг, эхийг маань нас барсны дараа ах минь надад зөвхөн энэ модыг л үлдээсэн юм. Энэ модгүйгээр би үхнэ. Энэ бол миний үнэн байдал. Би танаас од жимсээ харамласандаа ингээгүй юм шүү” гэж хэлжээ.

Үүнийг сонсоод хэрээ уярч: “За яах вэ. Чи сайн хүн шиг байна. Бүх юм сайхан болно, бүгд сайхан. Энэ бол асуудал биш. Нэгэнт би чиний од жимсийг идсэнээс хойш түүнийг чинь алтаар төлөх болно. Ингэвэл бүх юм сайн болно биз?” гэв.

Тэгэхэд нь залуу хүү: “Тийм” гэв. (Багш болон бүгд инээлдэв)

Тэр зөвхөн “За”, эсвэл “Тийм” гэхээс өөр юу ч хэлдэггүй, хүмүүст татгалзаж чаддаггүй юм.

Ингэтэл хэрээ түүнд: “Маргааш өглөө эрт, гурван цагт би энд чамайг авахаар ирнэ. Одоо чи гэртээ харьж, ам даавуу олоод ийм урттай, ийм өргөнтэй том уут оё. Маргааш сувд, үнэт чулуу, алт олж ирэхээр чамайг авч явах болно” гэжээ.

“За” гээд залуу хүү гэртээ харьж, яг түүний хэлснээр урт, өргөн нь тийм, том уут хийжээ, илүү ч үгүй, дутуу ч үгүй.

Маргааш өглөө нь хэрээ амласнаараа нөгөө газраа түүнийг хүлээж байв. Хэрээ хэлсэн нь: “За сайн байна. Одоо миний нуруун дээр гар. Би чамайг аваад далайг хөндлөн нисэж гаргах болно. Нисэж явахад чи ярьж болохгүй, нүдээ нээж болохгүй шүү. Юу ч тохиолдсон хамаагүй, миний үгнээс зөрөх юм бол чи амьд үлдэхгүй”. Залуу хүү: “За” л гэжээ.

Хэрээний нуруун дээр гарч, хүзүүнээс нь зуурсны дараа хэрээ нислээ. Гэнэтхэн хэрээ асар том болчож гэнэ. Залуу хүү нуруун дээр нь тохь тухтай байсан төдийгүй, нойронд автжээ. Тэр тэнд Арьяабалын бясалгал хийсэн ч асуудалгүй. (Хүмүүс инээлдэв) Гэвч тэр аялгуу ажаагүй, зөвхөн гэрэл ажиж чаджээ.



Сүнслэг бясалгагчид бид асуугаагүй л бол ярих хэрэггүй. Түүнээс гадна бид “За”, эсвэл “Тийм” гэхээс өөр юу ч хэлэх хэрэггүй. Библиод бас үүнтэй адил зүйл хэлсэн нь: Асуувал та нар зөвхөн “За”, эсвэл “Тийм” л гэж хэлэх хэрэгтэй гэсэн байдаг. Та нар хэрэгцээгүй зүйл ярих хэрэггүй. Энэ юу гэсэн уг вэ? гэхээр уг хэлээ хямгадаж, ярихгүй байх хэрэгтэй гэсэн уг.

Тэр zaluu хүү Арьяабалын аргаар бясалгаж, их сайн болсон байж. Ярихгүй л гэсэн бол ярихгүй. Товчоор хэлэхэд тэр бясалгаж эхэлснийхээ дараа самадид оржээ. Тэгээд зорьсон газраа ирлээ.

Хөөх. Тэр газар бол далайн давлагаяа цохилсон үзэсгэлэнт уул байсан бөгөөд төрөл төрлийн сувд, үнэт чулуу аварга том ууланд овоолоостой аж. Модод болон бүх зүйл нь сувд, үнэт чулуугаар хийгдсэн. Тодруулбал, мод нь алтаар, мөчир нь сувд, үнэт чулуугаар хийгдсэн аж. Юм болгон нь сувд, үнэт чулуу. Тэнд ямар ч “ердийн” чулуу байхгүй, зөвхөн сувд, үнэт чулуу.

Тэгээд хэрээ хэлсэн нь: “Одоо чи дуртай сувд, үнэт чулуугаа түүгээд уутал. Тэгээд хоёулаа хурдхан шиг гэр лүүгээ буцъя”.

Залуу хүү: “За” л гэсэн байна. Тэр дуртай буюу илүү үнэтэй зүйлсийг нь ууталж аваад түүнийгээ бүсэндээ хавчуулан хэрээний нуруун дээр үсрэн суув. Хэрээтэй буцаж нисэх үед нүдээ анин дахин бясалгалаа. Тэгээд самадид орж, удаа ч үгүй гэртээ иржээ.

Энэ өдрөөс хойш zaluu хүү баян болжээ. Сувд, үнэт чулуугаа зарж, шинэ байшин барьж, үзэсгэлэнтэй бүсгүйтэй гэрлэж, тэр байтугай хөөрхөн үрсээ өсгөн бойжуулав. (Инээлдэв) Тэр их тав тухтай амьдарч гэнэ ээ.

Үүнээс хойш нэлээд хугацааны дараа дүүгээ гэнэт их баяжсаныг сонсоод ах нь их хол газраас тэднийд зочлон ирэв. Ах нь тэгээд дүүгээсээ яаж ингэж гэнэт баяжсаныг асуухад, дүү нь: “За, би хэлье. Энэ бол таны ач буянаар болсон юм. Энэ бүгд таны ерөөлөөр болсон. Та л надад тэр од жимсний модыг өгснөөс би ийм баян болсон. Танд баярлалаа, ах аа”.

Тэгээд тэр ахыгаа хүндэтгэн мөргөжээ.

Ах нь асуусан нь: “Од жимсний мод яаж чамайг баян болгосон юм бэ?”

Дүү нь болсон бүх явдлаа нэг бүрчлэн ярьсан нь мэдээж.

Тэгж таарна. Ахынх нь шунал хөдөлж, “Аа хaa. Энэ миний буянаар болсон нь тодорхой, за яах вэ, одоо чи миний газар луу амьдрахаар нүүх хэрэгтэй. Тэр өв хөрөнгө бүгд чинийх боллоо. Энэ од жимсний мод минийх, (Багш болон бүгд инээлдэв)

хоёулаа одоо солигдьё. Чи жимсний модыг өөртөө дэндүү удаан байлгалаа. Би одоо чамд халаагаа өгөх болсон. Яагаад гэхээр бид хоёулаа л эцэг, эхийнхээ өв хөрөнгийг ээлжилж анхаарах ёстой. Би олон жил үүнд санаа тавьсаар ядарчээ. Одоо чиний ээлж. Чи тийшээ буц. Одоо би од жимсний модонд санаа тавина. За юу?” гэжээ.

Дүү нь: ”За” л гэжээ.

Ингээд дүү нь ахынхаа газар луу нүүжээ.

Харин ах нь дүүжин ор бэхэлж аваад од жимсний модон доор өдөр бүр хүлээдэг ажилтай болж. Хүлээж байснаар нь нэг өдөр хэрээ ирээд од жимсийг нь идчихжээ. Тэгэхэд нь тэр уурласан дүр үзүүлж хэлсэн нь: “Та миний од жимсийг идчихээр би өлбөрч үхэх болно шүү дээ”, тэгээд цааш нь дүүгээ дуурайж, хэлсэн бүгдийг нь урсгав.

Тэгтэл ч хэрээ: “Асуудал үгүй. Нэгэнт л би чиний од жимсийг идчихсэн юм чинь түүнийг алтаар төлөх болно. Болж байна уу?”

“Болж байна” гэж тэр хэлэв.

Тэгээд хэрээ хэлсэн нь: “Үүрээр, гурван цагт энэ газраа намайг хүлээж бай. Ирэхдээ ийм урт, ийм өргөнтэй том уут оёж авчир. Тэгээд би чамайг авч яван сувд, үнэт чулуу, алт түүж авна”.

Ах нь даруй гэртээ очоод даавуу хайчилж гарав. Гэхдээ тэр нь Арьяабалын орхимж нөмрөг шиг хэмжээтэй байжээ. (Багш болон бүгд инээлдэв) Энэ нь яг ийм урт, ийм өргөнтэй байж л дээ. Хоёр хэсгээ хамтад нь давхарлаад очихсон чинь тийм том болчихжээ. Тэр хэлснийг нь бүрэн дүүрэн ашигласан байна. (Сонсогчид инээлдэв) Тийм том уут оёчхож.

Аах! Тэр үүрийн хоёр цагт очоод хүлээв. Хэдийгээр хэрээ эрт ирээгүй ч яг цагтаа л иржээ. Яг л гурван цагт хэрээ түүнийг авахаар ирсэн байна. Ингээд хэрээний нуруун дээр гарлаа. Хэрээ түүнд хүзүүнээс нь барьж, дуугарч болохгүй, нүдээ нээж болохгүй гэж хэлэв.

Зүгээр шүү дээ. Гэтэл нөгөө ах хүүд нь их хэцүү байжээ. Тэр бясалгал хийдэггүй, ургамал хоолтон биш. Иймд үлийн үр нь их хүнд байжээ. Хэрээнд далайг хөндлөн нисэхэд маш хэцүү байлаа. Хэрээ ид шидийнхээ хүчийг хэрэглэснээр байдал арай дээрдэв. Залууд “Хү! Хү! Хү!” гэх сонсогдож, бас хэрээний далавчны хүчтэй дэвэх нь мэдрэгдэж байв. Удтал ниссэний дараа тэр бараг гуйж: “Бид хүрэх арай болоогүй юм уу?” гэв. (Багш инээв) Аз болоход хэрээ далавчаараа түүнийг алгадаахад тэр ухаарч, хэрээний хэлснийг санаад дахиж нэг ч юм асуусангүй.

Эцэст нь тэр ирлээ. Ашгүй! Энэ маш урт аялал шиг санагджээ. Хэрээнд ч гэсэн их уdsan шиг санагдсан байна. Хоёулаа ядарчээ. Хэрээ түүнийг доош буулгасны дараа даруйхан дугхийхээр явлаа. “Чи дуртай сувд, үnэт чулуугаа түүж аваарай. Би чамайг буцааж авч явахын өмнө дугхийгээд авья. Өөрийгөө ийм хүнд болгохоор юу идсэн юм бэ? Чи заан жилд төрсөн үү?” (Инээлдэв)

Бид бүгд л морь ч юм уу, хулгана ч юм уу, аль нэг жилд төрдөг байтал тэр заан жилд төрсөн бололтой. Түүний үйлийн үр илүү хүнд ч байсан байж магадгүй. (Инээлдэв) Хэрээг зүүрмэглэсний дараа мань залуу сувд, үnэт чулуунуудыг түүгээд барахгүй байлаа. Хэдий тийм ч тэр нүдээ гялалзуулан харна. Бүгдийг нь авмаар байжээ. Тэр энэнээс ч, тэрнээс ч салахыг хүсэхгүй байв. Шилж сонгосоор очиоён удаан хугацаа өнгөрсөн ч дуусдаггүй.

Эцэст нь хэрээ сэргж хэлсэн нь: “Чи дуусаагүй л байна уу? Одоохон юмаа ав. Цаг боллоо. Бид энд үүнээс илүү удаан байж болохгүй. Хэрэв энд удвал гэртээ харьж чадахгүй болно. Хурдхан нуруун дээр гар” гэв.

Энэ үед тэр маш түргэн хөдөлж, уутандаа гартаа тааралдсан болгоныг хийв. За яах вэ! Гэтэл уут нь дэндүү хүнд байснаас хэрээний нуруун дээр авч гарахад хэцүү болжээ. Хэрээ хэлсэн нь: “Үгүй ээ, энэ чинь хэтэрхий хүнд байна. Чи заримыг нь гаргаж хаях хэрэгтэй. Эсвэл нисэж чадахгүй нь” гэлээ.

Залуу их шуналтай учир ганц сувд гаргаж хаяв.

Хэрээ: “Үгүй, үгүй. Энэ чинь хангалтгүй, бүр ихийг гаргаж хая” гэв.

Гэтэл тэр бас нэг сувд гарган доош шидээд

“Бол oo!” гэв. Хэрээ: ”Үгүй! Хэрэв чи арай ихийг гаргаж хаяхгүй бол бид нисэж чадахгүй. Би одоо нисэж чадахгүй нь” гэжээ.

Залуу үнэндээ тэднээсээ салмаарагүй байсан ч ямар ч гэсэн нэг атгыг гаргаж хаяв. Тэгэхэд хэрээ: “Бид энд илүү удаан байж болохгүй! Явах хэрэгтэй байна. Цаг боллоо”.


Хэрээ нисэх гэж асар ихээр зүтгэн чармайв. Тэдний замд доогуур нь давлагаалах давлагаанаас өөр хараа тусах газар юу ч үгүй байлаа. Гэтэл хар салхи ойртон ирж, дэндүү ширүүн байснаас хэрээ далавчaa тэнцүүлэхэд хэцүү болов. Тэнцвэрээ хадгалах гэж байдгаараа хичээж, далавчиндаа их хүчтэй байсан ч салхины хүч, ачааны хүндээс ганхаж тогтвортгүй болов.

Тэгэхэд нь залуу: “Хэрэв та ийм байдлаар нисээд байвал

би үхэх нь. Та одоо яагаад байна аа?” гэв. Тэгээд тэр нүдээ нээгээд: “Хөөх! Далайг ээ!”

Түүнийг нүд, амаа нээнгүүт гараас нь сувд, үнэт чулуу нь мултран уналаа. Залуу болон сувд, үнэт чулуунууд хамтдаа доош унажээ.

Тэр хэрээ тийм урттай, ийм өргөнтэй уут хий гэж хэлсэн боловч дэндүү томыг хийсний уригаар хэрээ хүнд ачаанд дийлдэх нь мэдээж шүү дээ. Хүмүүс бид энэ ах хуутэй төстэй төрөлтөн. Бид хэмт их шуналаасаа, заримдаа ямар ч хэрэгцээгүй зүйлээс болж дуусдаг билээ.



ЭНЭ БОЛ ХӨЛ ТОЛГОЙГОО АЛДСАН ЕРТӨНЦ

Ж эг шавьтай агуу гэгээрсэн Багш байжээ. Шавь нь түүнийг дагах болсноор нэг их удаагүй юм байж. Тэр гэгээрсэн Багш бол хэдийнээ Үнэнийг олсон бөгөөд хaa сайгүй хэрэн хэсэж, анхааралд нь өртсөн ямар ч хүнийг чөлөөлдөг нэгэн. Шавь нь ч гэсэн хаа явсан газар нь түүнийг дагадаг ажээ. Багш мэдээж их ариун үнэнч хүн бөгөөд гуйлга гуйхыг хүсдэггүй. Түүнчлэн үргэлж өөрийгөө нуун далдалдаг, уулын далд нууцлаг зам харгуйгаар явдаг. Зам зуур юм идэхдээ шууд л таамгаар ямар нэг жимс, эсвэл зэрлэг ногоо түүнэ. Тэр идэж болох юуг ч иднэ. Шавь нь ийм замд ийм удаан хугацааны турш үүнээс илүүгээр тэвчиж чадахгүй болсон нь мэдээж.

Нэг өдөр шавь нь гуйлга гүйж болохоор хөрөнгөлөг айл олох найдлага өвөрлөн ганцаараа хот оржээ. Эцсийн дүнд олон хүн баярлан цэнгэж, найр наадам хийж байгаа нэгэн гэр бүлтэй таарав. Хэн ч гэсэн орж, юм идэх боломжтой байж. Туйлын их баярлан дотогш орж цадталаа идээд Багшдаа бага зэрэг хоол авчирч өгчээ. Шавь нь нэгэнт идэх юм аваад ирсэн юм чинь Багш нь идэж, идэх зуураа инээж хөхрөн: “Тэр бол дайсан нь буюу зээл олгогч нь өр төлбөрөө авахаар ирсэн байна. Даган баясаад баярлаад байх юм юу ч алга!” гэжээ.

Энэ угийг сонсоод шавь нь бүүр алмайрч, Багш нь ямар утгатай үг хэлснийг ч ойлгосонгүй. Тэр айлд дөнгөж шинэ хүүхэд мэндэлж, гэрийнхэн нь баяр хөөр болж, найр наадам хийн хүн бүрийг урьсан байж. Тэд ийм их аз жаргалтай байтал Багш, тэр бол тэдний дайсан нь, авлагын эзэн нь өрөө авахаар ирсэн нь тэр гэж байдаг. Тэгээд тэр: “Багш аягүй бол иссэн жимс хэтэрхий их идээд тархи толгой нь хэвийн биш болсон байх” гэж боджээ.



(Багш инээв)

Тэр Багшдаа нэлээд итгэлтэй болсон байсан тул орхиж явалгүй үлдсэн хэдий ч юу ч хэлсэнгүй. Тэр гэр бүл бол олон жил хүүхэд хүсэн залбирч байжээ. Тэгтэл одоо хүү заяаж, тиймээс олон өдөр үргэлжлүүлэн тэмдэглэхээр төлөвлөсөн байна. Дараагийн өдөр шавь нь бас л хоол гүйхаар явжээ. Тэр айл ямар ч зочдыг төлбөр нэхэхгүй оруулж байгаагаас хойш хэрэв хэн нэгэн оролцохгүй юм бол их харамсалтай байх болно. Энэ таатай бодолдоо умбасаар дахин хооллох итгэл дүүрэн байжээ.

Гэнэтийн юм болж, түүнийг хаалгаар ороход хүн болгон үймж сандран гүйлдэж, бас чанга уйлалдаж байхыг харав. Тэнд идэх юм өр байхгүй байжээ. Өчигдөрхөн л хүүгийн эцэг, эх их аз жаргалтай байсан байтал өнөөдөр Бурханыг буруутган хэвтэж байна. Үүний учир нь өчигдөр мэндэлсэн шинэ хүн нь дөнгөж сая нас барчихжээ.

Идэх юм юу ч үгүй болохоор тэр ямар нэг юм үлдсэн эсэхийг харж, энэ тэнүүгээр хайжээ. Хүмүүс оршуулгад бэлдээд завгүй байснаас идэх юм юу ч үгүй байж. Тэгээд тэр үлдэгдэл жаахан юмнаас хурдхан шиг шүүрч аваад гүйж гарав. Түүнийг хэн ч анхаарах сөхөөгүй байлаа. Тэр буцаж ирээд Багшдаа: “Багш аа, ямар нэг юм буруу болчихлоо. Өчигдөр мэндэлсэн шинэ хүн маань сая өөд болчихжээ. Тэнд өнөөдөр ямар ч сайхан хоол алга, иймд би танд өчигдрийн үлдсэн юмнаас жаахан хоол авчирлаа” гэв.

Тэгэхэд Багш нь чанга хөхрөхөд шавь нь: “Та яагаад инээгээд байгаа юм бэ? Тэнд нялх хүүхэд нас бараад тэд тийм их зовлонтой байхад та яагаад инээв?” гэж асуув.

Багш нь: “Энэ бол хөл толгойгоо алдсан (эсрэгээрээ) ертөнц. Өчигдөр өштөн нь ирэхэд тэд баяр хөөр болсон. Өнөөдөр өштөн явчихад гуниглаж байна!” гэлээ.

Шавь нь энэ байдлын учир шалтгааныг асуухад Багш нь: “Үнэндээ тэр нялх хүүхэд бол тэр гэр булийн хөрш байсан юм. Тэр хөрш тэдэнд өмнө нь мөнгө зээлдүүлснийг тэд ерөөсөө төлөөгүй байж. Хожим нь энэ гэр бүл баян болоод өр төлбөрөө бүр мартчихсан байна. Тэр хөрш нь нас барсныхаа дараа тэдний хүү нь болон мэндэлж, хамаг эд хөрөнгийг нь үгүй хийх зорилготой байжээ. Тэгээд тэр гэр бүл хүүтэй болсны баяраа тэмдэглэж, олон зочин урьж, хамаг мөнгөө найранд үрсэн байна. Хөршийнх нь буцааж авахыг хүсч байсан хэмжээний мөнгийг нэг л өдрийн дотор зарцуулсан тул хүү тэнд илүү удаан байх ямар

ч шалтгаангүй болжээ. Тэр өр нь төлөгдөж дууссаны дараа хүү явчихсан байна аа” гэж тайлбарлажээ. (Алга ташилт)

Хүн төрөлтөн бид баярлаж цэнгэх, уурлаж бухимдах, харамсаж гашуудах, аз жаргалтай байх г.м. дадал зуришилтай байдаг бөгөөд тэр бүхэн мунхаг харанхуйгаас болж байгаа юм. Бид юуны учир баясдаг, юуны учир уурладаг, юуны учир гунигладаг, бас юуны учир жаргалтай байдгаа мэддэггүй. Бидний хамаатан садан, эсвэл найз нөхөр хэн болох, бас бидний өштөн дайсан хэн болохыг шүүн тунгаах нь бидний хувьд тун хэцүү бэрх байдаг. Бид сүнслэг бясалгат хийхгүйгээр учрыг нь гаднаас хайх зам байхгүй.

МОИСЕЙ ШАВИЛЖ АХУЙДАА УГ ДУУГҮЙ, ХҮЛЦЭНГҮЙ НОМХОН БАЙСАН НЬ

*М*а нар Моисейг мэдэх үү? Хүн бүр мэддэг. Одоо үед Моисейг Арван Сахилтай алдар цуутай хүн байсан гэж үздэг. Тэр Бурхантай холбогдсон байх учиртай. Тэр Бурханыг таньсан байх ёстой. Тэр Бурханыг сонссон байх ёстой, тэгээд тэр Бурханаас шууд энэ сахилыг хүлээж авсан байж таарна. Бурханаас Сахил хүртсэн хэдий ч энэ завсар тэр Сахилаа зөрчиж, олон удаа өөрчилж байжээ. Яагаад тэгснийг нь би гайхдаг. Энэ бол Бурханы араншин биш, (Багш инээв) Моисейгийнх байх. Миний ааштай адил түүний ааш маш их байсан байх. (Багш болон бүгд инээлдэв)

Тэр их ууртай байсан бөгөөд Бурханаас өгсөн Арван Сахилтай чулуун хавтанг хөсөр хаячихсан. Хожим түүнийгээ дахиад хийсэн гэж би бодож байна. Угийг нь чулуун дээр сийлэхэд бас дөчөөд хоног зарцуулсан байх. Удаан хугацаа зарцуулсан.

Одоо ингээд Моисей амьдралынхaa турш өөр юу хийснийг үзье. Энэ бол түүний Их Багшийн шавь байсан үеийн тухай богино үлгэр. Тэр хараахан Их Багш болоогүй байсан төдийгүй, түүний ааш зан дүрэлзэгтгүй байсан үе юм. Гэвч энд та нарт харах юм бий. Хожим нь Моисей Их Багш болсон байх ёстой. Ийнхүү тэр Египетийн газар нутагт хүн ардыг удирдан хөтлөхөөсөө өмнө агуу Их Багшийн шавь байжээ.

Тэр Их Багшийн Моисейд оногдуулсан анхны дэг журам бол дуугүй байх. Тэр хоёр, нэгэн өдөр хөдөө хээр хэрэн тэнэж явж байтал Их Багш нь түүнд өөрөөс нь өмнө дуугарахгүй байх дэг журам тогтоосон аж. Их Багш Моисейг шавиа гэж хүлээн зөвшөөрсөн бөгөөд түүнийг ирээдүйн Их Багш болохыг харсан байж ч магадгүй.

Гэхдээ та нарын мэдэж байгаачлан хэн нэгнийг сургах нь их “амархан”. (Багш болон бүгд инээлдэв) Гэвч түүнд итгүүлэх, ойлгуулах, бас заасан зүйлээ дадуулах нь маш хүнд. Та нар зааж чадвал сайн хэрэг, гэвч тэр хүн нь сонссон эсэх нь өөр хэрэг. Харин сонсох нь их чухал, шийдвэрлэх зүйл мөн боловч энэ нь маш хэцүү байдал.

Ингээд Моисей, Их Багшийн шавь болоод Их Багштайгаа хамт явж байхад нь ямар ч юм тохиолдсон дуугүй л байх хэрэгтэй

гэж Багш нь түүнд хэлжээ. Дуугүй байх гэдэг нь амаа хамхи... тат гэсэн үг. Гэвч энэ нь их хэцүү.

Их Багш нь: “Юу ч тохиолдсон хамаагүй, чи дуугүй байх ёстой! Намайг чамд зөвшөөрөл өгтөл ярьж болохгүй шүү!” гэж сануулав.

Моисей “D'accord (францаар). За” гэв.

Тэгээд тэр хоёр олон өдөр хөдөө хээрээр хэрэн тэнэсээр энд, тэнд буудаллаж явав. Нэг өдөр үзэсгэлэн төгс байгальтай газраар өнгөрч явжээ. Энэ үзэсгэлэнт, ер бусын гайхамшигтай байдлыг Моисей тэвчиж чадалгүй харах гээд нүдээ, бас амаа ч нээжээ. Зөвхөн амаа нээгээд зогссонгүй, хэдэн үг дуугарсан нь: “Хөөх. Багш аа, энэ үнэхээр үзэсгэлэнтэй биш байна гэж үү?” гэжээ. (Багш болон бүгд инээлдэв)

Гэвч Их Багш нь түүнийг өршөөж: “Би чамд амаа т-а-т, тат гэж хэлсэн шүү!” гэв. (Инээлдэв)

Моисей: “За, Их Багш минь ээ, намайг уучил. Өршөө. Өршөө. Амаа татья. Дахиад юу ч ярихгүй” гэв.

Тэд цааш замаар явж байгаад гол гаталжээ. Тэнд нэг хүүхдийг голын урсгал хаман одож, эх нь араас нь орилон уйлж байлаа. Голын урсгал үнэхээр ширүүн аж. Моисей хүүхдийг аврахыг хүссэн боловч Их Багш нь зөвшөөрсөнгүй. Голын урсгал их ширүүн байсан учир Моисей ч мэдээжээр бас л юу ч хийж чадахгүй л дээ.

Тэр Их Багшдаа хэлсэн нь: “Багш аа, Та их хүчтэй. Та бүхнийг чадагч шүү дээ. Тэр хүүхдийг авраач. Та энд чимээгүй байгаад байж яаж чадаж байна аа? Эх нь уйлж байгааг харахгүй байна уу? Тэр хүүхэд живж байхад та дуугүй байсаар байх гэж үү?”

Их Багш: “Чиши. Дуугүй бай!” гэв.

Их Багш бас түүн лүү яг ингэж сүрхий ширтжээ. (Багш маш ноцтой, ширүүн цоо ширтсэн байдлыг үзүүлэв) (Инээлдэв) Та нар хэн нэгний ийм харцыг маш сайн мэднэ, би нэрийг нь дурдахгүй. (Инээлдэв) Тэр эмэгтэй уурласан үедээ бас ийм харагддаг. Нүд ердийнхөөсөө хоёр дахин том болдог. (Инээлдэв) Одоо та нар тэр хүнийг мэдчихсэн байх аа. Хэн нэгэн, юуг ч юм Хэн бэ?, Юу вэ? гэнэ – Би энэ хүнийг танихгүй гэдэг.

Хэдий тийм боловч Моисей хүүхэд живсэнтэй холбоотой явдлын дараа дуулгавартай байж, амаа хамхисаар байсан бөгөөд сэтгэл зүрхэндээ харин их зовж байлаа. Гэвч юу ч асуусангүй.

Тэр цаг үргэлж л Их Багшийгаа шүүмжлэн: “Багш их хатуу сэтгэлтэй хүн байна, энэрэнгүй биш, хүнийг хайлрах сэтгэлгүй юм. Тэр үргэлж л биднийг нигүүлсэнгүй байх ёстой, хүн төрөлхтнийг хайлрах ёстой, хэрэгтэй үед нь, зовсон цагт нь, аюул осолд өргсөн үед нь туслах ёстой гэж номлодог байсан. Харин энд хүүхэд живж, эх нь ямар ч арчаагүйдэн үйлж байхад тэр юу ч хийхгүй, дэргэд нь хараад зогсож байдаг” гэж бодож байв.

Тэр сэтгэлдээ маш их эргэлзэж, үнэхээр их зовинож, Их Багшийнхаа талаар тун ч ихээр шүүмжлэн бодож байсан ч амаа хамхисаар л байлаа. Моисей түүнийг ид шидийн хүчээ гаргах юм уу, өөр ямар нэг юм хийхийг гүйсан хэдий ч Их Багш туслагүй. Тэр Их Багшийгаа шүүмжлэх нь буруу гэдгийг мэдэж байсан ч тэвчиж чадаагүй, тэгээд Их Багшийнхаа тухай удаан гэгч нь бодож, төрөөд байгаа тэр бүх сөрөг бодлоо сарниулж чадахгүй байлаа.

Тэгээд ч хөдөө хээрээр хэрэн тэнэж явах замын туршид тэд бусад шавь нартай уулзахаар явж байсан байх. Өнөө үе шиг унаа машингүй учир явган явж байсан байж магад. Хэрэв тэд мөнгөтэй бол заримдаа морин тэргээр явж болох байсан. Хоёулаа тийм ч их мөнгөгүй учир ихэнхдээ явганаар хэрэн хэсэж явсан байх аа.

Нэг өдөр тэд тэнгисийн эрэг хавийн газар ирэв. Багийнхаа хамтаар живж байгаа завийг хоёулаа харжээ. Тэгээд Моисейгийн ам тэсэлгүй дахиад л нээгдчихлээ. Тэр: “Багш аа. Хараач. Тэр завь бүхлээрээ живж байна. Та харж байна уу? Бас багийн гишүүд бүгд живж байна шүү дээ. Та ямар нэг юм хийж туслач? гэлээ.

Багш нь: “Чишиш-ш-ш, Дуугүй бай!” гэж.

Түүний хэлсэн үг ердөө л энэ. Моисей тэгэхэд нь мэдээж өөр юу ч хэлэлгүй, дуугүй болов. Гэвч түүний шүүмжлэлт бодол



улам өссөөр, бүр ч ихэсжээ. Сэтгэл нь ихэд зовж, бүр их хүнд, зүдүүртэй болж ирсэн байна.

Тэр буцаж ирээд Их Багшдаа биш, харин Бурханд гомдол гаргав. Тэр хэлсэн нь: “Бурхан минь. Та надад энэ залууг дага гэж хэлсэн, гэвч Та энэ залууг ямар хүн болохыг мэдэхгүй байна”. (Багш болоод бүгд инээлдэв)

Бурхан хэлсэн нь: ”Огт хэрэггүй юм бүү ярь! Би үүнийг мэдэхгүй байж яаж болох вэ?”

Моисей түүнд үргэлжлүүлэн хэлсэн нь: “Гэхдээ Та мэдэхгүй байна аа, Бурхан минь. Тэр хүүхэд үхэж байхыг харсан, мөн завь багийн гишүүдтэйгээ живж байхыг, түүн дээр нь байсан гуч гаруй хүн цөм үхэж байхыг харсан, гэвч тэр юу ч хийгээгүй. Түүний сэтгэл ер хөдлөөгүй, бас нүдээ ч цавчаагүй, ийм л хүн байна даа, тэр залуу чинь. Гэтэл Та намайг түүнийг дага гэж хэлсэн”.

Харин Бурхан түүнд хэлсэн нь: “Энэ бол чиний мэдэхгүй зүйл. Тэр живсэн хүүхэд бол хоёр улсын хооронд асар том дайн дэгдээх хүн болох байсан юм. Үүнд олон зуун мянган хүн үхэж, сая сая хүмүүс шархдах байв. Ийм аюул гамшиг тохиолдох байсан бөгөөд тэр живснээр асар олон хүний амь амьдрал аврагдсан нь сайн хэрэг болжээ. Харин тэр живсэн завины хувьд гэвэл тэр бол дээрэмчдийн завь байсан юм. Тэр дээрэмчид тэнгисийн эрэг орчмын боомт газраар маш том дээрэм тонуул хийхээр явж байсан. Тиймээс завь живж, тэр бүх дээрэмчин үхсэн нь сайн хэрэг болсон. Ингэснээр тэр дээрэмчдийн үйлдэх байсан хамаг муу үйлдэл болох аллага, хүчирхийлэл, дээрэмдлэгээс хотын ард иргэдийг аварчээ. Завьтай дээрэмчид болон нялх хүүхэд живснээр тэдний хийх байсан хор хөнөөл арилж, гэм буруугүй хүмүүс бүгд аврагджээ гэдгийг чи одоо мэдлээ” гэлээ.


Мэдээжээр, үүний эцэст Моисей амаа хамхив. (Багш болон бүгд инээлдэв) Мөн түүний “дотоодын ам” ч бас хамхигдсан. Энэ л чухал юм. Гаднаа ярихгүй байснаараа чимээгүй болж байгаа юм биш, харин дотооддоо тайван намуун болсон юм.

Ингээд та нар Moisegүй наад зах нь ирээдүйн Их Багши болох ёстойг мэдлээ. Харин шавь байх үедээ тэр иймэрхүү хэцүү, бас нэг их юм мэддэггүй шавь байжээ. Ямар ч Их Багши байлаа гэсэн, тэдний хувьд оюуны чадвар багатай, билиг ухаан болон буян багатай ердийн хүмүүсийг сургах нь ямар хунд байдгийг та нар төсөөлж байна уу? Яагаад гэвэл Их Багши бол хэдийнээ асар их буянтай, асар их билиг ухаантай болчихсон тийм хамгийн агуу хүн байх хэрэгтэй. Хамгийн өндөр дээд түвшиний хүн байна. Одоо

энэ их өндөр дээд түвшиний хүн болох Их Багши бусдыг сургахын тулд энд дурьдсан шиг зовлон дундуур түулах хэрэгтэй болдог байна.

Хэрэв Моисей түүнд дуулгавартай байж, ерөөсөө дуугүй байх л юм бол хангалттай сайн юм биш үү гэж та нар бодож байна уу? Үгүй ээ, энэ тийм биш. Гаднаас нь харахад ямар байх нь биш, дотроо ямар байх нь чухал. Хэрэв дотроо цэвэр биш бол Их Багши руугаа заримдаа маш тааламжгүй энерги, хор хөнөөлтэй тийм энерги илгээх болно. Тэгээд ч Их Багши энэ бүхнийг тэвчээд дуугүй л байгаад байвал энэ нь түүнийг зовоохгүй байна гэсэн уг биш. Энэ нь багшийн үзэгдэх биеийг зовоохгүй байж магадгүй, гэвч энэ нь Их Багшийн оюун ухааны болон энергийн биеийг зовоож магадгүй. Их Багшийн билиг ухаан биш, энэрэл нигүүлслэл болон хайрын сэтгэл биш, мөн Их Багшийн хувь хүний хувьд нь ч биш. Харин энэ нь түүний оюун ухааны чадварыг зовоож магадгүй бөгөөд бас бие махбодыг нь ч зовоож мэднэ. Хэрэв үүнийг тэвчихэд оюун ухааны чадварын хувьд дэндүү их дарамттай байвал энэ нь гадагшаа илрөч, махан биенд нь нөлөөлдөг.

Ийнхүү хэрэв энерги нь маш ширүүн, хүчтэй, сөрөг байвал оюун санааны бие болон махан биед хоёуланд нь нөлөөлнө. Шавь нь Их Багшид түйлэн ширүүнээр, шууд нөлөөлнө, бас энэ нь бүр тэвчишигүй болж ч мэднэ. Гэвч Моисей дуугүй байсан учраас ямар ч нотлох баримт байхгүй тул Их Багши нь мэдээж энэ талаар юу ч ярихгүй бөгөөд дуугүй л байх байсан. Түүнийг Их Багши руугаа оюун санаагаараа дайрахад бие махбодыг нь ямар нэг зүйлээр цохих шиг хүчтэй нөлөөлдгийг хэн ч мэдэх аргагүй. Надад итгээрэй.



ОЙ МОДЫГ АВАРСАН ШУВУУ

Одоо би та нарт жижигхэн хүүхдэд зориулсан үлгэр яринаар байна. Энэ бол Шагжамуни Буддагийн өмнөх төрлийн үлгэр. Түүний өмнөх төрлийн үлгэр маш олон, энэ бол тэр төрлүүдийнх нь нэг нь тоть байсан тухай үлгэр.

Нэгэн удаа Шагжамуни Будда өөдөсхөн тотьны төрөлд төржээ. Тэр тоть жижигхэн ойд амьдардаг. Энэ ертөнц дэх түгшүүр, зовлонг мэдрэх ч үгүй, маш баяр баясгалантай амьдардаг байжээ. Түүнээс гадна өдөрт хоёр цаг бясалгадаг, мөн үүл, моддыг тойроод эргэлдэн нисэж, дуулж бүжиглэнэ. Ойн бүх амьтан түүнд маш хайртай, түүнчлэн бас найз нөхдийнхөөрөө зочилно. Тэд ч бас цөм “үнэмлэх”-тэй байжээ. Эргэн тойронд нь гадны хүн огт байхгүй. Хaa явсан газраа бүгдэд “Сайн уу!” гэж мэндчилнэ, ямар ч асуудалгүй. Бурхан түүнд нисэх чадвар хайрласан гэж бодож байсан болохоор тэр жинхэнээсээ аз жаргалтай, баяр баясгалантай

нэгэн байв!

Нэг өдөр гэнэт тэнгэр бүрхэж, ертөнц хав харанхуй болов. Тэгтэл ч хүчтэй цахилгаан цахиллаа! Тэр аянга хуурай мод руу буухад эргэн тойронд нь байсан хуурай өвс шатаж эхэлжээ. Тэгээд салхи салхилж, галыг тархаав. Удалгүй ой бүхэлдээ галд автжээ. Бүх амьтан давхилдаж, ойр орчиндоо нуугдах газар хайна. Аймаар! Тэд ой модны яг дунд нь амьдардаг учраас хаашаа яваахаа ч мэдэхгүй, ер нь явах газаргүй болжээ! Хаашаа ч явсан тэдэн лүү түймэр ирж байгаа нь харагдана. Галан далайд урхидуулжээ. Тэдний байдал нэн хүнд бэрх боллоо! Зарим нь амьсгалж ч чадахгүй, газар сайгүй утаа уугъж, хүчилтөрөгч дутагдаж эхлэв!

Шагжамуни Буддагийн
урьдах төрөл болох тэр өөдөсхөн
тоть сандран энд тэндгүй нисэж,
гал, утаан дунд орж, “Хурдан гүй!
Тэнд түймэр! Ийшээ гүй! Энд
гал байхгүй байна, хурдал!” гэж
хаширсаар байлаа.

Тэр ой дэндүү бяцхан totьны дуу хоолой дуулдахааргүй арай л том аж. Эргэн тойрныг бүхэлд нь нөмөрсөн гал, салхины дуу чимээ улам чангарч, түүний өчүүхэн дуу хоолой талаар болов. Гэвч тэр, “Ийшээ гол руу хурдал!” гэж хаширсаар л байлаа.

Гэлээ ч гэсэн ихэнх
амьтан тэр зүг зугатаж чадахгүй байлаа.


Ийм аюултай байдлын үед тэр түймэр лүү ус асгах санааг бодож олсон байна. Ингээд гол руу нисэн өөрийгөө усанд шалба норгоод буцан нисэж, усаа ойн мод руу гоожуулав. Хэдийгээр энэ нь тэр бүхэнд хангалтгүй гэж мэдэж байсан ч ахин дахин энэ үйлдлээ давтсаар байлаа. Тэр бас: “Би чадах чинээгээрээ хийнэ дээ” гэж бодсоор байжээ.

Ийнхүү тэрээр голд очиж, өөрийгөө шалба норгон буцаж ойд очоод усны цөөхөн хэдэн дуслыг доош дусааж, урагш хойиш нисэн өөрийгөө хайр найргүй зориулав. Ингээд ашиггүй байсан ч тэр үүнийг ахин дахин хийсээр байв, тэгсээр байтал өөрөө тэр чигээрээ бохир хар юм болчихжээ. Бие нь үнсэн саарал бүрхүүлтэй болсон байв. Тотьноос илүү хэрээтэй адилхан болжээ. Хэдийгээр



маш их ядарсан ч үргэлжлүүлсээр. Тэгээд өөртөө ингэж хэлж байна: “Би маш жижигхэн шувуу. Би явалт энэ бүхнийг нэгэн зэрэг хийх вэ? Ядахдаа өөрийн чадах хэрээрээ сайн хийе. Би бодож байснаасаа илүү удаан ниснэ дээ!”

Энэ үед бурхад болон тэнгэрийн элчис Тэнгэртээ суугаад цэцгийн балт дарсаа шимж байв. Тэд гэрэлтсэн сайхан газартаа алтан хаан ширээндээ сууж байлаа. Тэнд бүх юм нь гэрэлтэж байдаг учраас цахилгаан гэрлийн шаардлага үгүй. Баяр баясгалантайгаар ууж, идэж, тэнгэрлэг амттаниг амталж, анхилуун цэцгийн балтай дарс уух ажээ.



Гэнэт тэд доошоо ой руу харав, учир нь тэндээс дээшээ утаа суунаглаж байна гэнэ. Тэгээд доош харахад нэгэн жижигхэн хар цэг гол ой хоёрын хооронд нисээд байхыг харжээ. Тэр нь ямар шувууны төрөл болохыг тааварлахад хүнд байв. Тэд түүнийг өөрийгөө усанд шалба норгочоод буцан нисэж, дүрэлзэн байгаа ойн гал руу усаа дусааж байгааг харжээ.

Тэдний ганц нэг нь адисалсан хоол амандаа хийнгээ хэлж байх нь: “Ха! Тэр мулгуу жижиг шувууг харж байна уу? Түүний уураг тархи нь ажиллахаа болжээ. (Багш болон бүгд инээлдэв) Ойн их түймэрт өөрийн далавчнаасаа хэдхэн дусал ус дусаагаад унтраах ямар боломж байна аа? Дэндүү мулгуу юм! Мэдээж энэ бол ердөө л шувуу шүү дээ!”

Тэгээд инээлдээд бүүр очиж үзэхээр болов. Тэд хөгжилтэй байна байх гэж бодож л дээ. Гэвч тэр бурхадын нэг нь юу болж байгааг хараад сэтгэл нь хөдөлжээ. Тэр өөрийгөө том шувуу болгон хувиргав. Том шувуу жижиг totynы байгаа газар руу доош нисэн очив. Негөө бяцхан тоть жигүүрээ дэвсээр дусал ус ой руу доошоо дусаасаар урагш хойши ниссээр байлаа.

Тоть санаандгүй тэр том шувууг харав. Тэр урьд нь хэзээ ч ийм гоё шувууг хараагүй аж. Жигүүр нь өнгө өнгөөр солонгорох ажээ! Нүд нь том бөгөөд ган аяга шиг гялалзана. Бие нь бүхэлдээ хайрын хүчээр бялхана. Тоть гэнэтхэн маш таатай байдалд умбав! Гэвч тэр өөрийн үүргээ мартаагүй, жигүүрээ дэвсээр доошоо ус дусаасаар л байв. Хэдийгээр тэр ихэд ядarch байсан ч гол руу очиж, өөрийгөө шалба норгосоор л байлаа.

Тэр том шувуу нисэж очоод хэлсэн нь: “Хөөе бяцхан тоть оо, битгий мангтарaad бай! Яваад хэсэг амраад ав! Шатаж байгаа ой руу битгий ор! Оройтохоосоо өмнө болж уз, тэгэхгүй бол чи эндээ үхэх болно шүү!”

Тоть сонсохыг ч хүссэнгүй. Тэр хэлсэн нь: “Надад зав алга. Таныг сонсох зав алга! Надад маш чухал зорилго байна! Би өөрийнхөө үүргийг биелүүлнэ. Миний дорой бие хийж чадахаас илүү юмыг хийх болно! Таныг сонсох зав надад алга!”

Ингээд тэр гол руу, ой руу урагш хойш ниссээр, тэр галыг унтрааж, энэ занганд орсон амьтдыг аврахыг хүссээр байв. Бас том шувуунд хэлсэн нь: “Надад одоо зөвлөгөө хэрэггүй. Хэрэгтэй юм гэвэл тусламж л байна! Надад ус хэрэгтэй! Хоосон зөвлөгөө надад хэрэггүй”.

Тэгээд ажлаа үргэлжлүүлэн хийсээр байхдаа өнөөх том, сэтгэл татам шувуу руу дахин анхаарлаа хандуулсангүй. Тэр том шувуу хэрэг дээрээ тэнгэрийн бурхан бөгөөд totийг энэ өртөнцийн амьтдын төлөө өөрийгөө хэрхэн золиосолж байгааг хараад маш их уяран хайлав. Том шувуу өөрийгөө училж чадахгүй байлаа. Тэр ихэд ичиж: “Би энэ бүх адис ерөл, баяр цэнгэлтэй байдалтайгаар юу хийж байна аа? Өдөр болгон амттан идэж, сүү ууж, цэцгийн балтай дарс ташаалж, дутагдах зүйлгүй!”

Энэ бяцхан амьтан ийм хүчтэй, өөрийгөө ч золиослох сүнстэй болохыг тэр хараад өөрөөсөө маш их ичив гэнэ. Тэр Тэнгэр лүү харлаа. Бурхад, тэнгэрийн элчис үзүүлбэр үзэж байгаа юм шиг, өвчин зовлон, уй гашуугаар дүүрэн энэ өртөнц рүү доош харж, үүнийг зугаатай гэж бодон өөрсдийгөө баясгаж байлаа! Тэгээд тэр ийм маягаар амьдарч болохгүй гэж боджээ. Ийм эрэлхэг зоригтой, өөрийгөө золиослох сүнстэй жижигхэн totийг маш их өрөвдөн харж, түүнд ямар нэг юмаар тус больё гэж боджээ. Энэ нь түүнд Тэнгэрт өдөр бүр амтат жигнэмэг идэж, дарс, сүү уухаас өөр хийх юмгүй байснаас илүү сайн хэрэг юм шиг санагдav.

Тэд бол тэнгэрлэг буян хишигтнууд юм. Сүнслэг дадуулагч нэлэн олон хүн Тэнгэрт очиж чаддаг бөгөөд маш таalamжтай амьдралаар амьдардаг. Гэвч тэр бурхан Тэнгэр дэх баяр цэнгэл, буян хишиг хэтэрхий залхмаар юм гэж бодов, тэгээд энэ нь түүнийг ичээжээ. Ингээд totинд туслахаар шийдэв. Тэр: “Би totинд туслана!” гэж хэлэв.

Тоть бусдын зовлон шаналтыг нимгэлэхийг хичээн зүтгэж байгааг харангаа тэр яаж туслахаа бодож байлаа. Энэ хүнд хэцүү байдалд байгаа амьтад хэрхэн сандран урагш хойш гүйлдэж

байгааг ч харж байлаа. Сэтгэл нь ихэд хөдөлж, уйлж эхлэв! Улам хүчтэй мэгшсээр, нулимын нь хур бороо шиг асгарав. Тэр уйлсаар, тойрон тойрон ниссээр нулимын нь тэнгэрийн бороо шиг асгарав.

Ойн түймэр унтарлаа! Бяцхан тоть ч бас хур бороонд угаагдан эргээд сэтгэл татам нэгэн болжээ. Хийх ажил юу ч үгүй болсныг, мөн амьтад бүгд аюулаас мултарсныг харлаа. Тэд чангийн инээлдэн хөхрөлдөөд “Go, Go, Go” гэж дуулцгаав. (Багш болон бүгд инээлдэв) (Алга ташилт)


Аюулаас мултарсныхаа дараа бүх амьтан энэ баяр жаргалыг тэр бяцхан тоть авчирсныг мэджээ. Тэгээд бүгдээрээ урагш хойш нисэн байгаа шувуу руу харав. Тэр бурхан яагаад тэгж их уяран доош ирж, тэдэнд тусалсныг ойлгожээ. Бүгд л дуулж бүжиглэн алга ташиж, totinid баяр хөөрөө илтгэлээ. Тэгээд урьдынх шигээ цөм баяр жаргалтай амьдарчээ! (Алга ташилт)

Энэ угзэрийг хүүхдийн оюун санаанд зориулсан боловч бидэнд үүнээс сурах юм бас байна аа. Бид энэ ертөнцөд амьдарч байхдаа гэр бүлийнхээ төлөө байна уу, улс орныхоо төлөө байна уу хамаагүй, чадлынхаа хэрээр бусдад туслах ёстой. Энэ бол бидний үүрэг. Бид ертөнцийг номхонгоо аугаа зүйлсийн тухай яриад байх хэрэггүй. Бидний хийх ёстой зүйл бол өдөр тутмын ажлаа л сайн хийх явдал. Ингэж байж л бүх юм сайн сайхан болох ёстой.

Өөрсдийнхөө гэр орныг өөд нь татаж, цэвэр цэмицгэр байлгаж, гэрийнхэндээ найрсаг хандаж, хүүхдүүдээ эрүүл саруул байлган тэднээр орчин тойрноо цэвэрлээж сурга, ингэсэн цагт л та нар оногдсон үүргээ сайн гүйцэтгэлээ гэсэн үг. Заримдаа бид хaa нэг газарт газар хөдлөл, гол түймэр, үер ус гэх мэтийн аюул гамишиг болбол тогтмол хийдэг ажил шигээ чадлын хэрээрээ туслах ёстой. Энэ бол бидний үүрэг. Гэсэн ч бидний мэдэхгүй байгаа, тусалж чадахгүй байгаа зүйл дэндүү их бий. Гэвч бид юу чадахаа л хийнэ. “Энэ ертөнцөд дэндүү их зовлон зүдүүр байдал. Үүнд би тусалж гэхэд өнө мөнхийн хугацаа хэрэгтэй болно” гэж бодож болохгүй. Та нарын хийх ёстой зүйл гэвэл өмнө чинь тулгарч байгаа зүйлд л яаж тусалж чадах вэ? гэдгээ бодож олох явдал юм.

ИХ БАГШИЙН ДОТООД МЭДРЭМЖ

А) ШУВУУНЫ ТУХАЙ ТҮҮХ

 А нөө өглөө биднийг гэрээс гарагын өмнө нэг шувуу нисэж ирээд өмнө минь үхэдхийн унаалаа. Магадгүй хурдтай нисэж яваад цонх мөргөсөн байх. Энэ нь муу юм болсон ч гэлээ үүнээс ч муу юм дараа нь болсон. Өөр нэг шувуу түүний хажууд ирж суугаад хагас цаг, нэг цаг, бүр одоог хүртэл удтал хөдөлсөнгүй. Тэр шувуу нөгөөхөө босоод өөртэй нь хамт нисэхийг хүлээж суусныг би мэдсэн. Тийм учраас л тэнд суугаад нэг ямхын төдий ч хөдөлсөнгүй!



Ихэвчлэн шувууд ингэж сууж байхдаа ч толгойгоо ийш тийш хөдөлгөж байдагсан. Гэвч тэр шувуу яг үхсэн мэт хөдөлгөөнгүй суугаад нөгөө шувууныхаа биенэг ширтсээр байв. Тэр хэт цочролд орсон юм уу, эсвэл “Чи яагаад босоод надтай хамт нисэхгүй байна?” гэж бодоод сууж байсан ч байж магад. Эсвэл нөгөөхийгөө аль хэдийнээ үхчихсэн гэдгийг мэдэж байсан ч ямар нэг гайхамшигаар босоод ирж магадгүй гэж өдий болтол хүлээж байгаа байх. Аль эсвэл, тэр бас үхчихсэн юм шиг дүр үзүүлж байж ч болно, яагаад гэхээр би түүний хажуугаар нааш цааш холхин хэн нэгнийг дудаж байхад ч ереөс хөдлөөгүй.

Ингээд би нэг эмэгтэйд: “Нааш ир, магадгүй энэ хоёр хоёулаа үхсэн байх” гэлээ.

Үүнийг сонсоод тэр эмэгтэйг ирэх үед нөгөө шувуу нисээд явчхав. Нөгөө үхсэн нь тэр хэвээр хоцров. Тэр шувууны дэндүү үнэнч байдал миний сэтгэлийг хөдөлгөсөн. Тэр үхсэн шувуу нь баяртай байгаа байх, харин амьд нь одоо их зовж байгаа даа. Тэр тэнд суугаад нөгөөхөө босож ирээд хамтдаа цааш нисэн гээд хүлээгээд байсан. Уг нь тэд хамтдаа нисэж байтал гэнэтхэн нэг нь унаад үхчихэд нөгөөх нь хажууд нь суугаад хүлээж байна гэдэг миний хувьд маш харамсалтай байлаа.

Тиймээс та нар жижиг асуудал гэж битгий орхиж бай, миний хувьд энэ нь жижиг биш, юу ч жижиг биш. Тухайн хүний хувьд хамаатай л бол энэ нь жижиг асуудал биш. Тэр шувуу


Өөр хань олж авч чадсан эсэхийг би мэдэхгүй байна. Нөгөөдхөө нисчихсэн байна уу гэдгийг харааар тэр дээш доош нисэж байж ч магадгүй юм. Харин эмэгтэй гэрээс гарагсад нөгөө шувууг оршуулсан даа.

Б) ЯЛААНЫ ТУХАЙ ТҮҮХ

Э нэ бол Энэтхэгт болсон өөр нэгэн түүх. Хоёр сарын өмнө би зүгээр л амрахаар Энэтхэг рүү явлаа. Хималай руугаа буцаж очсон хэрэг, гэвч энэ удаад тэд үнэхээр урмыг минь хугаллаа. Хaa сайгүй маш бохир, эрүүл ахуйн шаардлага хангаагүй байсан. Хүмүүс голын хөвөө дагууг бие засах газар болгочхож, та нар голын ойр бясалган суух цэвэр хэсэгхэн газар ч олж чадахгүй. Хaa сайгүй яг ийм, бас эргэн тойронд дуу чимээ ихтэй. Энд үй түмэн мөргөлчин ирж, янз янзын тааруухан хөгжим сонсогдоно. Энэ зүгээр л дашрамд хэлэхэд ийм байсан юм шүү. Гэлээ ч гэсэн би энд үлдээд хэсэг хугацаагаар бясалгасан. Нэгэнт би тэнд ирчихсэн болохоор ингээд л тэндээ үлдсэн юм.

Нэгэн өдөр би жаахан юм идэхээр зоогийн газарт очлоо. Мэдээж ийм нөхцөлд би өөртөө хоол хийж чадахгүй байсан хэрэг. Гэлээ ч энэ бол асуудал биш, тэнд хaa сайгүй ургамал хоолны газар байдаг. Ингээд би зоогийн газарт байхдаа цонхны шилний цаана аалзны торонд орооццолдсон ялаа байхыг харав. Торноос гарах гэж ялаа тэмцэлдэж байгаа нь намайг шаналгалаа. Мэдээж би ялааг аврахыг хичээсэн. Тэр цонхыг Энэтхэг маягаар хадаасаар бэхэлсэн байснаас би онгойлгож чаддаггүй. Би хутга, сэрээ мэтийн зүйлээр онгойлгох гэж хичээсэн боловч амжилт олсонгүй. Би хагас цаг, бүтэн цаг ноцолдсон, үүнээс илүү ч байж магадгүй. Миний хажууд нэг хүн байсан, бид зүгээр л бие биеэ мэддэг байсан юм. Тэр бол Итали залуу. Тэр: “Ялааны төлөө сэтгэлээ зовоох хэрэггүй. Тэр юу юм бэ? Ялаа бол юу ч биш” гэлээ.

Би: “Энэ бол таны хувьд юу ч биш байх, гэвч миний хувьд



тийм биш. Та яагаад бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцоод байгаа юм бэ?” гэлээ.

Тэр хүн толгойгоо сэгсрэв. Тэр ялааны амьдралыг шалихгүй зүйл гэдэгт намайг үнэмшүүлж чадаагүй. Дараа нь бид түр ярилцах зуур би ялааг аврахыг дэмий л оролдсоор байв. Ярилцаж байхдаа тэр үүнийг орхи гэж ятгахыг хичээж байлаа. Би: “Тэр ялаа чухал зүйл биши байж магадгүй, гэвч тэр миний өмнө амьдралын төлөө тэмцэлдээж байна, би түүнийг нь харж байна. Одоо би тусалж чадах бол туслах хэрэгтэй. Тэгээд ч энэ нь ялаа юу, эсвэл хүн үү, ямар ялгаа байна? Энэ ялаа зовлонд учраад үүнээсээ гарах гээж тэмцэлдээж байхад та түүнийг тэр чигт нь хаяж байна. Үүнд та анхаарлаа хандуулах хэрэггүй. Би үүнийг ялааны төлөө хийж байгаагаас гадна бас өөрийнхөө төлөө хийж байна, яагаад гэвэл ийм зовлонг би хараад байж тэвчихгүй нь” гэж хэлэв.

Биднийг ярилцаж байхад нэг Энэтхэг хүн ирсэн. Тэр миний хажууд суух зөвшөөрөл хүслээ. “Тэг ээ, энэ бол зоогийн газар. Хүн бүхэн сууж болно шүү дээ. Яагаад надаас асууна вэ? гэж намайг хэлэхэд тэр: “Тиймээ, яагаад гэвэл би тантай ярилцах гэсэн юм” гэлээ.

“Аан, юун тухай” гэж би асуулаа.

Тэр ялааны амьдралын ялихгүйн тухай бүхэл бүтэн лекц заахыг хичээсэн юм. Тэр өөрийн логик санаагаа эргэлзээгүй гээд: “Уучлаарай хатагтай, энэ агшинд бидний эргэн тойронд, эсвэл энэ дэлхийд хaa сайгүй олон түмэн тоолшгүй ялаанууд үхэж байгааг та мэдэж байгаа. Энэ өчүүхэн ганцын төлөө та яагаад анхаараад байгаа юм бэ?” гэлээ.

Би: “Тийм ээ, яагаад гэвэл энэ миний өмнө үхэж байгаа бөгөөд бусад үй олныг нь би харахгүй байна. Би мэдэхгүй байгааг тэр үй олны төлөө юу ч хийж чадахгүй, гэвч би энд өөрийнхөө мэдэж байгаад л тусалж чадна. Түүнээс гадна, үүнтэй адил логикоор өдөр бүр үй олон түмэн хүн үхэж байгааг та бид харж байгаа. Яагаад бид энэ бүхэнд ямар нэг талаар анхаарал тавихгүй байна вэ? Яагаад бид зөвхөн өөрсдийн амьдраллаа л анхаараад байдаг юм бэ? Түүнчлэн энэ логикоор бол бид юм идэхээ болж, тэгээд үхэх ёстой. Эсвэл Африкт үй түмэн хүүхэд өлсгөлөн байгаа учраас бид өөрийн хүүхдүүдээ хооллохгүй байх ёстой. Энэ логикоор бол яагаад бид энд ганц хоёр хүүхдийг анхаараад байна аа?” гэж хэлэв.

Ингэхэд тэр тийм ч баяртай байгаагүй. Тэгээд надад илүү ихийг заахыг оролдсоор л байв. Би мэдэхгүй юм. Хүн бүр

л надад ямар нэг юм заах гэж хичээдэг болохоор би тэнэг хүн шиг харагддаг байх гэж бодож байна. Тэр ялаа амьдралын төлөө тэмцэлдэж байгааг нь мэдрэх надад аймаар байсан. Дараа нь тэр хүн надад: “Гэвч ялааг аварснаар та аалзны хоолыг булааж байна” гэж хэлэв.

“Тийм, тийм” гээд би: “Гэхдээ аалз явчихсан. Аалз энд алга” гэж хариулав.

Тэр: “Та яаж мэдэж байгаа юм бэ?” гэж асуув.

Би: “Яагаад гэвлээн энэ торны ихэнх хэсэг нь гэмтсэн байгааг та харж байна, нэлээн хэдэн үхсэн шавьж аль хэдийнээ энд байна. Тэр бүхнийг идээгүй байгаа биз дээ. Бас энэ газар салхи ихтэйг та харж байна, ийм газар аалз удаан амьдарч чадахгүй. Тэр хэдийнээ явчихсан. Тэгээд ч энд нэлээн хэдэн тор байгаагийн хэрээр үхсэн шавьж төчнөөн байгаа боловч нэг нь ч ашиг тусаа өгөөгүй байна. Тиймээс би ялааг аварвал аалзыг хохироогүй байх. Хэрэв аалз энд байсаар байгаа бол түүнд аль хэдийн дэндүү их хоол бэлэн болжээ. Ганц нэг хохирогч бол юу ч биш, хэрэггүй. Бид зөвхөн өлссөн үедээ юм уу, эсвэл хэрэгтэй үедээ л иддэг шүү дээ”.

Эцэст нь тэд намайг ганцааранг минь үлдээсэн. Тэд намайг маш муу сурагч, чадамжгүй шавь гэж бодсон байх. Ингээд тэд явсан, тийм л байна.

Та нар намайг уяхан сэтгэлгүй гэж хардаг байх. Миний хүнд хатууажилнамайг ийм болгосон юм, гэвч би амьд улдсэн. Бүхлээрээ үхээгүй, зөвхөн хагас үхсэн байж магадгүй. Надад та нарт байдаг бүх мэдрэмж бий. Хэрэв би үхсвэл, эсвэл шаардлага гарвал үүнийгээ яаж захирахаа би мэднэ. Түүнчлэн энэ бүх зүйл зөвхөн түр зуурын сэтгэлийн хөдөлгөөн гэдгийг би мэднэ. Заримдаа би түүнийгээ энэ ертөнцөд амьд улдэхийн тулд хадгалж, заримдаа түүнийгээ номхонгож, заримдаа үл тоомсорлож байдал. Тухайн байдлаас хамаарна. Би түүнийгээ бүгдийг нь орхиж чадахгүй. Тийм биши бол би та нарыг болон бусад хүнийг ч ойлгож чадахгүй. Хүн төрөлхтний бүхий л мэдрэхүй надад байх ёстой. Би Газар, Тэнгэрийн аль алинд нь байна. Хэрэв би хэт өндөрт байвал та нар надад хүрч чадахгүй, би та нарыг ойлгож чадахгүй.

Буддын шашины Абидын сударт Шагжсамуни Будда Ариун Дагшин газрыг ямар үзэсгэлэнтэй болохыг дүрсэлсэн байдал. Ариун Дагшин оронд, байгалийн үзэсгэлэнтэй газар, үнэт орд харши (болов, очир алмаас, элдэв төрлийн үнэт эрдэнийн чулугаар хийсэн), олон янзын үзэсгэлэнтэй сайхан эрдэнийн цэцэг, тэнд амьдарч байгаа голо үзэсгэлэнт хумүүсээс гадна өөр зүйл ч байдал.

Бүх юм нь ер бусын.

Гэвч тэнд нэг юм нь илүү онцгой. Энэ араг дахь тэр нь юу вэ? гэвэл хүмүүс нь өвчин зовлон гэдэг үгийг ер сонсоож байгаагүй, өвчин эмгэг, зовлон зүдүүр гэдэг үгийг мэдэх байтугай үгийн санд нь ч тийм төрлийн үг байхгүй. Хэрэв тэр хүмүүс болон тэр Их Багши энэ ертөнцийн зовлон зүдүүрийг ойлгох юм бол Тэр, Өөрөө зовох ёстой болно. Хэрэв Түүний ухамсар үргэлж Ариун Дагшин газартай хандаж байвал Тэр хэзээ ч дэлхийн зовлон зүдүүрийн учрыг ойлгохгүй байхсан.

Иймд хэн нэгэн хүн та нарт Их Багши бол зовлон зүдүүрээс ангид байдаг, мэдрэхүйгээс ангид байдаг гэж хэлэх юм бол тэд тун мулгуу юмнууд байж таарна. Тэд Их Багши гэж хэн болохыг мэддэггүй. Их Багшийг тийм байлгах нь бидэнд ямар хэрэгтэй гэж? Тэд магадгүй чулууг шүтээж болох юм.

ХААНЫГ СОНГОСОН ОХИН



Энэтхэгт нэгэн хааны тухай үлгэр байдаг юм. Тэр бол харьят ардаа хайлрадаг маш сайн хаан байжээ.

Нэгэн өдөр бүх эд хөрөнгө, үнэт зүйлээ ард иргэддээ тараахаар болж гэнэ. Нийтэд дэлгэн үзүүлж байгаа зүйлээс нь хэн ч гэсэн өөрт хэрэгтэйгээ ямар ч болзолгүйгээр зүгээр л санаандаа нийцүүлэн авч байсан аж. Хаанд үр хүүхэд, гэр бүл байхгүй учраас ард иргэддээ төрөл төрөгсөд шигээ хандаж, хайлрадаг байжээ.

Хүн бүхэн сэтгэлдээ нийцсэн ямар нэгэн юмыг сонгон авчээ. Гэтэл нэг охин ойртон ирж, хамаг л эд хөрөнгөө дэлгэн үзүүлж байсан хааны хажууд шууд яваад очжээ. Тэр хааны мөрөн дээр гарaa тавиад: “Таныг ч бас болох уу?” гэж асуусан байна.

Хаан их гайхаж: “Яагаад? Миний толилуулж байгаа зүйлээс

юуг нь ч хүсэхгүй байна уу?” гэж асуухад

Охин: “Үгүй. Би зөвхөн таныг л хүсэж байна” гэж хариулав.

Мэдээжийн хэрэг, хаан хэн нэгэн түүнд эд баялгаас болж биш, харин зөвхөн өөрт нь л хайртай байна гэдгийг мэдээд маш их баярлажээ. Хаан зөвшөөрч, тэд гэрлэжээ, тэгээд санасан ёсоороо урт удаан, аз жаргалтай амьдарчээ.

Тэр охин юу ч хүсээгүй боловч хаантай гэрлэсний дараа хааны бүх эзэмшил, эд хөрөнгө, улс орон нь тэр чигээрээ түүний харьяанд орсон юм.

ХАЙР СЭТГЭЛ БА ҮЗЭН ЯДАЛТ

Олон жилийн өмнө Чан-Шөү нэртэй хаан байжээ. Энэ нь Хятадаар урт амьдрал гэсэн утгатай. Хэдийгээр тэр өнөөдөр амьд биши ч гэсэн. Ингэж хэлсэн нь ертөнц бол мөнх бус байдгийг та нарт мэдрүүлэх гэснийх юм.

Нэгэн өдөр Чан-Шөү хаан нийслэл хотоороо явжээ. Ирэхдээ сэтгэлийн их түгшүүртэй болсон нь түүний улс нь хөрш орных нь сонирхлыг татах, тэд дайн зарласнаас болжээ.

Тэр хаан нутаг нэгтнүүддээ их хайртай юмсанж. Тэр сайн хаан төдийгүй, их хэрсүү, гярхай хаан байв. Нутгийнх нь эрчүүд өдөр бүр харгис хэрцгийгээр алгуулж, цусаа урсгаж, хүмүүсийн үхэж байхыг харахыг хүсэхгүй байв. Ийнхүү хаан маш их эргэлзэж, энэ байдлаас зайлсхийхийг оролдож байлаа. Хаан ордондоо нааш цааш холхиж, маргааш өдөр тохиолдоо азгүй явдлуудыг бодож байв. Энэ байдал түүний мэдрэлийг сульдааж, уйтгарт автуулан ихэд уйлмаар санагджээ.

Санамсаргүй, эрхэм дээд цолтой, маш үнэнч түшмэлийнх нь хэлсэн хэдэн үг түүнийг хэвийн байдалд нь буцаан оруулав. Тэр: “Эрхэм дээдэс ээ, өөрийгөө хэтэрхий их бүү шаналга. Бид сайн бэлтгэгдсэн, хүчтэй армитай, бас манай улс баян чинээлэг, бат бэх. Бид тэдний эсрэг сайтар тэмцэлдэх чадалтай гэдэгт би эргэлзэхгүй байна. Өчүүхэн ч бүү эргэлзээч, гүйя. Бид бүгд бэлэн, зөвхөн таны тушаалыг л хүлээж байна” гэсэн аж.

Хаан үүнийг бодох тусам бүр муу байдлыг мэдэрч, зөв шийдвэр гаргах чадваргүй болжээ. Эдүгээг хүртэл тэр хаан ширээнд байх хугацаандаа өөрийн улсыг жолоодохдоо хэзээ ч хүч хэрэглэж байсангүй. Тэр улсаа хайраар жолоодож байлаа. Иймд улс орон нь маш тайван амгалан, баян чинээлэг, ард түмэн нь энх амар, сэтгэл хангалуун амьдардаг байжээ. Хамгийн гол учир нь ард түмэн нь хааныг маш их хайрлаж, хүндэлдэг байсан нь түүний агуу их хайр, эрхэм дээд ёс суртахуун төдийгүй, бас



тухайн улс төрийн тогтолцоотой холбоотой байв. Үүнээс нь болж тус улсын арми нь тийм ч их хүчтэй, чадалтай байж чадахгүй байлаа. Иймд тэр дайнд ялна гэдэгт итгэлгүй байв.

Бусадтай дайн эхлүүлж, бусад улс руу өнгөлзөх санаа түүний оюун ухаанд хэзээ ч орж ирэхгүй. Тэр энэ нүүрлээд байгаа нөхцөл байдалд хэрхэн хандах тухай ямар ч санаа оноогүй байж л дээ. Хэрэв цэргүүдээ гадагш тулаанд илгээвэл ялахгүй гэдэг нь тодорхой. Түүнчлэн дайн болбол үхэл нүүрлэж, айл өрхийн хүмүүс нь үхээд байвал түүний ард зоны уdam угсаа мөхөх шалтгаан болно. Тэгвэл хүмүүсийнх нь төдийгүй улс орных нь хувьд ч дэндүү их гарз хохирол болох билээ. Энэ дайны дараа өнчрөл, бэлэзвсрэл, ядуурал нүүрлэх болно. “Ямар нүгэл хийсэн гэж тэд ийм байдалд орох болж байна?” гэж өнчрөн үлдэх хүүхдүүдийн тухай бодож суув. “Тэд яагаад балмад дайнаас болж зовлон зүдүүртэй учрах болж байна?”

Тэр ингэж бодсоор дахиад л зовуурь шаналгаатай болжээ. Тэгээд дэлхий дээр өмч хөрөнгө юм уу, эсвэл нийгэмд эзлэх байр сууринаас илүү үнэ цэнэтэй зүйлийг хайж олохоор гадагш гарья гэж шийджээ. Ингээд хаан улс орноо дайсандaa өгөхөөр төлөвлөв. Магадгүй тэр авшиг авч, бясалгаж, ургамал хоолтон болохыг хүссэн байх. Дараа нь тэрээр ханхүү, эзэн хааны татвар эмс, гоо үзэсгэлэнтүүдээ сүүлчийн удаа харахаар ордноо тойрон алхав. Тэд нь дараагийн өдөр улс орон нь өөр хүний мэдэлд орно гэдгийг мэдэлгүй гүн нойрондоо автаж байлаа.

Хаан ханхүүгийн өрөөнд орж түүнийг ширтгэв. Түүний нэрийг Чан-Шэнь (Хятадаар мөнхийн гэсэн утгатай) “Мөнх” гэдэг нь мөнх бус, “Удаан амьдрал” гэдэг нь ямар ч амьдралгүй болох нь дээ. Хаан хүүгээ ширтсээр, харин ханхүү удтал ном уншиж суусныхаа дараа ширээнийхээ ард унтдаг зуршилтай болсон байжээ. Тэр ганц хүү нь хатныг нь нас барснаас хойш эдүгээ хүртэл хааныг цаашдынх нь амьдралд зоригжуулагч, энэ ертөнцөд сэтгэл санааг нь өөдрөг байлгадаг, хааны ганц тайтгарал болж байж л дээ. Ханхүү гэнэт сээрэв. Тэр эцгийгээ хараад их гайхаж гэнэ.

Хаан хүүдээ хэлсэн нь: “Хүү минь, хөрш орны арми манай нутагт ирлээ. Тэд манай улсыг болон хаан ширээг булаах гэж байна. Тиймээс би хаан ширээгээ хадгалж үлдэхийг хүсэх юм бол миний ард түмэн зовлон зүдүүрийн ёроолгүй ангал руу унах болно, би үүнийг хүсэхгүй байна. Тэр дайн нь бас нөгөө орны иргэдийн зовлон зүдүүрийн шалтаг болно, мөн манай улсын мөхлийн шалтгаан, хүнд гарз хохирлын шалтгаан болох болно.

Хоёр орны аль алиных нь иргэдэд муу болно. Тиймээс би хөршдөө хаан ширээгээ өгөхөөр шийдлээ. Бид сүнслэг бясалгалыг дадуулан хөгжүүлэхээр ууланд гарвал илүү дээр байна” гэв.


Үүнийг сонсоод ханхүү хэдэн дусал нулимс унагалаа. Тэр ордон дахь шоколад, адистай хоол гэх мэтийн зүйлдээ тэмүүлсээр байх болно гэж би тааварлаж байна. Ууланд гарах юм бол адистай сайхан хоолыг хаанаас олох билээ? Тэр дахиж амттан олж авч чадахгүй нь тодорхой. Магадгүй тэр төрснөөсөө хойш одоог хүртэл амьдарч, өсөж том болсон гэрээ санах л байх. Өмнө нь хэзээ ч гачигдал зовлонтой байж үзээгүй. Гэвч эцгийнхээ хэлснийг сонссон тэр үеэс амьдралынх нь бахархам сайхан өдрүүд нь бараг дуусаж гэдгийг ухаарч, үүнээс хойш хүнд хүчир ажил хийж, гачигдал зовлонтой байх болно гэдгээ ч мэдсэн байна.

Тэгээд хаан болон ханхүү гар гараасаа барилцан бүхнийг орхин уул руу явлаа. Хаан бодь модон доор Арьяабалын номын цогцсоор бясалган суув. Магадгүй нэг иймэрхүү люм болсон байх. Тэд өөр хүний дуу хоолой сонсоглүй хэсэг хугацаа өнгөрөхөд өмнөх сүр жавхлант амьдралаа хүсэхээ бүүр больж, сайхан, бүүр сайхан мэдрэмж төрсөөр байгаад энэ амьдралдаа дасан зохицжээ.

Ханхүү өдөр бүр уулын гүн лүү явж, идэж болмоор өвс ургамал, зэрлэг жимс хайна. Түүнийгээ олоод эцэгтээ барихаар эргэж ирнэ. Нэгэн өдөр ханхүүг гадагш явсан хойгуур эцэг нь ганцаар бясалгаж суув. Гэнэт хааны хажуухнаас нь: “Энэ бол тэр, энэ бол тэр, тэр хаан байна” гэх хүний дуу гарч хааныг цочоолоо.

Тэгээд хаан жижигхэн, эцэнхий, муухай царайтай хүн бут сөөгнөөс үсрэн гарч ирэхийг харав. Тэр эр хаанд: “Манай ордныг дайсан авсан, нэлээд хэдэн үнэнч түшмэл амия хорлох гэж байна. Хөрш орны хаан таны талын бүх хүнийг баривчлах тушаал өгсөн. Манай хүмүүс хэзээ төгсгөл болохоо мэдэхгүй их зовж байна. Би таныг хайж, улс орныхоо бараг бүх газраар явлаа. Би өнөөдөр таныг олсондоо их баяртай байна” гэжээ.

Энэ үед хаан ихэд зовуурилан шаналж, уйлсаар: “Намайг явчихсан учраас манай хүмүүс тийм их эмгэнэлт байдалд унаа



юу?” гэж асуужээ.

Тэр хүн: “Тийм ээ, таныг оргосон учраас дайсны хаан таныг хаашаа явсныг мэд гэсэн тушаал гаргаж, хүмүүсийг баривчлан асууж, хатуу ширүүнээр тамлаж байна. Ганц ч хүн мэдэхгүй байна. Тэр дайсны орны хаан манай хүмүүсийг нэг газар нуусан байх хэмээн хардаж байгаа бололтой. Тиймээс ихэнхийг нь харгис хэрцгийгээр зодож байна. Тэр шинэ хаан таны байгаа газрыг хэлсэн хүн бүхэнд их хэмжээний шагнал, шан харамж өгнө гэж амласан” гэлээ.

Тэгээд өнөөх хүн Чан-Шөү хааны бугуйнаас шүүрэн авч: “Та надтай хамт яг одоо буцна даа. Би шагналаа авмаар байна” гэв.

Хаан түүнийг цааш түлхэхэд тэр туранхай хүн уначхав. Тэгээд хаан түүнийг зэмлэх гэснээ ингэж боджээ: “Миний хүмүүс надаас болж тэгж их зовж байхад би яаж ийм цэвдэг сэтгэлтэй байж болох билээ. Миний бие ч мөнх бус шүү дээ”.

Хэдийгээр түүний нэр “Чан-Шөү” (урт амьдрал) гэдэг боловч амьдрал бол мөнх бус байдгийг тэр ухамсарладаг юмсанж. Хаан бодсон нь: “Би өнөөдөр энэ биеийг хадгалж үлдэвч магадгүй энэ маань маргааш үхэж мөхөж болно. Хэрэв намайг барих гэсэн тэр эсрэг этгээд рүү би эргэж очвол олон гэмгүй хүнийг аварч болох юм”.

Ингээд хаан тэр хүний туяхан мөрийг зөөлөн алгадаад: “За сайн байна, чи намайг авч явж болно, тэгвэл олон хүн баярлаж, чи ч сэтгэл хангалаун үлдэх байх” гэв.

Тэр эсэргүүцэлгүйгээр хамт явах боллоо. Тэгээд Чан-Шөү хаан чулуу авч модны их бие дээр ханхүүд зориулан салах ёс гүйцэтгэх хэдэн үг сийлгэв. Ханхүү буцаж ирээд хаан эцэг нь алга болсныг мэдэхээрээ сэтгэл нь түгших вий гэж хаан эмээжээ. Хаан: “Би баригдаад хот руу хүргэгдлээ. Чи эндээ үлдээд бясалгалаа үргэлжлүүл” гэж бичжээ.

Хүү нь үүнийг уншиж мэдээд өөрийнх нь оронд үргэлжлүүлэн бясалгах болно, ингээд хаан тэр хүнтэй явав. Тэр жижигхэн хүн хааныг хурдан яв гэж шавдуулна. Тэр хүн бол үнэхээр харанхуй бүдүүлэг хүн аж. Ер нь тэр ийм нөхцөлд энэ бүх хуурамч байдлыг ухаарахгүй байна. Түүний муу санаа нь бясалгагч хүний бодлыг ойлгож



Ханхүү уулнаас аавдаа өгөхөөр багц жимс ногоотой ирсэн ч аавыгаа олсонгүй. Дуудтал ямар ч хариу байдаггүй. Санамсаргүй модон дээр аавынхаа сийлсэн бичгийг олж хараад нулимс асгаруулав. Түүний эцэг ертөнцийн эд хөрөнгөнд тэмүүлж байгаагүй.

Хaan энэ газар луу нүүн ирж, сүнсний бясалгал дадуулагч болсон билээ. Тэр модон дор бясалган суусаар эгэл өртөнцийн явдлыг сонирхохоо больсон бөгөөд өртөнцийн эд баялгийг ч мөн адил. Хaan ширээгээ ч буцааж авахыг ер хүсээгүй, ард түмнээ дайсны гарг хэрцгийгээр алуулахгүй гэж, тэднийхээ зовлонг багасгах гэж л хааны ордныг ямар ч эргэлзээгүй орхисон билээ. Гэтэл одоо хүмүүс ирж, түүнийг барьж алахыг хүсэж байна. Энэ эгэл өртөнцийн амьдралаар явж байгаа хүмүүс хэтрхий аймшигтай, маш хэрцгий юм гэдгийг ханхуу мэдрэв.



Хаан, ханхүү хоёр ойр орчиндоо нэг ч хүнгүй зэлүүд нутагт зэрлэг жимс идэж, гол горхиноос усыг нь шууд ууж, иймэрхүү маягтай амьдарч байсан. Тэд тайван амгалан амьдарч байтал хүмүүс ирж, тэднийг барьж алахыг хүсэж байна. Тэгээд ханхүү энэ өртөнцийн балмад хэрцгийн байдлыг ойлгож чадахгүй учраас үйлж эхлэв.

Чан-Шөү хааныг баригдаад нийслэл рүү хүргэгдэхэд эх орныг нь булаан авсан дайсны хаан түүнийг алахаар цаг алдалгүй гал өрдсөн байжээ. Нутгийнх нь хэсэг хүн цаазаар авах газрын эргэн тойрон цугларчээ. Тэд маш их гунигтай байсан тул нулимын дуслуулан байв. Хаан нь сайн хаан бөгөөд ард түмэндээ хайртай гэдгийг тэд мэдэж байсан учраас тэр. Хүмүүс зөвхөн хааны ухлийн төлөө уйлж байсан юм биш, түүнийг сайхан сэтгэлтэй, зан ааш сайтай, ес суртахуунтай, хайраар дүүрэн хүн гэдгээс нь болж уйлж байлаа. Ханхүү тэр уйлан гашуудаж байгаа хүмүүсийн дунд нуугдаж байв. Эцэг нь ханхүүг ууландаа үлдээд бясалгалаа үргэлжлүүлэхийг хүссэн ч эцгийгээ сүүлчийн удаа ч болов харахгүй байж тэсэлгүй иржээ.

Ханхүү чангын уйлж зүрхлэхгүй байлаа. Тэр эцэгтээ гараараа дохио өгч, хаанд өөрийгөө энд байгаагаа мэдэгдэв. Энэ үед

цэргүүд гал тавилаа. Хаанд үхэл нүүрлэлээ. Хаан ханхүүг харах үед нүдэнд нь үзэн ядалт дүрэлзэж байсанд ихэд түгшиж, түүнийг буруу үйлдэл хийх нь гарцаагүй болсныг мэдрэв, яагаад гэхээр эцгийнхээ үхлийн төлөө өшөө авах гэсэн туйлын хүсэлтэй байгааг хаанд зүрх нь хэлж байлаа. Чан-Шөү хаан хүүдээ зөвлөхийг хүсжээ.

Үхэж байхдаа тэрээр хүүдээ юм хэлэхийг оролдож байлаа. Гэвч тэр хүүгийнхээ зогсож байсан зүг хандан ярьж зүрхлэлгүй тэнгэрт хандан ийнхүү хэлжээ: “Чан-Шэнь чи үзэн ядалтаа хайраар арилгах хэрэгтэй. Чи сэлмийг сэлмээр буцаах ёсгүй. Чи үзэн ядалт, хүчирхийллийн тухай бодолгүйгээр Гэгээнтэн болон Бодьсадва шиг өршөөл нигүүсэл, хайраар дүүрэн амьдралаар амьдрах ёстой”.

Тэгтэл галын хүчтэй дөл нөмрөн авч хаан үхэв. Харин ханхүү ухаан алдан унасан байв. Түүний уур хилэн буцалж, зүрх нь эмтрэх шиг боллоо. Энэ үед тэр дөнгөж арван дөрөвхөн настай байжээ. Эцгийнхээ тарчилж үхсэний гэрч болоход тэр дэндүү бага байлаа. Эцгийг нь харгис хэрцгийгээр алж байхыг хараад юу мэдэрч байсныг та нар төсөөлж чадах уу. Мэдээж үүнийг тэвчиж чадахгүй. Эцгийнхээ үхлийг санах тусам өшөө авах хүсэл нь улам их буцалж байв. “Тэр хүн манай газар нутгийг эзэлж авчхаад бас эцгийг минь аллаа. Түүнээс өш хонзонгоо авах нь эргэлзээгүй. Би тэгэх ёстой” гэж тэр бодно.

Түүний оюун ухаан алах санаанд бүрэн автаж, өөр юу ч бодох зай үлдээсэнгүй. Тэр өлсөж дааран хоноглох газар ч үгүй байлаа. Тэрээр даарах, өлсөх, бэрхшээлтэй тулгарах хэрээрээ уурлаж, өшөө авахыг хүсж байв. Ингээд дайсны хааны ойр очих боломжтой төлөвлөгөө гаргажээ.

Тэр нийслэл хотод амьдрахын тулд ажилд орохыг хичээв. Дайсны улсын сайд түүнийг санамсаргүй олж харжээ. Сайд түүнийг сайн тамир тэнхээтэй залуу хүн байна гэж бодоод ногоо тарих, цэцэг услах, бас цэцэрлэг арчлах ажилд туслуулахаар хөлслөн авжээ. Ханхүү маш хичээнгүй, шаламгай байлаа. Тун удалгүй сайдын гэр бүлийнхэн түүнд итгэдэг болов. Сайд болон түүний бүх албат ханхүүд хайртай болж, онцгой эрхтэй нэгэнтэй харилцаж байгаа мэт сайн хандаж, олон зүйлийг түүнд хариуцуулдаг боллоо. Сайд тэр залуу хүүг Чан-Шэнь ханхүү гэдгийг огтхон ч төсөөлсөнгүй, учир нь ханхүү нүүрээ сайтар будаж, гадаад төрхөө өөрчилсөн байжээ.

Нэг өдөр сайд ханхүүгээс асуусан нь: “Миний аль хэдийн олж мэдсэнээс гадна өөр ямар авьяас чамд байна вэ” гэв.

“Би хоол сайн хийдэг” гэж ханхүү хариулжээ.

Тэр үнэхээр хоол сайн хийдэг байжээ. Сайдын өргөөний ямар ч тогоочоос илүүгээр хоол сайн хийнэ. Тиймээс сайд ханхүүг бүүр ч их таашаасаар байв. Сайд Чан-Шэнь ханхүүгээр их бахархаж байсан тул хааныг хоол идэхийг урьжээ. Тэрээр шинэхэн тогоочийнхоо хоол хийх чадвар болон оюун ухааныг нь магтан гайхуулах санаатай байж л дээ. Хааныг ирэх өдөр болоход ханхүү хаанд зориулан хамгийн сайхан амттай, нарийн хоолоо бэлтгэхийг хичээв. Хийсэн хоол нь махан, эсвэл ногоон хоол байсан эсэхийг би мэдэхгүй. Шинэ хаанд Чан-Шэнь ханхүү залуу хүнийхээ хувьд ч, хоол хийх чадвар нь ч аль аль нь маш их таалагджээ. Тэгээд хаан сайдаасаа “Түүнийг надад өгчих л дөө” гэж гуйв.

Хаан Чан-Шэнь ханхүүг өөртөө зориулан хоол хийлгэж байх, мөн өөртөө ойр байлгахын тулд сайдаас гүйжээ. Мэдээж хэрэг, сайд энэ хүсэлтээс нь татгалзаж зүрхлэхгүй; түүнд өрийн хамгийн хайртай, итгэлтэй албатаа хаанд өгөхөөс өөр сонголт байсангүй. Ингээд ханхүү Чан-Шэнь хааны тогооч болжээ. Ханхүү Чан-Шэнь аль болох хааны итгэлийг олж авахын тулд өдөр бүр хааныг баярлуулж, сайхан хоол хийж өгөхийг хичээж байв. Хаанд хамгийн сайнаар үйлчлэн хашир хянамгай байж, бүх зүйлийг хүндэтгэлтэй, болгоомжтой хийж байлаа. Хаан улам улмаар түүнд итгэлтэй болсоор байв.

Ханхүү Чан-Шэнь маш ухаалаг сэргэлэн бөгөөд дэндүү их авьяастай учир хаан түүнд улам их сайн болжээ. Ийнхүү ханхүү хааны хамгийн итгэлтэй хүн нь болж улмаар бие хамгаалагч нь болов. Тэр бараг бүх зүйлийн талаар Чан-Шэний зөвлөгөөг авах болсон байна. Ханхүү энэ ордонд төрж өссөн болохоор ордны талаар олон зүйлийг сайн мэддэг байжээ. Аливаа зүйлийг хэрхэн зохион байгуулах, тэнд юу болох ёстойг мэддэг байв. Тэр бүгдийг зохицуулж чаддаг байлаа.

Нэг өдөр ханхүүгийн удаан бодож хулээсэн тэр өдөр иржээ. Хаан ан гөрөө авлахаар явахдаа ханхүү Чан-Шэнийг авч явжээ. Хаан ан амьтдын араас хөөсөөр уулын гүн лүү орчихжээ. Хаан хамгийн сайн морио унаасан учраас бусад бүх дагалдагч нь хажуунаас нь хол хоцров. Хаан болон ханхүү Чан-Шэнь хоёр л олзны хойноос хөөсөөр уулын гүн лүү орсон байна. Ханхүү уулнаас гарах замаа мэдэж байсан боловч энд хааныг үгүй хийх гэж зориуд төөрүүлжээ. Тэгээд яаж явахaa мэдэхгүй юм шиг дүр үзүүлж байв.

Тэд замаа ололгүй байсаар шөнө болжээ. Хаан дэндүү их

ядарсан байх. Иймд хэвтэж амрахаас өөр аргагүй болов. Эргэн тойрон өндөр модод, хэцүү бэрх нарийхан зам харгуй нь өөр өөр зүг рүү хөтөлж байв. Ханхүү Чан-Шэнь хааны дэргэд түүнийг “хамгаалах”-аар сэлмээ атган зогсоно. Одоо Чан-Шэнь ханхүүд ховор тохиолдох аятайхан боломж гарч ирэв. Чан-Шэнь гүн нойрондоо автсан дайсан луугаа хяламхийн өөртөө сануулж байв. Хаан Чан-Шэний дэргэд бөх, тааламжтай унтаж байлаа. Уураг тархи нь: “Тэр эцгийг чинь алсан, хаан ширээг чинь булаасан. Чи түүнийг түргэхэн үхэл рүү нь илгээх ёстой” гэж түлхэн шавдуулна.

Хаан Арыяабалын аргаар бясалгадаггүй ч гэсэн тэр удахгүй чөлөөлөгдөх нь! Мөдхөн түүнийг сэлмээрээ хоёр хэсэг болгочихвол болоод явчихна. Ханхүү Чан-Шэнь тээнэгэлзэв. Тэрээр эцгийнхээ зөвлөгөөг санав, гэвч тархи нь дахин сануулж: ”Чи юугаа хүлээгээд байгаа юм бэ? Хурдан түүнийг ал!” гэлээ.


Тархи бол ийм л байdag. Уураг тархи биднээр үргэлж муу юм хийлгэх гэж албадаж байdag, үгүй гэж үү? Чан-Шэнь шиг бясалгагч хүртэл үүнээс зугтах аргагүй.

Тэр тийм залуудаа эцэгтээ тохиолдсон явдлын гэрч болсон учраас энэ явдлыг ёс бус гэдгийг мэдэрч байв.

Ханхүү Чан-Шэнь сэлмээ суга татан бэлэн боллоо. Тэр хогийн ургамал цавчих гээгүй! Харин хааны билгийн мэлмийг цоо хатгах гэж төлөвлөжээ. Гэнэт эцгийг нь хайр найргүй шатаасан дүр зураг дурсамжид нь тодрон гарч ирэв. Тэр үед эцэг нь хайр энэрэл дүүрэн нүдээр харж, түүнд: “Хүү минь чи үзэн ядалтаа хайраар угаах хэрэгтэй. Чи Буддагийн замаар явж, хайр болон нигүүлсэнгүй сэтгэлээр дүүрэн байж сурах ёстой. Чи харгис хэрцгийн хандаж болохгүй” гэлээ.

Ингэж бодсоноор зүрх нь зөөлөрч, нигүүлсэнгүй болов. Тэрээр “Би эцгийнхээ сүүлчийн хүсэлтийг үл тоомсорлож яаж болох вэ? Хэрэв би ингэвэл хүү нь биш болно” гэж бодов.

Эцэг нь хэчинээн энэрэл нигүүслэлтэй, өрөвч сэтгэлтэй байж вэ. Тэрээр үүний эсрэг юм хийхийн оронд эцгийнхээ үлгэр



жишээг дагах ёстой. Ингэж шийдээд ханхүү сэлмээ аажмаар хуйнд нь буцааж хийлээ. Тэгээд тэндээ зогсоод цурхиран уйлав. Тэгтэл шинэ хаан нүдээ нээж Чан-Шэнь ханхүүд “Би сая муу зүүд зүүдэллээ. Нэг хүн намайг алах гэж байхыг би харсан” гэж хэлэв.

Чан-Шэнь ханхүү “Хүйтэн газар унтсанаас хар дарж зүүдэлсэн байх аа. Би таныг хамгаалж байгаа учир хэн ч халдаж зүрхлэхгүй” гэж хариулав.

Шинэ хаан ч аюулгүй байдлыг мэдэрч, эргээд амрахаар хэвтлээ. Ханхүү Чан-Шэнь хамгаалан зогсож байв. Эцгийгээ хэрцгийгээр хөнөөсөн тухай бодонгуут дахин үзэн ядалт нь бадрав. Тархи нь түүнийг түлхэж “Түүнийг ал, түүнийг ал, түүнийг ал. Тэр чиний эцгийг алсан, чи өшөөгөө авах ёстой!” гэж байв.

Ингэж тархи нь ахин дахин муу юм руу түлхэнэ. Тэр сэлмээ сугалж, өндөрт өргөж, бараг хааны толгойд буулгав. Гэтэл эцгийнх хэлсэн үг ахин эргэж санагдав: “Чи ийм хэрцгийг байж болохгүй. Үзэн ядалтыг хайраар угаан арилгах хэрэгтэй... гэх мэт”.

Тэр мэдрэхүйтэйгээ тэмцэж чадахгүй байснаас уур нь ихэд хүрч, чанга хашхирмаар санагджээ. Тэгээд ханхүү хаанд хандан: “Чи хамгийн харгис дайсан, би чамайг уучиллаа. Эцгийнхээ төлөө, түүний нигүүлсэнгүй хайрын төлөө би чамайг уучиллаа!” гэв.

Дараа нь сэлмээ хуйнд нь буцааж хийсэнд дахин хэзээ ч тэндээсээ гарч ирээгүй аж. Өршөөл нигүүслэл үзэн ядалтыг яллаа. Гэнэт хаан дахин сэрлээ! Тэр үргэлж л амиа алдах шахсан үедээ сээрээд байв. Тэрээр “Эрхэм хүндэт минь, би дахиад нэг муухай зүүд зүүдлэв. Өмнөх хааны хүү миний нүгэл хилэнцийг уучиж байна гэж зүүдэллээ. Тэр өшөө авахаа больсон. Энэ зүүд ямар утгатай болохыг чи мэдэх үү?” гэж хэлэв.

Чан-Шэнь ханхүү нүд дүүрэн нулимстайгаар хаанд хандан “Би өмнөх хааны хүү байна. Миний эцэг чиний тушаалаар шатаж үхэх үедээ үзэн ядалтыг үзэн ядалтаар хариулж болохгүй, үзэн ядалтыг хайраар угаан цэвэрлэ гэж надаас гүйсан юм. Тэр намайг хайр, өршөөл нигүүслэлтэй Буддагийн замыг дагаж, хамаг амьтантай ийм сайхан хайраар харилцаж байхыг хүссэн юм. Би таныг алахаар төлөвлөж байсан боловч ингэж чадсангүй” гэв.

Хааны сэтгэл харамслаар дүүрчээ. Тэр Чан-Шэнь ханхүүг зуурч, орь дуу тавин уйлав. Улмаар хамтдаа дуу тавин уйлалдлаа. Хаан: “За яах вэ, чи эцгийнхээ өшөөг авч намайг алж болно. Чи

үүнтэй дахин тэмцэж, өөрийгөө хэтэрхий их зовоож шаналгах шаардлагагүй” гэж хэлэв.

Ингээд хааны чулуу шиг төрх зөвлөөд явчхав. Тэр тодорхой хэмжээгээр гэгээрчээ. Тэр Чан-Шэнь ханхүүд алуулахад бэлэн болов. Тэр бас хайрын мэдрэмжээ илчилж, түүний зорилгыг цаашид удаан хорьж байхыг хүсэхгүй байлаа. Үүнд нь ханхүү Чан-Шэний сэтгэл их уярчээ. Тэрээр “Үгүй ээ, эрхэм Дээдэс ээ, би таныг алахыг хүсэхгүй байна. Надад тушаасан ч гэсэн би ингэж зүрхлэхгүй. Намайг залхаан цээрлүүлээч, гуйя” гэжээ.

Хоёр эр бие биенийгээ алахгүй гэж шийдээд ихэд тайвшрав. Тэд гэнэт гэгээрчээ. Яг л нар мандахад доторх харанхуй алга болсныг тэд мэдрэч байв. Энэрэл нигүүслэлийн гэрэл өртөнцийг бүхэлд нь гэрэлтүүлэх шиг болов. Хаан толгойгоо барин ханхүүд учруулсан миний нүгэл дэндүү их байтал тэр юутай уужим сэтгэлтэй, ямар нигүүлсэнгүй юм бэ? Гэж бодож байлаа. Mash их ичжээ. Гэнэт хаан ямар нэг зүйлийг ухаарсан бөгөөд үүнээсээ болж, маш их баярлав. Тэрээр гэгээрээд Чан-Шэнь ханхүүд “Эрхэм хүндэт минь, өнөөдөр би энэ өртөнц дэх хамгийн сайхан зүйл юу вэ? Гэдгийг олж мэдлээ. Дайн байлдаан болон үзэн ядалт бол харгис хэрцгий нүгэл хилэнцтэй явдал аж. Зөвхөн хайр л жинхэнэ эрдэнэ юм байна” гэж хэлжээ.

Чан-Шэнь ханхүү хааныг замчлан ой модноос гаргав. Тэнд дээд түшмэд нь сэтгэл түгшин хүлээж байлаа. Тэд хаан хаашаа явсныг мэдэх ямар ч боломжгүй байжээ. Хаан, Чан-Шэнь ханхүү нар нийслэлд буцааж ирсний дараа хаан түшмэдээсээ “Өмнөх хааны ханхүү хаана байгааг та нар мэдэх үү?” гэж асуужээ. Мэдээж нэг ч хүн мэдэхгүй байлаа. Хаан Чан-Шэнь ханхүүгийн гарыг өндөрт өргөн “Энэ бол тэр! Тэр бол өмнөх хааны хүү. Тэр мөн миний удирдагч. Тэр намайг алаагүйгээр барахгүй, надад маш сайн сургамж өглөө. Түүний ачаар би өмнөх хааныхаа уужим сайхан сэтгэл, эрхэм дээд ёс суртахууны чанарыг ухаарч авлаа. Би түүний үлгэр жишээг дагамаар байна” гэж хэлжээ.

Тэгээд хаан өөрийн улсдаа буцан очиж, улс орноо хайраар захираг болсон байна. Бас эзэлж авсан газар нутгаа Чан-Шэнь ханхүүд буцааж өгсөн бөгөөд Чан-Шэнь ханхүү эцэг шигээ нигүүлсэнгүй сэтгэл, хайраар улс орноо удирдан залах болсон билээ. Түүний улс орон улам цэцэглэн хөгжиж, амар амгалан болжээ. Ийнхүү манай өртөнцийн зовлон зүдүүр дахин нэг булангаар багасаж, бас нэг ч атугай гэгээлэг, амар амгалан газар бий болсон байна. Энэ түүх ингэж төгслөө.

Шагжамуни Буддагийн өмнөх төрөл нь Чан-Шөү хаан юм.

Тэр ингэж ярьсан. Ханхүү Чан-Шэнь бол Ананда байсан бөгөөд дайсан улсын хаан бол Девадаттагийн өмнөх төрөл мөн. Тэр Шагжамуни Буддаг үргэлж зовоохыг хичээж байдагт гайхах юм алга. Төрөл болгондоо тэр түүнийг алах гэж хичээж байжээ. Шагжамуни Буддагийн явсан газар бүхэнд Девадатта түүнийг үргэлж алахыг хичээдэг байсан.


БҮХ ЗҮЙЛ АМНААСАА БОЛДОГ

Эрт дээр үед нэгэн нуурын ойролцоо хоёр фламинго, нэг яст мэлхий дотно нөхөрлөн амьдардаг байжээ. Тэр жил ган гачгаас болж усгүй болсон байна. Бүтэн жилийн турш бороо ороогүй учраас нуурын ус өдрөөс өдөрт улам багассаар, ингээд ямар ч усгүй боллоо. Нар ердийнхөөсөө илүү халж байх шиг байв. Хамаг л өвс ногоо, мод бут өнгөө өөрчилж, кофеных шиг бараан өнгөтэй болжээ. Яагаад гэвэл нар дэндүү халж байсан учраас хэтэрхий багассан нуурын ус нь халчихжээ. Ингээд аквариумд амьдрагсад нэг нэгээрээ нирваанд одож байлаа.

Одоогийнхoo энэ байдалд яст мэлхий их л амгалан бус болж, юу хийвэл зохих талаар толгойдоо элдвийн юм үргэлж боддог болов. Тэр энэ нөхцөл байдлаас чөлөөлөгдхийг маш их хүсэх болжээ. Тэр бодоод л, бодоод л байж! Тэгтэл азаар өнөөх хос фламинго зочлон ирэв. Ийм өрөвдөлтэй гэгээрсэн царайтай, ийм өрөвдөлтэй гэгээнтний баг зүүсэн байхыг нь хараад машид найрсаг, сэтгэл нь зовсон шинжтэй, эелдэг хайраар “Юу болоо вэ? Чамд юу тохиолдоо вэ? Яагаад чи ийм өрөвдөлтэй харагдана вэ?” гэж асуужээ.

Яст мэлхий тэдэнд “Өө! Өө! Та нар юу ч мэдэхгүй байна! Би маш их зовлонд учраад байна! Аяа! Би бараг үхэх нь ээ. Та нарыг дахин харна гэж бодохгүй л байна. Хрр...” гэлээ.

Тэгэхэд нь нөхөр фламинго яриаг нь таслан “Бид хоёр удаан хугацааны турш сайн нөхөд байлаа. Энэ урт хугацаанд зовлон жаргалaa хуваалцсаар ирсэн билээ. Чамайг юу ингэж бухимдуулж, зовоож байгааг бидэнд мэдэх боломж олгооч. Чамайг энэ өрөвдөм байдлаас чинь гаргаж аврахын тулд бид боломжийнхoo хэрээр туслах нь гарцаагүй. Бид ямар асуудал байгааг мэдэхгүй байна,



тэгээд ч чи аль хэдийнээ итгэл алдран урам зориггүй болсон байна. Чи битгий ингээч ээ. Асуудал болгонд шийдэл байдаг шүү дээ” гэв.

Үнэхээр ухаалаг сонсогдож байна. Тэр Арьяабалын аргаар бясалгадаг байж магадгүй. Гэгээрсэн фламингонууд. За! Болж дээ! Тэгээд цааш нь харцгаая.

Яст мэлхий гүнээ шүүрс алдаад “Та хоёр надад зориулж юу хийж чадахыг би мэдэхгүй байна. Гэвч... нэлээн олон хоног... би нарны хүрднийхээ төв рүү юу ч хийж чадсангүй. Миний хийж чадах бүх зүйл гэвэл нарны хүрдний төв дээрээ бясалгах явдал юм. Ямар ч гэгээрэл алга. Ингээд л би үхэх нь гэж бодох боллоо. Ёох! Дусал ч усгүй, загасгүй, мэлхийгүй, юу ч байхгүй. Би үхэх нь. Эсвэл ковбойнууд намайг олоод шөлөндөө хийчих биз... Нэг удаа таван жилийн өмнө тэдэнд баригдсан юм. Азаар тэнд буддын шашинд итгэдэг хөгшин хатагтай байсан. Тэгээд тэр эмэгтэй намайг худалдаж аваад нуур луу буцааж тавьсан юм. Хэрэв дахиад баригдах юм бол Amitaba намайг аварч чадна гэдэгт би итгэлтэй биш байна. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай л чадаж магадгүй. Гэвч би Түүнийг сорьж үзээгүй, мэдэхгүй байна. Ёох! Сүүлчийн зугталтынхаа тухай бодох болгонд миний хуяг тэр чигээрээ арзайх шиг болдог” гэж хэлжээ.

Тэгээд нөхөр Фламинго нь энэ асуудлыг шийдэхийн тулд ихэд эргэцүүлэн боджээ. Хөмсгөө зангидах, хөлөө завилан далавчaa хөл дээрээ тавьж, фламингогийн байрлалд оров, билгийн нүд нь эргэцүүлэл бодлоосоо болж харанхуйлж байлаа. Бас эхнэр фламинго нь яст мэлхийг машид өрөвдөж байв. Тэгтэл эр фламинго “Чи яагаад өөр газар нүүж, гэр орноо нүүлгэж болохгүй билээ?” гэж хэлжээ.

Нэн их зовж байгаа яст мэлхий хариуд нь: “Төсөөлөөд үз дээ, би хэзээ ч өөр газар очиж үзээгүй. Надад машин ч байхгүй. Миний хөдөлгөөн тийм ч хурдан биш гэдгийг та нар мэдэж байгаа. Машингүй бол би яах вэ? Түүнээс гадна би төрөлх хотдоо хайртай. Би өөрийн нутагтаа үхсэн нь дээр байх даа. Харийн газар оршуулагдах болвол сүнс минь тайван амгалан байна гэж та нар бодож байна уу?”

Гэнэт нөхөр фламинго урт хүзүүгээ өргөж: “Надад нэг санаа байна. Би түүнийгээ хэлмээр байна, гуйя” гэж хэлэв. Итгэл найдвар, урам зоригоор дүүрэн тэрээр үргэлжлүүлэн: “Аан! Бүү ай, айх хэрэггүй. Эндээс 10 бээрийн цаана бадамлянхуа цэцгийн цөөрөм байдгийг би мэднэ, тэр цөөрөм хэзээ ч ширгэдэггүй гэдгээрээ алдартай. Манай энд иймэрхүү ган гачигтай байхад ч

тэнд хэзээ ч ширгэж байгаагүй. Бид чамайг тэнд аваачья. Тэгээд бид чамтай хамт байх учир чи ч ганцаардахаа болино. Бид уруудсан ч, өөдөлсөн ч чамтай хамт байх болно. Ингэвэл зөв биз дээ?”


Яст мэлхий бодолд автаж гэнэ ээ. Тэр ер нь бодохдоо ч маш удаан. Тэр яст мэлхийн маягаараа, гэхдээ билиг ухаанаараа бодов. Энэ тухай тэр хагас цагийн турш эргэцүүлэн бодсон байх. Яст мэлхий ер нь их удаан байдаг. Тэрбээр “Би чинь одоо арван бээр байтугай арван метр ч явж чадахгүй. Надад идэх юм байхгүй. Арван метр ч явж чадахгүй байхад юун арван бээр!” гэв.

Тэр үхэх гэж байгаа юм шиг харагдах аж. Тэгэхэд нь фламинго: “Бүү санаа зов! Бид бүгдийг мэдэж байна. Бид чамайг зөөнө. Чамд бид агаарын тээврийн нэгдүгээр зэргийн билетийг захиалах болно. Бүү санаа зов, бүү санаа зов. Гэхдээ нэг болзол байна. Чи бидний төлөвлөгөөг анхааралтай сонс. Тэгвэл бид үүнийг хийж чадна” гэлээ.

Яст мэлхий сүрхий нухацтай сонирхох болов. Тэр “Тэгье, тэгье, гуйя” гэж хэлэв. Одоо тэр хурдан болсон байлаа. Тэр хагас цагт биш, хорин минутанд л ингэж хэлжээ. “Надад хэлээч, гуйя”.

Фламинго: “Энэ бол маш энгийн. Бид хоёр уяа олж авчраад хоёр үзүүрийг нь зууна, чи голоос нь зууна. Тэгж бид чамайг зорьсон газар руугаа зөөнө. Гэвч чи аяллын турш амаа нээж ердөө ч болохгүй гэдгийг мэдэж байх ёстой шүү. Үгүй бол энэ их аюултай байх болно. Хуяг чинь гэмтэж, нэг газар нь хонхорхой үүснэ, эсвэл бяцалсан нухаш, яст мэлхийн нунтаг болж мэднэ шүү. Энэ хооронд юу болсон ч, сэтгэл чинь яаж ч хөөрсөн, хичнээн уурласан ч, эсвэл чамайг өдөөн хатгасан ч чи амаа хэзээ ч нээх ёсгүй шүү. Тэгвэл хагас цагийн дараа бид тэнд очсон байх болно. Тиймээс санаж аваарай” гэжээ.

Фламинго бас дахин: “Шүдээрээ зуугаад ярьж болохгүй гэдгийг сайн сана. Тэр бүү хэл эвшээж ч болохгүй. Ердөө апчихий ч (найтааж) гэж болохгүй. Бид зорьсон газраа хүрэн хүртэл өөрийгөө хянаж тэвчээртэй байх ёстой шүү. Бүх юм тодорхой, бэлэн болсон, ойлгомжтой, бэлэн байгаарай, амжилт хүсье!” гэв.



Тэгээд тэр хоёр уяаны хоёр талаас, харин яст мэлхий дундаас нь зуув. Тэд нэг газраас нөгөө рүү шилжиж байв. Тэд бидний хамгийн сүүлд Калифорнид очсон байх үсийнх шиг нэг, хоёр долоо хоногийн дараа бүгд ногоон болсон кофены хатаасан өвс болон ногоон бэлчээр, улаан цэцэг дээгүүр нисэж байв. Байгалийн үзэсгэлэнт газрууд жирэлзэн өнгөрнө. Яст мэлхий энэ бүгдэд баясан гэр орноо ч мартаажээ. Хүрээлэн байгаа орчныг магтан гайхад гэж хэд хэдэн удаа амаа нээх шахаж байв! Өө! Гайхамшигт гацуур модод! Сайхан чапати! Амттайхан Энэтхэг цай! Ау-Лакын хөөрхөн бүсгүйчүүд! Хятадын сайхан дуур хуур! Сайхан ус! Гэвч тэр санаж л явлаа. Фламингогийн хэлснээр ямар ч шалтаг гарсан амаа нээх ёсгүй шүү гэдгийг санаж байлаа. Ийнхүү хянамгай байж, амандаа хамаг анхаарлаа тавьж, ер нээсэнгүй.

Гэвч...ийм зүйлд дандаа л “гэвч” байдаг. Гэвч тэднийг нэгэн тосгоны дээгүүр нисэж явахад тэнд хүүхдүүд байж байв. Та нар хүүхдүүдийг мэднэ шүү дээ, үргэлж л дүрсгүйтэж байдаг даа. Тэд хоёр фламинго болон яст мэлхийг хамтдаа нисч байхыг хараад хашгирч, цовхчиж, яст мэлхийг шоолж эхлэв. Одоо яст мэлхий цааш тэвчишгүй боллоо. Хэзээ ч ийм өндөр настай болтлоо амьдрах хугацаанд нь хүмүүс болон өөр хэн ч ингэж, эдэн шиг түүнд бүдүүлэг авирлаж байгаагүй. Түүний би гэх үзлийг хөнджээ! Түүний өөрийгөө үнэлэх үнэлэмж нь шавхагдаж, билиг ухаан нь самуурав. Өөрөөрөө бахархах бахархал нь та нарын шарах шүүгээнд хоол хийхдээ хоёр зуун градус халаадагтай адил буцлав. Ингээд яст мэлхий нүдээрээ доош газар луу хялалзаж, амаа нээн “Амаа тат! Та нар амаа хамхи!” гэлээ.

Тэр дөнгөж ингэж хэлээд л цаашид яст мэлхий байхaa болилоо! Тэр чөлөөлөгдлөө! Хүягнаасаа саллаа!

Тиймээс Будда: “Энэ хорвоод олон хүн яг үүн шиг амаа хамхиж чадаагүйгээсээ болоод гай зовлонд өртдөг. Тийм учраас та нар зөвхөн шаардлагатай үед л ярьж байхыг анхаарч аваарай” гээж хэлсэн байдал. Энэ үлгэрийг санаж яв.



ИХ БАГШИЙН ХҮЧИНД ИТГЭ

Э нэ бол Энэтхэг үлгэр. Сүнслэг бясалгалаар маш сайн бясалгадаг нэгэн эмэгтэй байжээ. Түүнийг маш их хайлаж, хүндэлдэг байсан тул олон хүн түүнд атаархдаг байв. Хаан хүргэл түүнд атаархдаг байж. Олон хүн түүнийг сайн бясалгадаг гэж сонссон боловч эмэгтэй хүн тийм сайн бясалгаж чадна гэдэгт үнэмшдэггүй байлаа. Тиймээс хаан түүнийг шоглох гэж ордондоо авчрахыг хэн нэгнээс хүсэв.

Дарамт, шахалтад автсан ийм нөхцөлд тэрээр энэ хүнд байдлаас зугтахыг хичээж байлаа. Тэр хамаг л ухаан санааныхаа хэрээр хичээсэн боловч талаар болжээ. Заримдаа тэр ганц хоёр удаа Их Багшийгаа санаж дуудаж байв, ер нь зуршил болсон байснаас л тэгснээс, харин чин сэтгэлээсээ дуудсан юм биш байж. Тэрээр Их Багш нь түүнийг хамгаалж чадна гэдэгт бүрэн итгэлгүй, өөрийн хүчээ дайчлан хичээсээр байлаа. Их Багшаасаа тусламж гүйж байхдаа тэрээр бүхнийг Их Багшдаа даатгаагүй, бас чин сэтгэлээсээ гүйгаагүй тул өөрөө л тэмцэлдсээр л байв. Ийм учраас түүний Их Багш илрэн гарч ирэхгүй байжээ.

Эцэст нь тэр өөр юу ч хийж чадахгүй болон бууж өгөөд чин сэтгэлийн угаасаа Их Багшдаа итгэж найдан: “Одоо юу болсон ч хамаа алга, Их Багш минь, энэ бүхнийг зохицуулж өгөөч” гэж гүйжээ.

Тэр агшинд Их Багш нь гэрлэн биеэрээ илрэн гарч ирээд даруй түргэн түүнийг аварсан байна.

Хэрэв бид хүч чадалтайгаа тэмцэлдэх юм бол энэ нь ихэвчлэн нэн хэцүү байдал. Их Багши гэж хэн бэ? Үнэндээ энэ бол бас өөрсдийн маань хүч, бүхнийг мэдэгч, хaa сайгүй оришигч, бүхнийг чадагч, хамгийн дээд Би, төгс Би юм. Хэрвээ бид оюун ухаанаа ашиглаж байвал бид зүгээр л энэ доод ухамсартаа, зөвхөн өнгөрсөн туршилагадаа тулгуурлана гэсэн уг. Жишээ болгоход: “Надад гарцаагүй байдал тулгарсан үед би юу хийх ёстой вэ? Зарим төрлийн хүнтэй тулгарах үед ямар хариу үйлдэл хийх ёстой вэ? Би өмнө нь ийм зүйлтэй тулгарч байсан, үүнийг яаж зохицуулах ёстой вэ?” Энэ бүхэн бидний оюун санаанд хадгалагдсан өнгөрсөн туршилагыг л ашиглаж байгаа хэрэг. Гэсэн хэдий ч нөхцөл байдал өөр байдал тул өнгөрсөн туршилага маань заримдаа үүнээс өөр гэдгийг та нар мэдэж авах ёстой. Заримдаа өчүүхэн төдий ялгаа нь үүнийг огт өөр болгочихдог.



ГЭГЭЭРСЭН ШИДЭТ ДАГИНАС

Э нэтхэгт нэгэн үлгэр байдаг. Хятадад үүнтэй адил үлгэр байдаг шиг санагдаж байна. Нэг өдөр Тамын Хаан томоохон үдэшлэг зохиож, түүндээ өдий төдий сүнс сүг, бурхан, шидэт дагинаыг хамтдаа хооллоё гэж урьсан аж. Тамын Хаан маш дэгтүй (энэ бол түүний угийн зан чанар нь). Тэр зориудаар хамаг амттан, нарийн хоолоо ширээнийхээ голд нь тавиад сандлыг нь ширээнээсээ хол, их зайдуу, түүнчлэн хоолтой таваг дотор урт гэгчийн халбага тавьсан байжээ. Диваажингийн тоор, усан үзмийн дарс гэх мэт та нарын бодож чадах элдэв төрлийн амтат хоолыг уул, далайгаас сонгон авчирсан байжээ. Энэ нь үнэхээр гайхалтай, сэтгэл сэргэм, чамин гоё, хүн бүхний арааны шүлс асгарам тансаг сайхан зассан ширээ байлаа.

Хэдий тийм боловч Тамын Хаан нэг болзول тавьсан нь: хоол идэж байхдаа тохойгоо нугалж болохгүй ажээ. Ердийн үед хүн хоол идэх үедээ тохойгоо нугалдаг. Халбага нь маш урт, ширээ нь тээр хол, тохойгоо нугалж болохгүй гэсэн хэдий ч тэр бүхнийг бүгдийг нь идэж болно гэж байх юм гэнэ. Тэр сүнс сүг болон астрал амьтад Тамын Хааныг зэмлэн гомдоллож, хэрэлдэж, загнаж байгаад сүүлдээ бүгд өөр өөрийнхөө замаар яваад өгчээ! Зөвхөн шидэт дагинас үлдээд ямар арга байж болохыг бодож олжээ. Тэд даруй ойлгожээ! Тэгээд бие бие хүүхэд хооллож байгаа юм шиг хооллож эхлэв. Тиймээс дүрмийн зөрчил гаргалгүй, тохойгоо нугалалгүйгээр идэж чадсан байна. Сүнс сүг болон гэгээрсэн шидэт дагинасын хоорондох ялгаа нь энэ л юм.


Бидний жирийн хүмүүсийн хувьд идэж чадахгүй бол сүйрэл болсон шиг санагдажс, бусад хүн ч бас идэж чадахгүй болно. Үүний үр дүнд аль аль нь идэж чадахгүй. Энэ бол Маяагийн онцлог чанар. Хэдийгээр бид хүний биетэй боловч бидний зарим нь Маяа



шүү. Хэрэв бидний үйл хэрэг *Маяагийнх шиг* бол бид *Маяа л гэсэн уг*. Бусдад өөрийгөө зориулах сэтгэл байхгүй бол бид *юу ч олж авч чадахгүй*, бусад *хүн ч бас адуулхан - харин тэнд зөвхөн сүйрэл байна*. Яг л тэр *сүнс сүгүүд бие биеэ халамжилдаггүй*, нэг нэгнээ дардаг шиг л юм болно.

Бид бусдад анхаарал тавьсан цагт л Бурхан бидэнд анхаарал тавина. Би үүнийг баталж чадна. Бясалгал хийж байхдаа ажлаа алдана гэж айх хэрэггүй. Тэр шидээг дагинаасаас та нар суралцах хэрэгтэй. Халбага нь урт байсан болохоор бие биеэ хооллох нь маш хялбар төдийгүй, тун хөгжилтэй байсан байх. Тэд баяр хөөртэй тоглосон байж таарна. Бүгд инээж байсан. Гэтэл эдгээр *сүнс сүг юу ч идээж чадалгүй их ууртай, хоосон ходоодтой буцжээ*.

Гэгээрсэн хүмүүс бид юмыг саруул ухаанаар харах чадвартай байдаг болохоор маш тайван амгалан амьдардаг. Хэрэв бид гэгээрээгүй бол бидний сэтгэл “*Би их чухал хүн*” гэж бодсоор байх бөгөөд энэ нь бүүр ч их гай зовлон болно! Дэлхий дээр хэн ч байхгүй, зөвхөн “*би*” л ганцаараа байдал, аз жаргалыг зөвхөн “*би*” л эдлэх боломжтой гэж бодохоороо бид зовлон зүдүүрийг өөрсдөө үүрэх ёстой болдог. Үүнээс үзэхэд энэ бүхэн нь утгагүй, хэрэггүй зүйл болж байна.



ЭХИЙН ЗӨВЛӨГӨӨ

Сүй тавьж нөхөрт гарсан охин нь хол явах болжээ. Түүнийг нөхрийнхөө гэр лүү явахынх нь өмнө эх нь түүнд хамгийн сайн зөвлөгөө өгөв. Эх нь уйлсангүй, бас охиноо ч уйлахыг зөвшөөрсөнгүй. Ингэхийн оронд ээж нь хэлсэн нь: “Чи намайг сонсох ёстой! Энэ бол хамгийн аз

жаргалтай өдөр, чамд Арьябалын аргаар бясалгадаг (Багш болон бүгд инээлдэв), мөрийтэй тоглоом тоглодоггүй, бусад эмэгтэйг алиа салбадай шиг эргүүлдэггүй, архи дарс хэрэглэдэггүй, хуурч мэхэлдэггүй, харин үнэнч, энэрэнгүй, эелдэг зөвлөн, ёс суртахуунтай, буянтай, гаднаа ч, дотроо ч сайхан (Бүгд инээлдэв) нөхөр заяажээ, Бурхан чамайг адисалсан байна”.

Дотор тал нь гаднахаасаа илүү сайхан юм байна. Дотор тал нь цагаан, харин түүний гадна тал нь бараан аж. (Багш болон бүгд инээлдэв)

Охин инээмсэглэн эхийнхээ үгийг хайр, халамж дүүрэн, анхааралтай сонсов. Эх нь: “Одоо чи шинэ гэр лүүгээ явна. Хадмынхаа хамаатан садантай өөрийнх юм шиг харилцаж бай. Чи намайг болон эцгийгээ хүндэтгэдэг шигээ хадам эцэг, эхээ хүндэтгэж бай. Нөхрийгөө өөрийн ганц Бурхан, Гүрү, найз, хамгаалагч мэт үзэж, газар дэлхий дээрх хамгийн хайртай, хүндэлдэг хүнээ гэж хандаж бай. Тэгвэл хожим нь чи хүүхдүүддээ үлгэр жишээ болон гэрэлтэх болно, бас чи шинэ гэр бүлдээ нэр алдар, аз жаргал, бахархлыг авчрах болно. Чи нөхрийнхөө төлөө, миний төлөө, эцгийнхээ төлөө, энэ гэр булийн ах дуусийнхээ төлөө энэ үүргээ биелүүлэх ёстой. Түүнчлэн ингэж байж л чи өөрийнхөө болон нөхрийнхөө төлөө бид бүгдийг алдаршуулах болно” гэжээ.

“Гэр бүлдээ, нөхрийнхөө эд хөрөнгө, бизнест анхаарал тавь, тэгвэл гэр бүл тань өргөмжлөгдж, элбэг дэлбэг, аюулгүй байдалтай болсноор цэцэглэн хөгжиж, хүүхдүүд чинь аятай

тухтай амьдрах болно.

Өнөөдөр ингэтлээ гуниглах зүйл алга, одоо зөвхөн ирээдүйгээ харах шинэ сорилт чамайг хүлээж байна. Чи сайн эхнэр байхыг чармайх хэрэгтэй, тэгвэл чи амьдралдаа энэ бүх амжилтыг олж, аз жаргалтай байх болно”.

Охин нь: “Гэхдээ энэ бүх үүрэг, таны сая надад хэлсэн энэ эрхэм үүрэг, хариуцлагыг биелүүлэхийн тулд би юу хийх хэрэгтэй вэ?” гэхэд

Эх нь: “Чи өдөр бүр сайн идэж, сайхан хувцаслаж, тайван унтах ёстой”.

Охин: “Тэгье ээ, ээж ээ, би ойлголоо” гэж хэлэв.

Ингээд хадмынхаа гэрт очоод яг л тийм байж гэнэ. Өдөр бүр сайн унтаж, сайн идэж, сайхан хувцаслаж байв. Хадмын гэр бүлийнхэн түүнтэй хамт маш их баяр хөөртэй байдаг болжээ. Тэрээр нөхөр болон хадмын гэр бүлд үзсэглэнтэй, дуулгавартай, ухаалаг, ажилсаг, хичээнгүйлэн суралцдаг хүүхдүүдээ сайхан өсгөжээ.

Бусад хүн ирж, түүнээс нууцыг нь асуудаг байв. “Чи үүнийг яж хийдэг байна аа? Чи тийм хол газраас ирчхээд энэ нутгийн ёс заншлыг ер мэдэхгүй, тэгсэн мөртлөө энэ бүхний яж ингэж сайн хийдэг байна вэ? Чи яж амжуулдаг юм бэ?”

Жирийн бэр, өдгөө гурван хүүхдийн бахархалтай ээж, гэр бүлийн хамгийн чухал хүн нь, нөхрийнхөө компанийн даргын нарийн бичиг, эмэгтэй эзэн нь, бүх айл гэрийн үйлчлэгч нь, (Багш болон бүгд инээлдэв) хадам эцэг, эх болон ахмадууддаа асррагч нь, хадам дүү нэр, бэрүүдийнхээ өрхийн тэргүүлэгч нь гэх мэт, сайхан, эрүүл, ухаалаг гурван хүүхдийнхээ туслагч нь атлаа хайртай ээж нь болсон тэрээр маш даруухнаар: “Би ээжийнхээ хайраар дүүрэн зөвлөгөөний ачаар энэ бүхэнд хүрсэн” хэмээн ярьжээ.

Мэдээжийн хэрэг хүн бүр: “Надад хэлээч, надад хэлээч, гуйя, надад тэр зөвлөгөөгөө өгөөч!” гэв. “Миний ээж намайг шинэ бэр болоод наашаагаа гарахын өмнө гуниглаж байхад минь хадмынхаа гэрт очоод бөх унтаж, маш сайн хооллож, сайхан хувцаслаж байгаарай” гэсэн юм. (Багш болон бүгд инээлдэв)

Хүмүүс: “Юу? Ямар зөвлөгөө гэхээрээ ийм байдаг байна аа? Тэгээд чи яг ингээд л гэр бүлээ авч явж байгаа юм уу?”

Тэр: “Тийм ээ, би яг ингэдэг - өдөр бүр сайн идэж, бөх нойсож, дэгжин хувцаслаж байгаа. Миний хийсэн юм гэвэл энэ л байна” гэхэд

Тэд: “Яаж тэр вэ? Ямар учир утгатай юм бол? Зүгээр л тааشاал авснаар чи гэр бүлээ авч явж, бүх зүйл сайн сайхан болсон хэрэг үү? Бидэнд тайлбарлаж хэлж өгөөч, гүйя, чи тоглож байгаа байлгүй дээ?” гэхэд

Тэр: “Үгүй, үгүй. Миний ээж сайн хооллох хэрэгтэй гэсэн нь бүх гэр бүлийнхнийхээ төлөө анхаарал хalamж тавих ёстой, зочдоо оролцуулан бүгдийг нь цадтал, бас сэтгэл ханатал нь хооллох хэрэгтэй гэсэн үг. Тэгээд би өөрөө үлдсэнийг дуусгана, учир нь бүгд сэтгэл хангалаун болсны дараа хэн ч надад юугаар ч саад болдоггүй. (Багш болон бүгд инээлдэв) Эргэн тойрон эргэлдсээр би тэр үед өлссөн байдаг, (Инээлдэв) тэгэхээр юу ч үлдсэн байсан тэр нь маш амттай, гайхалтай, (Инээлдэв) шим тэжээлтэй, бас маш их адислалын хүчээр дүүрсэн байдаг.

Би юм идэхийнхээ өмнө Төгс Гэээрсэн Их Багш Чин Хайд залбирахад (Багш болон бүгд инээлдэв) Тэр миний хоолыг адисладаг. Иймээс би юу л иднэ, тэр маань зөгийн бал болчихдог. Миний бие хүчтэй, хodoод маань дүүрэн, зүрх сэтгэл минь хангалаун байдаг тул би нам гүм орчинд амттай хоол идээд ханаж, сэтгэл хангалаун байж, гэр бүлдээ хамгийн сайнаар үйлчилж чадна. Мөн хүн бүр цадаж, сэтгэл ханасны дараа тэд ч бас намайг хайрладаг, мэдээжийн хэрэг, би тэднийг маш сайн халамжилж байгаа болохоор тэдний хайрын мэдрэмж намайг адисладаг. Тэдний хамаг сайн сайхан ерөөл, сэтгэл хангалаун мэдрэмж нь намайг адисладаг, би ч бас тэдний аз жаргалын буяныг хуваалцдаг. Сайн хооллохын маань нууц энэ дээ” гэжээ.

Тэгэхэд тэд: “Чи шөнө болгон бөх нойрсдог уу? Чи зөвхөн нойрондоо л санаа тавьдаг гэсэн үг үү?”

Тэр хэлсэн нь: “Үгүй. Ээж минь сайн унт гэж хэлсний утга нь хүн бүхнийг унтсаны дараа би хамаг хаалга үүдээ цоожилж, гэрлээ унтрааж, бүх юм байрандаа байгаа, мөн түүнчлэн манайд хулгайч орж ирэхэргүй аюулгүй болсонд өөрөө итгэж, хүн болгон гүн нойрсож, биеийн байдал нь сайн байгаа эсэхийг мэдэж, гэр бүлийнхээ бүх гишүүнд анхаарал тавь гэсэн үг. Тэгсэн цагт би сэтгэл түгшихгүй болно. Тэгээд би бүгд дулаан хөнжилдөө таатайхан



унтаж, бас бүх л шөнийн турш ямар нэг юм гүйхаар юмуу, эсвэл өвдөх шалтгаан гаран хэзээ ч босож намайг үймүүлэхгүй гэж мэдэж байгаа учраас сэтгэл амарч, алжаалаа тайлахаар хэвтдэг. Тэгж байж л би сэтгэлийн түгшүүргүй болдог. Өөр хийх зүйл байхгүй болохоор би өөрөө маш тайван унтдаг. (Багш болон бүгд инээлдэв) Ээжийн маань үгийн утга энэ дээ”.

Тэр хүмүүс эхийнх нь билиг ухааныг ихэд гайхан бишрэв, бас охиних нь билиг ухаанд үнэхээр гайхав. Мэдээж охин нь ээжийгээ дуурайлгүй яахав.


“Одоо нэг юм үлдлээ гүйя, одоо сүүлчийн нэг. Өө! Яагаад чи сайхан хувцаслах ёстой гэж?”

Ингээд тэр хэлсэн нь: “Тийм ээ! Сайхан хувцаслах гэдэг нь үргэлж зохих ёсоор зөв хувцаслаж, цэвэр цэмцгэр байх ёстой гэсэн үг. Өглөө босохдоо ч, унтахын өмнө унталгын хувцсаа өмсөхдөө ч тэр, баяр баясал дүүрэн инээмсэглэн хувцаслахыг хэлнэ. Зүрх сэтгэлд чинь Бурханаас заяасан хайр энэрлээр өөрийгөө хувцасла, тиймээс хүмүүс чамайг хараадаа сахиусан тэнгэрийг харах болно, чиний нүүрэн дээрх хайрыг харна, чиний нүднээс хайр хишиг гэрэлтэн байгааг харах болно, чиний сайхан сэтгэлийн инээмсэглэлээс Бурханыг харах болно. Ээжийн минь сайхан хувцасла гэсний утга нь энэ”.

“Би өдөр бүр сайхан хувцасладгийн учир нь энэ. Өдөр бүр эрүүл байхын тулд сайн хооллодгийн учир нь энэ, шөнө бүр сайхан зүүд зүүдлэн унтдагийн учир нь энэ. Хэрэв та нар бүгд бүх юмыг ингэж хийвэл танай гэр бүлийнхэн, хадмууд тань манайхан шиг сайн сайхан байх болно!”

Мэдээж, бүгд мэхийн ёсолж, алга ташиж, инээмсэглэн өөрсдийгөө сайхан хувцаслахаар гэр гэр лүүгээ харьжээ.





ХАНХҮҮ ВИКТОР БА ТАВАН ЗУУН ГҮЙЛГАЧИН

Одоо энд Шагжамуни Буддагийн урьд төрлийнх нь амьдралын тухай нэгэн түүх байна. Тэрбээр энэ төрөлдөө Пасифэр гэдэг нэртэй байр хөлслөгч байжээ.

Нэгэн цагт Сарасвати хотноо, Четавана ашрам дахь «Аннатакапитикакапака»-д Гэгээрсэн Нэгэн амьдардаг байсан гэж би сонссон. Та нар хэдийнээ тэр газрыг мэддэг биз? Хэлэхэд их хэцүү шүү. (Инээлдэв) Тэр цагт Будда болон хуврагуудыг түшиглэн амьжиргаагаа залгуулдаг тэр хавийн таван зуун гүйлгачин байжээ.

Тэд яаж ингэдэг байсан юм бол? Тэд үлдэгдлийг нь ирж иддэг байсан байж магадгүй юм, эсвэл Будда болон хуврагуудад хоол өргөхөөр ирсэн хүмүүсийг харахаар тэр хавьд эргэлддэг байсан

байх. Тэгээд үүнээс үлдсэнийг нь иддэг ч байсан байж магадгүй. Ийм л байдаг байх.

Нэгэн өдөр Четаванагийн цэцэрлэгт хүрээлэнд санаандгүй байтал тэр таван зуун гуйлгачин Буддаг зорин ирж, Түүнээс тэднийг лам болгон сахил хүртээнэ үү гэж гуйжээ. Тэд Түүнд хэлэхдээ: “Энэрэлт Эзэн минь, Таны өршөөлөөр, ахан дүүсийн барилдлагын нигүүлслэлээр бид цатгалан байна. Одоо Та аугаа нигүүлслэлээ хайлаж, биднийг хуврагийн гэр бүлдээ багтааж болгоон соёрхоно уу? Бид чин сэтгэлээсээ хүсч байна”.

Энэ нь хувраг болно гэсэн үг.

Будда тэдэнд: “Миний сургадаг Үнэн Ёс бол туйлын ариун бөгөөд үндэстэн ястан болон сурвалж язгуур, баян ядуу, сайн муугийн хооронд ялгаа гаргадаггүй. Энэ нь цэвэр усаар угаал үйлдэхтэй адил. Ус бүхий л үндэстэн ястан, сурвалжит язгууртан, баян ядуу, сайн мууг ялгалгүйгээр угаадаг. Энэ нь уул, хад, тэнгэр, газар гэж ялгалгүйгээр бүх бодисыг алагчлалгүй шатаадаг галтай адил. Миний сургаал бол эрэгтэй эмэгтэй, охид хөвгүүд, баян ядуу бүгд ялгаагүй доор нь байраа олдог тэнгэр мэт” гэжээ.

Мэдээж энэ утгаараа тэр гуйлгачдыг хийдийн шавь болгон хүлээн авч байна гэсэн үг юм. Эдүгээ гуйлгачид Эзний хэлснийг сонсоод итгэн баярлав. Тэгээд тэд дахин хувраг болох зөвшөөрөл гүйв. Тэр эрт үед ийм дүрэмтэй байсан байж магадгүй. Та Буддаг дагахдаа чин сэтгэлээсээ, нухацтай байгаагаа харуулахын тулд Буддагаас хоёр юм уу, гурван удаа гүйх ёстой байсан байх. Тиймээс тэр үед нь Эзэн “Тавтай морил” гэж хэлжээ.

Ийнхүү үсээ хусуулж, улбар шар өнгийн орхимж нөмөрч, ёс журмын дагуу хувраг болжээ. Эзэн тэдэнд Үнэний ном сургаал айлдах үед оюун ухаан нь чөлөөлөгдөж, эгэл амьдрал нь хувиран архад болжээ.

Тэр улсын эрхэм дээд сурвалжит гэр бүлийн тэргүүлэгч, худалдаачин, ноёд нөгөө золгүй гуйлгачдыг шашны бүлэгт хүлээн авсныг нь сонсоод ихэд гомджээ. Тэд өөр хоорондоо “Хэрэв бид буян хийхээр Будда болон нигүүлсэнгүй хуврагуудыг уривал тэр гуйлгачид ч бас бидний дээр сууж, бид тэдэнд хүндэтгэл үзүүлэх хэрэг үү. Тэгвэл бидэнд гутамшигтай болно” гэлцжээ.

Энэ нь тэр хүмүүс тэр гуйлгачин хуврагуудыг үл тоомсорлож байна гэсэн үг.

Ингээд эртний учрал өрөөлөөр Виктор (Ялгуулсан) ханхүү Будда болон хуврагуудыг урилаа. Гэхдээ эхлээд Буддад: “Өө, Эзэн минь. Би Будда болон хуврагуудыг урьснаас биш, сүүлд хувраг

болсон тэр гүйлгачдыг уриагүй шүү!” гэжээ.

Тэр ялгаварлаж байлаа. Үүнийг та нар сайн гэж бодож байна уу? Үгүй ээ, энэ сайн биш.

Дараагийн өдөр нь Эзэн болон түүний шавь нар ханхүүгийн гэрт очих цаг болоход Будда нөгөө уригдаагүй хуврагууддаа хэлсэн нь: “Өглөгийн эзэн та нарыг урьсангүй, тэгэхээр та нар хойд тив рүү яваад хэний ч тариалаагүй, ургацыг нь хурааж аваагүй газраас зэрлэг будаа олж авчир.


Түүнийгээ өглөгийн эзний гэрт авчраад тэнд идээрэй!” гэв.

Буддагийн зааврын дагуу тэд архдын оюун ухааны хүчээр үтэр түргэн хойд тив рүү нисэж, бадрын саваа будаагаар дүүргэв. Дараа нь тэнгэрээр зэрлэг голуу шиг үзэсгэлэнтэйеэ зэллэсээр Виктор ханхүүгийн ордон руу нисэн ирж, дараалан суугаад онцгой будаагаа идлээ. Виктор ханхүү тэнгэрээр нисэн ирсэн тэр хуврагуудыг хараад гайхан биширч, чадал хүчинд нь итгэсэн байна. Тэгээд Буддагаас асуусан нь: “Өө, Эзэн минь! Энэ сүр жавхлантай, гайхалтай, буянтай, гэгээн, цэцэн мэргэд хаанаас ирээ вэ?”

Будда хэлсэн нь: “Та тэднийг таних ёстой доо. Ханхүү минь сайн сонс, би танд тэдний тухай хэль. Эд чинь нөгөө уриагүй хуврагууд шүү дээ. Та тэднийг уриагүй учраас тэд хойд тив рүү явж, зэрлэг будаа идэх гэж олж авчирсан байна”.

Хөөх! Аймшигтай юм. Хэрэв та энэ Виктор ханхүүгийн оронд байсан бол яах байсан гэж бодож байна вэ? Баярлан баясах уу? Ихих үү? Аймшигтай байх уу?

Виктор ханхүү үүнийг сонсоод ихэд ичжээ. Тийм ээ, та нар ухаалаг байна. Та нар зөв тааж байна. Тэр өөрөөсөө их ичсэн. Тэр ийм зүйл хийсэндээ ихэд гэмшиж, Буддад: “Харанхуй мунхаг, энэ ариун гэгээн хүмүүсийн талаар ойлголтгүй байснаасаа болж би тэднийг уриагүй байна. Эзэн минь, Таны буян төсөөллөөс хэтийджээ. Хэдийгээр энэ ариун гэгээрсэн хүмүүс энэ улсад нийгмийн доод давхаргын гүйлгачин байсан ч Эзний нигүүлслэлээр тэд дэлхий дээр баяр баясгаланг олж авч, удаан хугацааны буян хишиг хүртжээ. Ээ, Эзэн минь. Таны энэ дэлхийд



ирсэн нь энэ бүхний төлөө юм. Энэ гүйлгачид Тантай уулзаж, чөлөөлөгдөхийн тулд ямар буяны үндэс тарьж, мөн урьдын ямар нүтглээсээ болж гүйлгачин болж төрснийг тайлбарлаж өгөөч гэж би Танаас гүйж байна” гэв.

Энэ бол үзлийн үргэлжийн холбоотой.

Иймээс Будда дараах байдлаар тайлбарлажээ. “Эрт дээр үед, эргэж ирэхгүй эрин үед Олон Арш нэргэй нэгэн уул байжээ. Нэгэн цагт уулан дээр хоёр мянган арш амьдардаг байсан бөгөөд үзмэрч тэдэнд: “Арван хоёр жилийн турш тэнд бороо орохгүй” гэж урьчилан хэлжээ. (Арш гэдэг нь маш их ид шидийн хүчинд хүрсэн бөгөөд жишээлбэл, агаарт нисэх, олон мянган бээрийн тэртээхийг харах, ямар ч хана туурга гэх мэтийн саад тогторыг нэвт харах гэх мэт чадалтай, түүнчлэн буянтай ариун явдалтай хүмүүсийг хэлнэ. Тийм учраас тэднийг арш гэж нэрлэдэг.) Тэр арш нар тухайн улсад амьдардаг Пасифэр хэмээх хөрөнгө чинээтэй, байр түрээслэгчийнд очиж гэнэ. Тэгээд түүнээс арван хоёр жилийн турш хоол ундаар хангахыг гүйж, хэрэв чадахгүй гэвэл өөр тийшээ явахаа хэлжээ.

Тэгэхэд байр түрээслэгч хэлсэн нь: “Ариун гэгээн арш нар минь! Өөр тийшээ бүү яв. Энд үлд, би та нарыг гүйя. Би арван хоёр жилийн турш өргөл өргөх болно” гэв. Тэнд арван хоёр жилийн турш хур бороогүй байх учраас тэр арш нар байр хөлслөгчийнд ирж, түүнээс арван хоёр жилийн турш найдвартай өргөл өргөхийг хүсжээ.

Байр хөлслөгч тэгээд арван хоёр жилийн турш Ариун гэгээн хүмүүсийн хоол хүнсийг хангахад хүрэлцээтэй эсэхийг няраваасаа асуув. Тэгэхэд тэр хүрэлцээтэй гэж хэлсэн бөгөөд байр хөлслөгч арш нарт үйлчлүүлэхээр таван зуун эртэй тохиролцжээ. Таван зуун эр хэсэг хугацаанд тэдэнд үйлчлээд ядарч эхлсэн бөгөөд энэ гүйланчинггуудыг халамжилсаар хэтэрхий их зовж байна гэж өөр хоорондоо дургүйцлээ ярьж эхэлсэн гэнэ. Тэр үед бас хоолны цаг болоход хувилгаадыг дууддаг нэг эр байсан бөгөөд өөрийг нь үргэлж дагаж явдаг нохойтой байж. Нэг удаа тэрээр арш нарыг дуудахаа мартчихжээ. Гэтэл нохой нь тэдэн лүү гүйж ирээд хуцаж эхэлсэн бөгөөд арш нар хоол бэлэн болсныг мэдээд явж очжээ. Хэсэг хугацааны дараа арш нар байр хөлслөгчид хур бороо удахгүй наашлах учраас үрээ суулгах тариалангийн талбайгаа бэлтгэх хэрэгтэй гэв. Тэдний зөвлөгөөгөөр байр хөлслөгч талбайн ажилчдадаа тариан талбай дээр ажиллаж эхлэхийг тушаажээ.

Тэд арвай, улаан буудай болон бусад олон төрлийн үр тариа тарьжээ. Үр нь соёолж, савтай усны өндөр хүртэл ургахад гэрийн

эзэн арш нар дээр очиж, сайн ургац авах эсэхийг асуув. Тариалалт чинь сайн болно, тэгээд цаг үргэлж усалж байх зөвлөгөө өгсөн бөгөөд ургац хураалт болоход олон удаа хурааснаар агуулах нь дуурхэд байр хөлслөгч баяр баясгалантай болов. Арш нарт үйлчилж байсан таван зуун эр ийнхүү тэдний хүч чадлын илрэлийг үзээд үнэхээр их ичиж, гэмшин тэр ариун гэгээнтнүүдэд буруугаа хүлээж: “Ариун гэгээнтэд минь. Бид та нарыг муухай үгээр доромжилсон нүглээ наминчилж байна. Ирээдүйд хэзээ нэгэн цагт та нартай бид уулзаж, чөлөөлөгдөх болтугай” гэжээ.


Арш нарын эсрэг хэлсэн тэр муу үгнээсээ болж, таван зуун эр таван зуун төрөлдөө ядуу тарчиг гүйлгачин болж төрсөн юм. Хожим нь нүглээ наминчилж, ам тангараг өргөсний үрээр тэд надтай учирч зовлон нь дуусаж, үхэж төрөхийн хүрднээс ангижирсан билээ. “Ханхүү минь, та үүнийг ойлгох хэрэгтэй. Би бол тэр Пасифэр нэртэй байр хөлслөгч. Удияна бол миний нярав байсан юм. (Удияна тэр цагт Буддагийн шавь нарын нэг болсон байжээ.)

Харин та, Виктор ханхүү хоолны цаг болоход арш нарыг дууддаг тэр эр байсан бөгөөд харин

Сайхан Дуу хоолойт чи бол тэр нохой юм. (Ханхүүгийн хажууд Сайхан Дуу хоолойт нэртэй хүн байжээ.) Тэр хоолны цаг болсныг хуцаж мэдэгдэн зөвхөн ганц удаа л ариун гэгээн хүмүүсийг дуудсан учраас дараагийн бүх л амьдралдаа сайхан дуу хоолойтой болсон байна. Энэ таван зуун гүйлгачин бол тэр үеийн таван зуун үйлчлэгч эр юм. Буддаг ингэж ярихад заримынх нь дэс дээшилж байсан бөгөөд заримынх нь билиг ухааны хөгжил нь дээдийн дээд гэгээрэлд хүрчээ. Эзний угэнд бүгд итгэж, зүрх сэтгэлдээ баясан цэнгэв.

Энэ номын ихэнх үлгэр нь хуврагууд болон сүнслэг бясалгал дадуулагчдад өргөл өгөх нь асар их ач тустайг харуулж байна. Магадгүй ариш нар Их Багш болоогүй ч тэдний дагаж мөрдөж байгаа зам нь зөв бөгөөд Үнэний зам юм. Тэд бясалгаад зохих хэмжээний билиг ухаанд хүрсэн тул хор хөнөөлт муу замаар төөрч буудлахгүй. Тиймээс энэ хүмүүст өргөл өргөх нь зохицтой.

Энэ хүмүүст өргөл өргөсөн хүн маш их буян хишиг хүртэнэ,



бүхий л амьдралынхаа туршид материаллаг оршихуйдаа буюн хураана, эцэст нь амьд Буддатай учирч чөлөөлөгдөх буюу дээдийн гэгээрэлд хүрдэг юм. Нохой хүртэл чин сэтгэлээсээ ари нар луу хуцаж, тэдэнд хоол бэлэн болсныг мэдэгдсэн нь маш олон удаагийн төрөлдөөт хүн болж төрөөд түүнээс гадна үргэлж сайхан дуу хоолойтой болжээ. Эцэст нь тэрээр Энэтхэгт төрөхдөөт Буддатай учирч, ханхүүгийн хамт Түүнтэй бясалгасан байна.

Тэгээд ч Виктор ханхүү ер нь ари нарыг гүйлгачин уу, эсвэл сүр жавхлантай хүмүүс үү гэж өөдөр уруугаар ялгаварлах тийм санаа гарч ирэхгүй байх байсан. Гэвч ийнхүү ялгаварлан узсэн нь тэр гүйлгачдын өмнөх амьдрал дахь муу үйлийн үрээс болсон байна. Та нар санаж байна уу? Энэ үйлийн үр нь тэд Буддаг энгийн хүн байхад нь түүний удирдлагаа дор ари нарт үйлчилж байхад тохиолдсон шуу дээ. Иймээс тэдний олж авсан энэ муу үйлийн үрээс нь болоод Виктор ханхүүтэй учрах үед ханхүү урилгадаа тэднийг оролцуулажгүй гэдгээ зөн совингоороо мэдэрсэн байх. Гэвч Виктор ханхүү ялгаварлах узэлгүй байтлаа ингэсэн нь үйлийн үр байсан юм. Энэ бол ханхүүгийн гэм буруугаас болоогүй, тэгээд ч бид түүнийг буруутгаж чадахгүй. Энэ бол тэр таван зуун гүйлгачны өмнөх амьдралын үйлийн үр. Түүнээс гадна бидэнтэй тохиолдож байгаа учрал бүхэн учир шалтгаангүйгээр болохгүй гэдгийг та нар ухаарч байгаа биз ээ.


Энэ үлгэр нь бид урьдах нүгэл, урьдах алдаа эндэгдлийг цэвэрлэхийн тулд Үйлийн үрийн Эзэн бидэнд сонгож өгсөн амьдралын ямар ч сорилтыг тэвчих, хүлээн зөвшөөрөх, тэсвэрлэхийг сургаж байгаа хэрэг юм. Эхнийх нь болох таван сахилыг сахихдаа мэдээж хайрын нинжин сэтгэлтэй, хүлцэнгүй тэсвэр тэвчээртэй байх гэхчлэн байж сахидаг. Та нар ирээдүйдээ зориулж, муу урслэг тариалж болохгүй. Өнгөрсний муу үйлийн үрийг ямар ч гэсэн бид дуустал нь дуртайяа хүлээн зөвшөөрч, тэсвэрлэн хүлцэж байж давах болно. Жишээ болгоход, энэ үлгэрт таван зуун гүйлгачин урьдын амьдралдаа маш муу хэрэг хийсэн боловч тэд үүндээ гэмисэн. Таван зуун удаагийн амьдралдаа цээрлэлээ төлсний дараа тэдний энэ өнгөрсөн амьдралынх нь муу үйлийн үр нь төлөгдөж дууссан байна.

Одоо тэр байтугай, хэдхэн удаа залхуурснаа, ари нарыг зохих ёсоор хүндлэн биширч, өргөл өргөөгүйгээ зүгээр л зүрх сэтгэлдээ мэдэрч, хүндэтгэлгүй хэдхэн уг хэлснээсээ болж, тэр таван зуун хүн таван зуун удаагийн амьдралдаа гүйлгачин болж, амьдралынхаа хэв маяг, байр байдлаас шалтгаалан

бусад хүний зүгээс доромжлол амсааж, мөн дэндүү их гачигдал дутагдал, зовлон зүдүүр, өлсөх, даарах зэргийг тэвчин түүлсан байна. Тэгээд тэд өөрсдийн бүх нүгэл хилэнцийн төлөөсийг төлж, Буддатай учирч, хувраг болсны дараа ч гэсэн урьдын амьдралынх нь ул хүндэтгэсэн энэ үйлийн үр нь ингэж орчин тойрны уур амьсгалд яльгүй жсаахан нөлөөлөхөөр үлдсэн байжээ. Энэ нь Виктор ханхуу тэднийг зөн совингоороо үнэртэж, харж, мэдэрч байснаас харагдаж байна. Тийм ч учраас тэр тэднийг цайллагадаа урихыг хүсээгүй тул ийм хариу үйлдэл гаргажээ.

Үнэндээ бидний хийсэн болон хийж байгаа зүйлээс үл хамааран энэ тухай хэн ч мэдэхгүй байсан ч, энэ хүмүүс биднийг өмнө нь ийм зүйл хийхийг хэзээ ч харж байгаагүй, тэр ч байтугай бидэнтэй хэзээ ч уулзаж байгаагүй ч гэсэн бидний гэрлийн бүрхүүл, энергийн талбай, соронзон талбай доторх ямар нэг зүйлийг илрүүлэн гаргаж, тэгээд үүнийхээ дагуу хариу үйлдэл хийдэг байна. Тийм учраас өөрсдийгөө өө сэвгүй, төгс цэвэр байлгахын тулд цаг ямагт анхааралтай байж, үргэлж ийм байхын төлөө ухамсартайгаар мэрийх ёстой гэдгийн учир нь энэ. Тийм биш бол бидэнд юу ч тохиолдоо гэсэн бид өөр хэн нэгнийг буруутгах аргагүй.

ТЭВЧЭЭРТЭЙ ГҮНЖ



Ж нэ бол буддын шашны өөр нэг үлгэр. Түүний нэрийг Чун-рен гүнж гэдэг байжээ. Чун гэдгийн утга нь цэвэр ариун, рен гэдэг нь тэвчээртэй гэсэн утгатай. Маш тэвчээртэй болохоор нь түүнийг Чун-рен гэж дууддаг аж.

Тэр гүнж бол Берсна хааны бага охин юм. Энэ гүнж эцэг, эхдээ нэн хүндэтгэлтэй ханддаг бөгөөд маш их тэвчээр хатуужилтай ажээ. Гэвч тэр нэг дутагдалтай байсан нь үнэхээр муухай, хэтэрхий муухай, аймаар муухай, итгэмээргүй муухай байсан аж. (Инээлдэв) Үүнээс болоод тэр арван найман нас хүрсэн ч гэрлэж чадахгүй байлаа. Энэ “цэцэг” цэцэглээд удаж байлаа. (Инээлдэв)

Эцэг, эх нь охиныгоо гэрлүүлж чадахгүй байлаа. Тэд түүнд нөхөр олох гэж их оролдсон боловч бүгд талаар болов. Тэд Бурханыг шударга бус явдалд буруутгаж, Тэр л түүнд ийм царай, ийм болгоомжгүйгээр өгсөн гэж байлаа. Энэ гүнж үнэхээр царай муутай байсан тул түүнийг харсан хэн ч тэсэхээ болж, өөрийгөө хянах чадвараа алддаг байв.

Тэр ямар муухай байсан гээч? Пөөх! Хамар нь дэндүү навтгар, хавтгай, бас хамрынх нь хоёр нүх том бөгөөд тэнгэр өөд хандсан юм шиг! Уулзсан хүн бүр тэр даруй хамрынх нь хоёр нүхийг л хардаг байжээ. Дух нь овон товон, шүд нь гадагшаа орсойж ургасан нь ямар нэгэн нууц хадгалахад нь түүнд туслахыг хүсэхгүй байгаа юм шиг. (Инээлдэв) Аман дотроо байхад хэтэрхий халуун байгаа юм аятай хамаг шүд нь гадагшаа сэргүүн агаарт

ил гараад ирчихсэн байжээ. Нүд нь нүдтэй адилгүй, дэндүү том бөгөөд аймаар.

Бас биеийнх нь галбирыг дурдахын ч хэрэг алга. (Инээлдэв) Өндөр бөгөөд туранхай. Гэхдээ энэ нь зөв харьцаагүй. Алхаа гишгээ нь яг мануухай шиг. Түүнийг харсан хэн ч яг л сүнс сүгтэй тааралдлаа гэж бодмоор. Аймшигтай! Залуу сурвалжит эрс бүгдээрээ холхон байхын тулд гадаадад сурахаар явсан байжээ. (Багш болон бүгд инээлдэв) Өөрөөр хэлбэл түүний нөхөр болохоос айdag байсан түүхтэй юмсанж!

Тэрээр хоёр эгчийнхээ тольдохыг, мөн гадаад төрхөндөө баясаж байхыг нь хараад гонсойн машид гашууддаг байлаа. Гэхдээ тэр эгч нартаа ердөө ч атаархаж байгаагүй; тэр ердөө л байдал төрхөндөө гуниглан харамсдаг байжээ. Тэрээр оюуны хөгжил сайтай, ариун журамтай хатагтай байтал эгч нар нь өөрсдөөрөө л бахархахаас өөр юмгүй тул тэднийг хэн ч хайлрадаггүй байв. Тэр харин их өөр байжээ. Хэдийгээр тэр муухай царайтай ч харин бүгдэд таалагддаг байв.

Эгч нар нь омог бардам, гоо үзэсгэлэнгээрээ бахархаж, дүүгээ маш муухай гэдгийг мэддэг болохоор түүнийг үл тоомсорлон зориудаар харц буруулна. (Инээлдэв) Бас түүн лүү нөхөрсөг бусаар харж, тэр ч байтугай нуруугаа харуулна. (Инээлдэв) Тэд түүнтэй хэзээ ч найрсааг, эсвэл ойр дотно харилцаж байгаагүй, хэзээ ч ярьж хөөрдөггүй, хэзээ ч мэндэлж, хэзээ ч тайтгаруулж байгаагүй, огт харилцдаггүй байжээ. Тэд хаан эцэгтээ хүртэл хэн нэгэн тэднийг доромжилж, хааны гэр бүлийнхнийг үл тоомсорлоохоос зайлсхийхийн тулд түүнийг ордноос хэзээ ч гаргаж болохгүй гэжээ. Түүнээс хойш түүнийг гадагш гарч тоглохыг нь зөвшөөрдөггүй байлаа.

Ямар ч найз нөхөдгүй учир тэр ганцаардаж, дарамтад байжээ. Хэдийгээр тэр ийм нөхцөл байдалд байсан боловч эцэг, эхдээ сайн охины ёсоор хүндэтгэлтэй, эгч нартаа эелдэг сайхан ханддаг хэвээр байв. Тэрээр доод албат болон зарц нартаа маш анхааралтай, ухаалаг харилцаж, сэтгэл харамгүй байдаг байж. Хэн нэгэнд ямар нэг зүйл дутагдахад, эсвэл ядуу хүмүүст тусламж хэрэгтэй үед тэдэнд чадах бүхнээрээ туслахыг хичээдэг байсан юм. Гачигдалтай хүмүүст эм авч өгөхийн тулд үнэт эрдэнийн зүйлээсээ, хэрэгцээний зориулалттай мөнгөнөөсөө өгдөг. Хэрэв хэн нэгэн нь өвдөх юм бол халамжлахыг хичээнэ, эсвэл түүнд туслахыг эмчээс гуйна. Яагаад хүн бүрт маш их таалагддаг байсны учир нь энэ юм, харин хоёр эгчид нь хүмүүс дургүй байжээ. Түүний тааламжгүй гадаад төрхийг үл харгалзан магтууштай

үйл хэргийнх нь алдар цуу бүхий л улс даяар төдийгүй, хөрш зэргэлдээ улсад ч тархсан байлаа. Түүний буянт сэтгэл болон гадаад төрхийн аль алиныг нь сайн мэддэг болсон байв.

Нэг өдөр Чан-дэр (энэ угийн утга нь хятадаар буяныг эрхэмлэгч) гэдэг нэртэй хөрш орны ханхүү хаант улсад нь иржээ. Чан-дэр ханхүү түүнтэй гэрлэхийг хүссэн болохоор түүнд эмэгтэй хүний дур булаам байдал огт хамаагүй байсан байх. Ашгүй! Ордны бүх хүн мэгдэж хоцров! Хаан тэр ханхүүг бодлоо өөрчилчих вий гэж санаа зовсондоо цаг ямагт гараас нь зуурч байв. (Багш болон бүгд инээлдэв) Хаан түүнд талархаж буй дүр эсгэж байгаа боловч үнэндээ тэр ханхүүг зугтаж магадгүй гэж санаа нь зовж байжээ. Хаан, ханхүүгийн гараас атган түүнийг И-чи гэж дуудна (И-чи гэдэг нь хятадаар шударга ёсыг эрхэмлэдэг хүн гэсэн үг).

Хаан Чан-дэрт хандан: “Би чиний, охиныг минь гэсэн хайранд талархаж байна. Үүнийг үгээр илэрхийлэх ч аргагүй. И-чи минь, чи эмэгтэй хүний дур булаам байдлаас илүү буяныг эрхэмлэдэг билээ! Хэрэв хойшид танд ямар нэг юм хэрэгтэй бол би бүх талаар туслах болно. Одооноос эхлэн манай хоёр улс үхсэн ч, сэхсэн ч хамтдаа байх болно” гэх мэтээр өгүүлжээ.

Хаан хүмүүсийн хов живээс хол байхын тулд хуримын дараа охиныг нь гадагш явуулахгүй ордон дотор үлдээхийг (Инээлдэв) ханхүүд зөвлөсөөр байлаа.

Ханхүү хааны хэлснээр хийж, гүнжийг гэрт нь хорьжээ. Хэдийгээр ханхүүгийн оюун ухаан нэн нээлттэй, маш өгөөмөр байсан ч гүнжийн боломж хязгарагдмал хэвээр байв. Гэсэн хэдий ч гүнжийн муухай дүр төрх нь хязгааргүй байлаа. Хязгаартайн эсрэг хязгааргүй.

Эцэст нь ханхүү яалаа ч тэвчиж чадахаа болив. Хэдийгээр хаяа гүнжийн буянтай өгөөмөр байдлыг биширдэг ч түүнийг харахаараа өчүүхэн ч тэсвэрлэж чадахаа больж, дахин нэг удаа ч болов хяламхийн харах сонирхолгүй болжээ. Аажмаар Чан-дэр тоглон баясаж, буяныг эрхэмлэхээсээ илүү зугаа цэнгэл хөөцөлдөж эхэлжээ. Тэр янз бүрийн шалтаг тоочин гадагш гарч, ан хийх, уух, шатар тоглох гэх мэтээр зугаацна. Гүнжтэй тэр бүр уулзахаа ч болив.

Гүнж ордондоо амьдарсаар л, бүх зүйл бэлэн байсан ч яг л шувуу шиг байв. Тэр сэтгэлийн хямралын алтан торонд оржээ. Үргэлж дөрвөн хананы дунд байж, гадаа юу болж байгааг мэдэхгүй байв. Гүнж маш гунигтай байсан ч энэ нь түүний хувь тавилан гэдэгт итгэж байлаа. Тэр маш тэвчээртэй ажээ. Тэр одоогийн

нөхцөл байдлынхаа учир шалтгааны тухай үргэлж боддог байлаа. Магадгүй энэ нь түүний урьдын амьдралдаа сүнслэг дадал дутсаны төлөөс, эсвэл хүнд үйлийн үрийн төлөөс байх. Гэлээ ч тэр үүргээ сайн гүйцэтгэж, ердөө ч гомдол гаргадаггүй. Нөхөртөө үргэлж хамт байсан анхны өдрийнх шигээ ханддаг байжээ. Тэр маш их жигшил зэвүүцлийг тэвчиж байсан ч маш үнэнч байж, түүнд сайн анхаарал тавьж, чин сэтгэлээсээ дэмжиж байв. Хэдийгээр тэр ордныхонд маш өгөөмөр ханддаг байсан ч зарим нэг таагүй уйл явдал тохиолдсоор байлаа.

Хааны татвар эм, гүнж нар, хааны гэр бүлийн хамаатан саднууд гоо үзэсгэлэнгээ гайхуулахаар иржээ. Тэд түүний муухай дүр төрхийн талаар ил тод ярина. Гүнж маш хүлээцтэй хүн байж. Тэр хэзээ ч хүмүүстэй найрсаг бус харилцдаггүй. Ямар ч тохиолдолд үргэлж хүмүүжилтэй, тэвчээртэй, эелдэг байсаар байжээ.

Нэгэн өдөр тэр харгис сурвалжит хатагтай, гүнж нар түүгээр доог хийх, тохуурхах арга бодож олжээ. Тэд нөхрүүдээсээ гуйж, дайллага хийн хүн бүрийг, тэр дундаа ханхүү болон түүний эхнэрийг урьсан байна. Ихэнхдээ ийм бүжигт цэнгээний төрөлд эхнэр, нөхөр хосоороо ирэх шаардлагатай байдаг. Тэр хатагтай нар ханхүүтэй насаар ойролцоо, нэн ихэмсэг зантай аж.

Эцэст нь Чан-дэр ханхүү ганцаараа ирлээ. Тэр ганц бие болон гэрлэсэн сурвалжит хатагтай, гүнж бүгд л ханхүү рүү хандан маяглаж, дооглоно. Тэд түүний анхаарлыг татах, сээтгэнхэг гэж хичээх аж. Заримдаа тэд зориуд эхнэрийг нь маш муухай гэдгийг мэдүүлж, түүнийг гунигт автуулах гэж оролдож байв.

Ханхүү сүүлдээ буяныг эрхэмлэхээ болив. Тэр энэ доромжлолыг удаан тэвчих аргагүй болжээ. Эхнэртээ уурлаж эхэлсэн байна. Тэр доромжлогдож, ууртайгаар гэр лүүгээ буцаж гүйлээ. Тэр түүнээс салах ёстой гэж өөртөө хэлсээр явав. Тэр одоо өчүүхэн ч тэсэж чадахаа болив.

Яг энэ өдөр гүнж нөхрөө гэртээ эргэж ирэхийн өмнө өрөөндөө юу болсныг ч мэдэхгүй сууж байж. Гэнэт дотор нь сэрхийн аймшигийг мэдрэв. Энэ бол түүний зургаа дахь мэдрэхүй нь болсон явдлын тухай муу мэдээг хэлж мэдрүүлж байх шиг болжээ. Гүнж өөрийнхөө тухай бодож, гэртээ нулимс унаган уйлж эхлэв. Түүний бие цогцос, гадаад төрхийн хачин жигтэй байдал маш их уй гашууд автуулж байлаа. Өвдөг сөхрөн хоёр гараа нийлүүлэн залбирч, тэр үеийн амьд Шагжамуни Буддад залбирав. Тэр Буддагийн шавь ч байсан байж магадгүй, эсвэл дөнгөж Буддагийн нэрийг л сонссон байх.


Тэр залбирч: “Та бол хүмүүсийг зовлон зүдүүр, бэрхшээлээс авардаг амьд Будда билээ. Би одоо хамгийн зовлон зүдүүртэй хүн байна. Би Танд хүндэтгэлээ илэрхийлэх гэж гэрээсээ ч гарах боломжгүй тул миний Танд хандсан хүслийг ойлгож, ирээч дээ!” гэлээ.

Шагжамуни Будда түүний чин сэтгэлийгмэдэрч, Четаванахийдээсээ хувилгаан биеэрээ нисэн ирэв. Гүнж Буддаг хараад нулимс дуслуулж эхлэв! Тэр баярлаж, бас гуниглан уйлсаар. Тэрээр Шагжамуни Буддад: “Буддад хүндэтгэлээ илэрхийлье! Би өөрийнхөө өнгөрсөн амьдралаа мэдэхгүй байна!” гэлээ.

Өнгөрсөн амьдралдаа тэр ямар муу үйл хийснээс түүний бие махбод болон гадаад төрх ийм хачирхалтай болж, мөн ямар сайн үйл үйлдсэнээс тэр ийм баян чинээлэг гэр бүлд төрснийг нь мэдэх эсэхийг асуув. Хүмүүс түүнийг хүндэлж, зарим нь атаархдаг боловч зарим нь түүний төлөөс болох гадаад төрхөөс болж ялгаварлан доог тохуу хийнэ. Тэрээр Буддагийн өмнө хийсэн муу үйлдээ гэмшигээн байна. Мөн Буддагаас түүний чин сэтгэлд итгэхийг гүйв. Тэрээр урьд төрлийнхөө үйлийн үрийг мэдэхгүй боловч үүндээ их харамсаж байлаа.

Будда түүнд хэлсэн нь: “Чи урьд төрөлдөө үзэсгэлэнтэй хатагтай, гоо эхнэр байсан юм. Хэдий тийм боловч үйлчлэгч зарц нартайгаа маш хүйтэн сэтгэлээр харилцдаг, үзэсгэлэнтэй сайхан найз нөхөд, хамаатан садандаа атаархаж байдаг байжээ. Чи зөвхөн өөрөөсөө гоо үзэсгэлэнтэй хүмүүс рүү л хардаг байв. Хүмүүст таагүй ханддаг байсан. Сайхан харагддагтаа найдан бусдыг хүндэтгэдэггүй, их зантай, бүдүүлэг байсан. Хэрэв чи одоо чин сэтгэлээсээ гэмших юм бол бүх зүйл оюун ухаанаар бүтээгдсэн учраас энэ үйлийн үр чинь оюун санаагаа нээвэл арилах болно”.

Гүнж Буддагийн хувилгаан биеийн ингэж хэлэхийг сонслоо. Түүний сонссон энэ хоолой бол их зөөлөн, сайхан, бас бүлээн дулаан байв. Тэгээд тэр маш аз жаргалтай, сэргэлэн цовоо болж, тайвширснаа мэдэрч, гүнээ гэмшижээ. Өвдөг сөхрөн Буддагаас энэ үйлийн үрээ барагдуулахад нь туслахыг гүйв. Тэр үнэхээр чин сэтгэлээсээ, хамаг л сэтгэл зүрхнийхээ гүнээс гэмшиж байсан учраас Шагжамуни Буддагийн хувилгаан бие түүний толгойд хүрэв. Дараа нь гүнж Түүний нүд лүү харав.



Удтгал Түүний нүд лүү харсаар байсан гэж тэнд бичсэн байна. (Инээлдэв) Тэр магадгүй самадид орсон байх. Тиймээс удаан үргэлжилсэн биз. Ийм байдалд нилээд хэдэн цаг болсон гэж байна. Шагжамуни Буддагийн нүд рүү харж байтал гүнжийн нүд яг Түүнийхтэй адил үзэсгэлэнтэй, гэрэлтэй болон хувирчээ. Тэр Буддагийн сүр жавхлантай төрхийг харах үед гэнэт үзэсгэлэнтэй, сүр жавхлантай болжээ. Тэр маш их жаргалтай байгаагаа мэдэрч байв. Хамгийн баяр баясгалантай мэдрэмж биеэр нь тархав. Буддаг машид биширч, хайрлан хүндэтгэж байлаа.

Тэр Буддагийн биеийн аль ч хэсэг рүү харсан өөрийнх нь биеийн тэр хэсэг нь өөрчлөгдөж байлаа. Ингээд тэрээр даруй маш үзэсгэлэнтэй гүнж болон хувирчээ. Шагжамуни Будда түүнтэй ярилцахын тулд Өөрийгөө хувиргасныхаа дараа ид шидийн хүчийг хэрэглэн буцан нисэв. Үүнийг Тэр ид шидийн хүчээ хэрэглэсэн гэж хэлж байгаа боловч тэр бол Түүний хувилгаан бие байсан юм!

Ингээд Будда явчхаж. Дараа нь ханхүү гэртээ буцаж ирэв. Энэ үед ханхүү дахин цаашид өчүүхэн ч тэсэхээ больж, салахаар шийдсэн байжээ. Гүнж хар хурдаараа давхиж байгаа дуу чимээг сонсоод ямар нэг сүртэй юм болохыг мэдэж, зүрх нь хурдан цохилов. Тэр нөхрийгөө угтхаар гарахдаа маш их сандарч байжээ.

Тэр нөхрөө ууртай, бас харгис хэсрцгий зангаар дүүрэн байгааг олж хараад юу ч хэлж зүрхэлсэнгүй. Үүний оронд доош сөхрөн суугаад гутлыг нь тайллаа. Урьдын адил нөхрөө гэртээ ирэх болгонд хийдэг байсан бүх зүйлээ хийлээ. Түүнийг тав тухтай байлгахын тулд гутлыг нь тайлахад тусалжээ. Ингээд хөлөнд нь иллэг хийв. Дараа нь маш хүнд титмийг нь тайлж авлаа. Энэ бол нөхөртөө ханддаг түүний тогтсон заншил байжээ. Тэгээд сэлмийг нь авч



байранд нь тавив, дараа нь нэлд нь сувд, гартаамаар чимэглэсэн их хүнд бусийг нь тайлж тавив.

Ааяя, тэр үед л ханхүү эмэгтэйг харлаа. Түүнийг хэн болохыг мэдэхгүй гайхаж, тойруулан шильтэв. “Үгүй ээ, тэр биш!” Гэхдээ л ийм зан төлөвтэй тэр хүн бол түүний эхнэр, гүнж байх ёстой байв. Тэр эхнэртэй нь адил үйлдэл хийж, яг ижил хандлагатай байсан ч царай зүс нь өөр, мөн дур төрх нь бас өөр байв! Тэр эргэн тойрноо харж, яагаад ийм байгааг гайхан гүнжээс: “Чи хэн бэ?” гэж асуув.

Гүнж түүний будилж уймарсныг ойлгож, тэгээд Буддаг харсан тухайгаа, яаж өөрчлөгдсөнөө бүгдийг ярив. Хөөх! Тэр түүнээс салахыг хүссэндээ дэндүү их баяртай байсан! (Инээлдэв) Гэтэл одоо тэр бясалгал хийх нь хамгийн чухал гэдгийг ойлгож, тэгээд хамтдаа бясалгадаг болжээ. (Инээлдэв) Тэд магадгүй тэр өдөр авшиг хүртэж, нийтийн бясалгаль оролцсон байх. Тэд билиг ухаантай болохыг зорьж буян, адислалын төлөө туйлын хичээнгүйлэн бясалгаж, өглөг тараах болжээ.

Нэг өдөр хоёул сайхан зантай байхдаа өөр хоорондоо хөөрөлдөж сувв. Гүнж биеэ барьж чадалгүй нөхөртөө: “Би чамайг буяныг эрхэмлэхээс илүү эмэгтэйлэг сэтгэл татам байдалд анхаардаг гэж боддог” гэж хэлэв. (Инээлдэв)

Ханхүү буяныг эрхэмлэхээс илүү эмэгтэй хүний сэтгэл татам байдлыг хүсдэг учраас гүнж түүний нэрийг өөрчлөхийг хүссэн нь тэр. Тэгтэл ханхүү ичиж сандран өөр зүйлийн талаар ярьж, ярианыхаа сэдвийг сэмхэн өөрчилсөн байна. (Инээлдэв)

Гүнжийн хувьд түүний цаг нь болсноос ийм сонирхолтой байдалд ороод гацахксан байжээ. Тэр ч бүү хэл Буддад мөргөхөөр гадаги гарч чадахгүй байв. Тэр голоо үзэсгэлэнд биши, харин Буддад тэмүүлсэн байна. Гүнж Будда луу үнэхээр их тэмүүлэх болсны учир бол хувь тавилан нь сайнгүй, бас бие галбир, гадаад төрх нь тийм аймишгтай байсан бөгөөд тэр ч байтугай эрх чөлөөгүй байсан гэж ярьсан билээ. Тэр сурвалжит гүнж байсан боловч эрх чөлөөтэй байгаагүй. Эргэн тойрных нь бүх хүн түүнийг шүүмжилж, бүр дэндуу их шүүмжилсэн нь гүнжийн үйлийн үрийг цэвэрлэчихжээ! Тэр өдөр түүний хүндэтгэдэг нөхөр нь хүртэл салахыг хүсэж, түүнтэй ёс бус харилцсан билээ. Гэвч энэ бүх зовлон түүний үйлийн үрийн зарим хэсгийг цэвэрлэсэн байна.

Энэ бүхэн түүнийг Буддатай уулзахыг маш их хүсэн тэмүүлэхдээ хүргэсэн ч Түүнийг харахыг зөвшөөрөөгүйн улмаас сэтгэлээр унагаж, гомдоосон байна. Ийнхүү Түүнийг өөрт нь харагдах боломж олгохыг хүсэж, Буддаг ирээсэй гэж залбирч


гүйхад хургэжээ. Өөрийнх нь гадаад төрх өөрчлөгдөнө гэж өчүүхэн ч итгэж найдаагүй. Гүнж Буддагаас ямар нэг тусламж гүйхыг бодоогүй, энэ бол түүний өнгөрсөн амьдралын үйлийн үр гэдгийг тэр мэдэж байсан учраас зөвхөн харуусан гэмисэн байна. Энэ байдал нь түүнийг өөрчилжээ.

Би юу гэж хэлж байна вэ? гэхээр бясалгагчид тэр бүх материаллаг зүйлийг гүйх шаардлагагүй. Хэрэв тэр зүйлс ирэх бол аяндаа л ирнэ, хэрэв ирэхгүй бол ямар ч хамаагүй. Хамгийн эрхэм зүйл нь Үнэнийг чин сэтгэлээсээ эрэлхийлж, Ариун журамдаа санаа тавих явдал юм, тэгсэн цагт гаднах зүйл аяндаа сайхан болно. Есүсийн хэлсэнчлэн “Эхлээд Бурханы Орныг эрж ол, тэгвэл бусад бүх зүйл та нар луу ирэх болно”.

Бид үүнээсээ илүү үзэсгэлэнтэй гэдэгтээ итгэлтэй байх ёстой. Та нар өөрсдийгөө гоо үзэсгэлэнтэй, түүнчлэн гэгээ гэрэлтэй, сэргэлэн цовоо гэж бодохгүй байна уу? Тиймээ. Бидний дотоод гоо сайхан гадагшаа илэрч байдал. Бусад хүн биднийг харахаараа үзэсгэлэнтэй гэж боддог. Заримдаа ийм зүйл тохиолддог. Бидний дотоод гэрлийн чанарт гялбасан тул сүл дорийн байдал болон гаднах төрхийг маань харж чадахгүй болдог. Энэ бол үнэн зүйл.

Баяр баясгалангаар дүүрэн, аз жаргалтай, нээлттэй байхдаа бид үзэсгэлэнтэй харагдахгүй гэж үү? (Сонсогчид: Тийм) Зарим нь сайхан бөгөөд үзэсгэлэнтэй харагддаг ч гунигтай царайтай болохоор нь бид тэднийг харахыг хүсдээгүй. Та нар хэр үзэсгэлэнтэй байх нь хамаагүй, надаас гүйсан ч би тэр гунигтай царайнуудыг харахгүй. Та нар өөрсдийн гадаад төрхөнд хэт анхаарал тавих хэрэггүй, зөвхөн дотооддоо анхаар. Хэрэв бид дотооддоо үзэсгэлэнтэй байвал гадна тал ч адилхан байх болно. Дотоодоос гарсан сөрөг муу хүч нь гадна талыг бараан болгодог.

Бид уйтгар гунигтай байхдаа муухай харагддаг. Бясалгальчид бид гаднах зүйлийг хүсдээгүй боловч тэр бүхэн бидэн лүү аяндаа ирэх болно. Хэрэв бидэнд тэр зүйлс байхгүй бол бид зүгээр л байна. Бид илүү сайн бясалгасны дараа тэр зүйлсийг ер хайхраахаа болино. Бие махбодын гоо үзэсгэлэн бол сайн хэрэг, гэвч бие махбодын гоо үзэсгэлэн үгүй бол бас л сайн хэрэг.



ХАРАМЧ ЭМТЭЖ



Э нэтхэгт, уулын бэлд нэг эмгэн амьдрал суудаг байжээ.
Тэр эмгэн “ганцаардмал” байдалд их дуртай. Зожирох дуртай хүмүүсийн ихэнх нь Бурхантай хамт байхыг хүсдэг. Ийм байхдаа л зөвхөн Бурханыг бодож, бясалгаж, санаж, хайлаж, сонсож, Бурхантай ярьж чаддаг байна. Энэ бол жинхэнэ ганцаардал юм.

Гэвч энэ хөгшин тийм биш, харин тэр улс орондоо хамгийн тэргүүн зэргийн харамч нь байв. Өмч хөрөнгө, хоол хүнсээ бусадтай хуваах дургүй учраас л ингэж зожирон амьдардаг байжээ. Энэрэл нигүүлсэл гэж юу болохыг ч мэдэхгүй. Камбожийн

ард түмний төлөө ширхэг будаанаасаа ч салахыг хүсдэггүй нэгэн. (Инээлдэв) Амьдралынхаа турш хэнд ч, юу ч огт өгч байгаагүй, тэр байтугай хуучин хогийн шүүрээ ч гэсэн. Хэрэв тэр нь хуучирч элэгдвэл засаж сэлбэн хадгалчхаад хэнд ч, хэзээ ч өгдөггүй байж.

Эзэн Вишну гэдэг нэртэй бурхан байжээ. Хоёрдугаар өртөнцийн эзэн Вишнүг та нар мэднэ дээ. Тэр манай өнөөх алдар цуутай эмгэний амьдрал байдлыг сонирхон харж гэнэ. Тэгээд түүнийг шинэ жилийн дараа удахгүй үхэх нь гэдгийг олж мэдэж л дээ. (Инээлдэв) Тэр хамгийн эхний цагаан будааны бялуугаа идээд хахаж үхэх ёстой ажээ. Үнэндээ шинэ жилийн баяр наадмын үеэр хөгшин япончууд цагаан будааны бялуунд хахах нь олонтоо. Тэр цагаан будааны бялууг та нар хэтэрхий их идэж болохгүй, наалдамхай будааны бялуу, тийм биз? Тэд яаж үүнд хахдаг байна аа, би ойлгохгүй юм, гэвч ямартаа ч хэн нэг нь ингэдэг юм.

Эзэн түүний дэлхий дээрх амьдрал гурван өдрөөс илүүгүйг харсан байна. (Юутай сайн хэрэг вэ! Түүнийг явчихсаны дараа хүмүүс өмч хөрөнгөнөөс нь бага зэрэг хувь хүртэж болох нь) Эзэн Бусандийг дуудаад хэлсэн нь: “Миний хамгийн хайртай Бусанди минь, тэр хөгшин маргааш үхэх учраас өнөөдөр түүнээс ядаж нэг зүйл салгаж ав. Хэрэв ядах нь аа бага зэрэг шоколад ч юм уу, эсвэл эрдэнэ шиш ч юм уу сэм хулгайлбал үхэхэд нь түүний тооцоонд бага ч гэсэн буян хураг” гэжээ. (Инээлдэв)

Бусанди за гэж толгой дохив. Тэгээд хэрээ болж, Качанийн гэрийн ойр модон дээр суулаа. Качани гэж өнөөх эмгэний нэр. Энэ үе нь атгахан бор будаа угааж, усанд дэвтээн хоолоо бэлдэж байсан цаг байлаа. Тэгээд Бусанди түүнийг нь сэм хулгайлан хошуугаа дүүргэхээр шийдэв. Гэнэт нэг үсрэлтээр, гэрлийн хурдаар “Сүн” хийн нисэж очоод савны дэргэд бууж, амандаа будаа дүүргэв. (Инээлдэв)

Гэлээ ч сээрэмжтэй байсан эмгэн асар хурданаар хүзүүнээс нь атгаад авлаа. Тэгээд шувууны хүзүүт нь мушгив. Хрр! (Инээлдэв) Тэр будаагаа хodoод руу нь гулсаад орчихоос нь өмнө амжиж авахын тулд мушгижээ. (Сонсогчид: Яа яа!) Бурхан минь! Энэ хооронд нөгөө гараараа шувууны хошууг



хоёр тийш нь ярж, хоолойноос нь сүүлчийн будааг ч үлдээлгүй авахын тулд шахаж гарав.

Өө! Энэ бол үнэхээр зохих ёсоор үнэлэгдэж, биднээс шагнал авууштай! Түүхэн дэх Хамгийн Харамч Эмэгтэй. (Инээлдэв) Ийм үлгэр байдаг уу, ийм явдал үнэн болсон уу, би мэдэхгүй байна, байсан л байх даа. Зарим хүн их харамч, мунхаг, хэрцгий, бас хүйтэн цустай байдаг. Бусанди амь насыхаа төлөө тэмцэлдэж гүд, гүд, гүд... гэж байв. (Инээлдэв) Эцэст нь эмгэний тооцоогоор бүх будаа гарсны дараа тэр чөлөөтэй болжээ.

Тэр Эзэн Вишнү руу нисэж ирээд хөлийнх нь хажууд үхэдхийн уналаа. Вишнү Эзэн өөрийг нь орхиж явснаас хойш юу тохиолдсоныг түүнээс асуув. Уухилан байж тэр хэлсэн нь: “Ээ, Эзэн минь, би бараг үхэх шахлаа. Үүрэг даалгавраа биелүүлж чадсангүй ээ, намайг үнэхээр учлаарай. Би тэр золгүй эмгэний хоолноос ганц ч будаа авч чадсангүй” гэв.

Тэгэхэд Эзэн: “Өө Бусанди, битгий ингэж хэл. Нааш ир, чи надад амаа шалгул. (Инээлдэв) Амаа нээ дээ, нэг харья” гэж хэлэв. Ингээд Бусанди хошуугаа нээхэд Эзэн Вишнү билгийн мэлмийгээ ашиглан томруулдаг шилээр түүний хоолой руу харлаа: “Аа хаа, энд ямар нэгэн юм байна. (Инээлдэв) Энэ юу вэ? Энэ юу болохыг би хармаар байна, ямар нэг юм байх ёстой доо”.

Тэгээд тагнайд нь наалдсан будааны гадуурх хальс болох өчүүхэн жижиг зүйлийг харжээ. (Инээлдэв) Бурханд талархья. Ядаж л дэмий хоосон цагаа үрээгүй, дэмий тэмцээгүй байна. “Хараач Бусанди, чиний тагнайд өчүүхэн жижиг хальс наалдсан байна. Сэтгэл минь ханалаа” гэж Эзэн хэлэв.

Аяа! Эзний санаанд нийцүүлэх амархан аж.

Одоо ингээд тэр эмгэн багахан ч гэлээ буянтай боллоо. Аяа, өрөвч, энэрэнгүй, нигүүлсэнгүй Эзэн мандтугай! Тэр тэгээд: “Бусанди, түүнийг үхсэний дараа дэлхийд буцаж төрөхөд нь тагнайд чинь наалдсан тэр будааны хальсаар хооллох юм шүү” гэж хэлэв.

“Тэр эмгэн насан туршдаа үүнийг л идэх болно.” Эзэн ингэж хэлээд үзэгдэхгүй болов.

Санаатай үйлдээгүй ч нигүүслэл, сүсэглэлийн ач тус агуу



бөгөөд гайхамшигтай. Бурханы хайр энэрэл хязгааргүй бөгөөд хэмжээлигүй. Өчүүхэн ч болов нинжин сэтгэл, нигүүслэл энэрлийн нууцлаг хүч ийм л байдаг аж. Эмгэн тэр хальсыг хэрэггүй гэж бодсон болохоор л авахыг хүсээгүй байх. — Өө, тэнд тийм ч их юм байхгүй дээ гэсэн биз. (Инээлдэв)

Эзэн Бурхан Өөрийн аугаа хайраараа нүгэлт хүмүүсийг ч гэтэлгэж, шүтэн мөргөх боломж олгож байдал. Буяны сэтгэлгүй хөгшин эмгэн хальс төдийхнөөр дараа идэх хоолоо олж авах боломжтой болжээ. Хэрэв бид хүмүүст бүр ихийг өгвөл хэр ихийг олж авах нь ойлгомжтой байгаа биз дээ?

ЗӨРҮҮД ГУРВАН ЗАРЦ

*Ж*эгэн баян тэрбумтан эр гурван зарцтай байжээ. Нэг нь нэн ухан бодомтгой, хоёр дахь нь маш хэрсүү болгоомжтой, харин үлдсэн нь эелдэг найрсаг ажээ. Тэр баян эр тэдэндээ их хайртай, бас сэтгэл хангалаун байдаг байв.

Нэг удаа баян эрийн хүү золгүй тохиолдоор голд унан живж байжээ. Гэтэл хоёр дахь хэрсүү зарц нь үүнийг харж гэнэ. Хэдийгээр тэр тийм хэрсүү боловч эзэндээ хэлэхээр буцаж явав: “Эзэнтэн минь, таны хүү дөнгөж сая голд унаачлаа. Би түүнийг аварч чадах уу? (Инээлдэв) Бид түүнийг аварч чадах уу, үгүй юу, та юу гэж бодож байна? Хамгийн сайн ямар арга байна вэ? Энэ талаар хоёулаа ярилцах хэрэгтэй байх!” гэв.

Мэдээж баян эр ихэд уурлаж, түүнийг хөөчхөв.

Тэгээд хүүгээ аврахаар гүйж очиход дэндүү оройтсон байлаа. Ингээд тэр эхний буюу ухан бодомтгой зарцдаа хүүгээ оршуулахад хэрэглэх авс худалдаж авахыг тушаажээ. Тэр зарц юу ч болоогүй байхад ч бүх юманд урьдаас бэлдэж байдаг хүн учраас хоёр авс худалдан авчээ. (Багш болон бүгд инээлдэв) Тэр хэтэрхий сэтгэн бодомтгой хүн! Эзэн нь бас л уурлаж хэлсэн нь: “Зөвхөн ганц хүү минь үхсэн байтал чи яагаад хоёр авс худалдаж авав?”

Зарц хариулсан нь: “Юмыг яаж мэдэх вэ, таны хоёр дахь хүү чинь живэх ч юм уу, өөр нэг золгүй явдал тохиолдвол (Сонсогчид инээлдэв) бид дахин худалдаж авах шаардлагагүй болно. Тэгвэл төвөгт удахгүй, цаг хэмнэнэ, бензин хэмнэнэ!” гэв.

Баян эр туйлын ихээр уурлаж, түүнийг хөөчихлөө!

Одоо ганц л зарц үлдлээ. Тэр нь маш эелдэг хүн байв. Баян эр түүнд их сэтгэл хангалаун байжээ. Нэг өдөр тэр зарц нь өөр нэг зарцын хамт эznээ дагалдан дурсгалт газруудыг узэхээр гадагш гарахад нь жуузыг нь дамнан явжээ. Тэдний замд гүехэн устай, намагтай гол таараздав. Хэрэв усыг гаталбал хувцас нь бохирдож норох байлаа. Нөгөө зарц нь тээнэгэлзэн зогсов. Гэтэл эелдэг зарц хэлсэн нь: “Битгий буцаж яв! Эзэн маань баяртай л байвал бид цааш явах хэрэгтэй. Бид өөрсдөө тийм ч чухал биш” гэв. Тэгээд тэд өөрсдийгөө хайхралгүйгээр голыг гаталжээ.

Боол нь өөрт нь ийм үнэнчийг сонсоод эзэн нь ихэд баярлав. Тэгээд тэр зарцдаа: “Өдийг хүртэл чи их халамж асралтай байж, надад бүхнээ зориулдаг, үнэнч итгэлтэй байсан тул би гэртээ хариад чамд олон шинэ хувцас өгч, цалинг чинь нэмнэ!” гэв.

Үүнийг сонсмогц эелдэг зарц жуузыг доош нь тавьж (яг голын дунд хэсэгт зогсож байсан үед) залбиран: “Таны нинжин сэтгэлд баярлалаа, эзэн минь” гэв. (Багш болон бүгд инээлдэв)

Харж байна уу, та нар, манай авшигтинуудаас нэг их ялгараа юм алга байгаа биз дээ? (Сонсогчид инээлдэв) Тэд тухайн нөхцөл байдлыг хэрхэн үнэлж, түүнд зохицсон ямар үйлдэл хийхээ мэддэггүй. Хүн бүр өөрийн гэсэн зан чанартай байдал ч үүнийгээ буруу газар ашигладаг.

Та нар Күнзийг санаж байна уу, тэр хэдэн гайгүй алдартай шавьтай байсан. Зе-Лу бол их эрэлхэг зоригтой, харин Зан-Чио их хэрсүү байсан. Гэвч хүн бүр ийм л ганц онцлогтой. Хэрэв та нар хэтэрхий хэрсүү бол яаж амар тайван байхыг мэдэхгүй байх болно. Хэрэв та нар хэтэрхий эрэлхэг зоригтой бол хэзээ даруу төлөв байхаа мэдэхгүй байна. Иймд хэтэрхий туйлирах нь сайн биши гэдгийг ойлгох хэрэгтэй.

Хэдийгээр тэд маш сайн байсан ч Күнзээс суралцахаар ирсэн, учир нь Тэр эрэлхэг зоригтой боловч хэтэрхий зоригтой биши, даруухан боловч хэтэрхий даруухан биши, бүх онцлог чанарыг өөртөө шингээж чадсан байж. Тэр ямар ч нөхцөлд хэрхэн биеэ авч явахаа мэддэг байсан. Тэр бүх зүйлийг төвийг сахисан байдлаар зохицуулдаг, хэт нэг талыг баримталдаг туйлиран улангасагч биши байжээ.

Бидний ихэнх нь зөрүүд. Хэрэв бид үүнийгээ зөв газар ашиглавал энэ нь сайн хэрэг. Гэсэн хэдий ч буруу газар ашиглавал муу болно. Яг л цахилгаан шугамыг ашиглаж чадвал чийдэн асаж, энэ нь агаарыг халуун, эсвэл хүйтэн болгодог шиг. Гэхдээ хэрэв цахилгаан шугамд шууд хүрвэл асуудал гарна. Түүнчлэн хүмүүсийг анагааж чадах эмчилгээний олон эмийг шинээр зохион гаргаж байна. Гэхдээ их тунгаар уувал аюултай.



Бид энэ өртөнцөд хэрхэн төгс төгөлдөр болохыг суралцах гэж ирсэн бөгөөд бүх онцлог чанарыг эзэмшиж, тэр бүхнийг хэрхэн зөв, тохирсон газар нь яаж ашиглахаа мэддэг байх ёстой. Бид их эрэлхэг зоригтой учраас юуг ч тоохгүй урагшаа дайран явж болно гэж хэлж болохгүй. Хэрэв бид эрэлхэг зоригтой атлаа билиг ухаангүй бол өөрсдийгөө болон бусдыг хохироож мэднэ.

ДАРУУ ТӨЛӨВ БАЙЫЛАА СЭРГЭЭС



○ үнслэг бясалгал хийхийг үнэхээр хүсдэг нэг хүн байжээ. Тэр түүх, судар нэлээдийг уншсан бөгөөд бүгдэд нь: “Төлөв даруу байдал бол хэн нэгэн хүн Гэгээнтний түвшинд хүрсэн гэдгийг харуулдаг гол чанар юм” гэж бичсэн байдал ажээ.

Тиймээс тэрээр төлөв даруу байдалд суралцахыг хүсжээ.

Суралцахын тулд нэг их багшийг дагав. Их Багшдаа Бурхантай уулзахыг маш их хүсэж байгаагаа хэлж, тэгээд төлөв даруу байдлыг яаж сурахаа мэдэхгүй байна гэжээ. Бас өөрийгөө цэвэр бус, бохир заваан, төлөв даруу бус юм шиг мэдрэмжтэй байгаа учраас Бурханыг харж чадахгүй байгаагаа хэлжээ.

Түүний их багш нь: “Сайн байна! Одоо чи яваад өөрөөсөө илүү дорд муу, бохир заваан хэн нэгнийг юм уу, ямар нэгэн юм ол. Тэгээд надад авчир, эсвэл тэр дордоо надад хэл. Тэгэхэд чинь би хэрхэн түүнээс суралцахыг, хэрхэн улам төлөв даруу болохыг зааж өгч чадна” гэж хэлжээ.

Тэр Тайбэйгээс Каошион хүртэл явсан боловч бүтэлгүйтэж, Мияолид ч олдсонгүй. Гэсэн ч бид олигтгүй муу хэдий ч тэр өөрөөсөө олигтгүй юу ч олсонгүй. Тэр урамгүй байлаа.

Нэгэнтээ тэр жорлонд байхдаа гэнэт баас бол түүнээс илүү бохир заваан, дорд юм байна, эдүгээг хүртэл хэн ч түүнийг хүсдэгтгүй бөгөөд харахаасаа өмнө хамраа таглаад холддог гэж бодлоо. Тэр овоолоостой бааснаас авч түүнээс илүү муухай ямар

ч юмыг олж чадахгүй учраас их багшдаа аваачихаар болов.

Гараа яг “түүнд” хүргэх гэтэл ямар нэгэн дуу хоолой: “Надад бүү хүр! Битгий хөдөлгө! Бүү хүр!” гэж хэлэх дуу сонсогдов.


Тэр эр их гайхаж, хэн ярьсныг сонирхжээ. Тэгэхэд тэр дуу хоолой дахиад: “Чи надад гар бүү хүр!” гэв.

Энэ нь тэр баас түүнд хэлээд байх шиг санагдлаа. Ихэд эргэлзэж: “Яагаад үгүй гэж? Яагаад би чамд хүрч болохгүй гэж?” гэхэд

Тэр хэлсэн нь: “Чи намайг харахгүй байна уу? Би өчигдөрхөн бялууны төгс төгөлдөр зүсэм хэрчим байсан. (Инээлдэв) Би үнэхээр үзэсгэлэнтэй сайхан, үнэ цэнтэй, нандин байсан тул хаанд идүүлэх, эсвэл агуу гэгээнтэнд өргөж болохуйц тохиромжтой байсан. Харин одоо би чамтай нэг удаа холбоотой байснаасаа болж, өнөөдөр ийм байр байдалд хүрсэн байна. Одоо хэн ч надтай уулзахыг хүсэхгүй, ойртох ч үгүй. Тэд намайг хараад нүдээ аньж, хамраа таглаад хурдхан зугтана. Бүгд намайг дорд үзнэ. Би чамтай нэг удаа холбогдсон болохоор л ийм байр байдалд хурлээ! Хэрэв чи надад дахиад нэг удаа хүрвэл аймаар юм, (Инээлдэв) би юу болохыг хэн мэдлээ? Надад өөр ямар аймшигтай зүйл тохиолдохыг би мэдэхгүй. Тиймээс надад дахиж битгий хүр.”

Тэгээд тэр хүн төлөв даруу байдлыг мэдэрч, үнэхээр ойлгосон байна.

Бид өөрсдийгөө маш сайн гэж боддог, гэхдээ үнэндээ бол тийм биш ч байж магадгүй! Тэр бааснаас бид илүү гэж өөрсдийгөө боддог, гэвч үнэндээ тэдний байр байдал нь биднээс болж өөрчлөгдсөн. Сунслэг бясалгагчид бид даруу зантай эсэхээ маш сайн мэддэг. Бид өөрсдийгөө ямар нэгэн аугаа зүйл гэж бодож болохгүй.



УЛААН, НОГООН БҮГ

Хагас сүнс, хагас бурхан, магадгүй хагас сахиусан тэнгэр, хагас буг хоёрын тухай үлгэр байдаг. Тэр хоёр хамтдаа амьдардаг байжээ. Нэг нь улаан, нөгөөх нь ногоон өнгөтэй, яг л гудамжны улаан, ногоон гэрэл шиг. Ногоон нь амар амгалан,

дөлгөөхөн хөдөлгөөн. Улаан нь дайн, зогсолт, саад тогтор гэсэн утгатай. Гэвч хоёул хамтдаа ууланд аз жаргалтай, ямар ч асуудалгүй, айdas түгшүүргүй, хүсэл шуналгүй, өөр шаардагдах юу ч угүй амьдарч байжээ.

Тэд хэдийнээ олон зуун жил амьдарсаар иржээ. Тэгээд хийх юмгүй үедээ үргэлж уулын орой дээр суугаад тэднээс доош байдаг хүний ертөнц рүү хардаг байж. Хамаг л үймээн бужигнаан, нааш цааш явж байгаа хүмүүсийг, бүх зүйлийг хардаг байв. Хүний ертөнц байнга өөрчлөгдөж байхыг хардаг байжээ. Ингээд Ногоон нь Улаандaa хэлж гэнэ: “Бид энд хэдийнээ олон зуун жил амьдарсан боловч бидний амьдрал ердөө өөрчлөгдөөгүй. Өдөр бүр ижилхэн. Гэтэл доорх хүмүүсийн ертонц өдөр бүр өөрчлөгдөж байдаг. Яаж ингэдэг байна аа?”

Улаан нь хэлсэн нь: “Өө тийм, чиний зөв, маш сонирхолтой. Тэдний амьдрал илүү сонирхолтой юм.”

Гэтэл Ногоон нь: “Тэдний амьдрал яаж ингэж цаг үргэлж өөрчлөгддөг байна аа?”

Тэгтэл Улаан нь хэсэг бодож байснаа: “Өө, тэд үргэлж өөр хоорондоо тэмцэлдэж байдгаас ингэдэг юм байна. Сайхан том барилга бариад дараагийн өдөр нь тэмцэлдээд түүнийгээ нураана. Дараа нь дахиад нэгийг барьж, дайтаж дахин устгана. Тийм ч учраас дэлхий дээр үргэлж хийх зүйлтэй байдаг. (Багш болон бүгд инээлдэв) Тиймээс энэ ертөнцийнхөн үргэлж өөрчлөгдөж байдгийн учир нь ийм юм байна. Иймд одоо бидний энэ ертөнцөд бид хэтэрхий найрамдалтай, хэтэрхий уйтгартай байна. Бид өөр хоорондоо дайтах хэрэгтэй гэж би бодож байна” гэж хэлэв. Улааны санал бодол ийм байлаа.

Ногоон хэлсэн нь: “Үгүй! Байлдахгүй! Бид сайн найзууд. Бид өчнөөн зуун жилийн турш нөхөрлөсөн. Бид яаж өөр хоорондоо дайтаж болох билээ?”

Гэтэл Улаан хэлсэн нь: “Хэрэв бид байлдахгүй бол бидэнд ямар ч өөрчлөлт гарахгүй. Бидний амьдрал үргэлж л нэг янзаар явж ирсэн. Энэ нь уйтгартай бөгөөд бидэнд ямар ч дэвшил гарахгүй. Тиймээс байлдъя!”

Ногоон хэлсэн нь: “Үгүй, үгүй, үгүй! Би ингэж чадахгүй. Үгүй ээ, бид бол найзууд!”

Улаан нь шаардаж хэлсэн нь: “Өнөөдрөөс эхлэн чи миний дайсан. Тэгээд л бол oo”.

Тэр шууд дайн зарласнаа мэдэгдчихээд яваад өглөө. Тэр ногоонтой дахин ганц хором ч хамт амьдрахаа болжээ. Тэр уулын

нөгөө тал руу нүүж, дайнд бэлдэж эхлэв. Ногоон нь өөрсдийнхөө амьдарч байсан ууландаа үлдээд ганцаардаж, ихэд хэцүү болов. Тэр нөгөө бугаа санаж байлаа.

Энэ төрлийн хагас сахиусан тэнгэр болох бугнууд ид шидийн хүчтэй гэнэ ээ. Тэд нисэж чадахаас гадна аливаа зүйлийг бүтээн гаргаж ирэх, алс холын юмыг харах, сонсох, мөн түүнчлэн хамраа хязгааргүй урт сунгах чадвартай аж.

Ногоон буг маань нэг өдөр их л уйтгарлан сууж байлаа. Гэнэт доорх хүн төрөлхтний өртөнцөд ямар нэгэн зүйл байнга анивчиж, гэрэлтдэг болохыг анзаарав. Иймд тэр сонирхсондоо хамраа ашиглахаар шийджээ. (Инээлдэв) Тэр хамраа уртасгав. Тэр, “Урт бол, урт бол” гэж хэлсээр байлаа.

Тэгтэл хамар нь уртсан уртассаар доорх өртөнцөд гялалзан харагдсан нөгөө газарт нэвтрэн орлоо. Тэр хотын гүнжийн хувцас тэгж гялалзаж байжээ. Энэ нь гүнжийн хувцсыг зарц нар нь салхинд гаргаж, юманд өлгөн дэлгэж байгаатай тохиолджээ. Хувцас нь алтан хайртай, заримыг нь очир алмаз, бадмаараг гэх мэтийн үнэт чулуугаар чимэглэсэн байв. Тиймээс наранд гэрэлтэн анивчиж, гялалзан харагдаж байжээ.

Зарц нар нь өөр хоорондоо: “Түүний хувцас маш үзэсгэлэнтэй атлаа их олон юм аа. Хувцаснуудыг өлгөх хулс хүрэлцэхгүй байна, яах вэ?” гэж ярилцах ажээ.

Яг энэ үед нөгөө бугийн хамар ирж таарчээ. (Инээлдэв) Үйлчлэгчид: “Өө, бид үлдсэн хувцсаа өлгөх хангалттай хулстай боллоо” гэж боджээ.

Ингээд тэд гүнжийн үлдсэн хувцсыг энэ ногоон хулсан шон дээр тавиад баяр хөөртэйгөөр чапати идэхээр дотогш оров.

Ногоон буг маань гэнэт хамраараа ямар нэгэн хүнд зүйлийг мэдрэв. Тэр гайхан түгшиж, даруйхан хамраа татан авчирч, хэвийн хэмжээнд болготол хамартай нь хамт гялалзсан хэдэн хувцас ирэн хөлд нь унажээ. Тэр: “Aax! Өө! Өнөөдөр ч азтай өдөр байна даа” гэлээ.



Тиймээс түүнийг ямар гоё үзэсгэлэнтэй болгохыг нь харахын тулд өмсөж үзлээ! Тэр бахархаж, ганцаараа тойрон алхаж байв.

Энэ явдал Улааныг ирэх үед тохиолджээ. Тэр дэвшил гаргахын тулд дайн эхлүүлэхийг хүсэж байлаа. Гэтэл Ногоон хэлсэн нь: “Наашаа хараач! Би ийм сайхан хувцастай болсон. Үүний хагасыг нь чамд зориулж хадгалсан” гэжээ.

Улаан нь жигшсэн харцаар хараад: “Сонс доо, би ийм хөгийн зүйлийг өмсдөггүй, чам шиг галзуу хүмүүс л өмсдөг юм” гэж хэлэв.

Тэр дайн дэгдээмээр санагдаад тэнэг юм хэлжээ.

Ногоон бол ногооноороо л байдаг учир их амгалан байж, түүний үгэнд эмзэглэсэн нь ч үгүй хэлсэн нь: “За, зүгээр ээ. Чи өмсөхийг хүсэхгүй бол энэ юугаар ч гай болохгүй. Эднийг энд нь үлдээе, тэгвэл дээр”.

Улаан өөр юу хийхээ мэдэхгүй байсан учраас гэр лүүгээ явлаа. Үнэндээ тэр Ногоонд маш их атаархаж, дараа нь өөртөө хэдэн хувцастай болж авах гэж оролдсон байна. Тэр бас хамраа сунгаж, доош тэр ордон луу оруулж, хамар дээр нь хувцас өлгөхийг хүлээлээ. Гэтэл энэ үед самурай нар хоорондоо сэлмийн сургуулилт хийж байгаатай тааралджээ. Тэд нэг ург юм ороод ирэхийг хараад бие биесээ: “Энэ юу вэ?” гэж асуув.

Нэг нь хэлсэн нь: “Аан, энэ чинь дайснуудыг бидэн руу довтлохын тулд сэдсэн шинэ бүтээл байх. Эхлээд үүнийг устгай”.

“Өө, тэгье” гэж нөгөөх нь хэлжээ.

Тэгээд сэлмээр “Tas” (Багш тасалж байгаа дуу авиа гаргав). Улаан гэнэт өвдөхийг мэдэрлээ. Тэр үтэр түргэн хамраа буцааж хэвийн хэмжээнд авчрав. Хамраас нь цус гарч, маш их уйлав гэнэ.

Ногоон түүний уйлахыг сонсоод ирж асуусан нь: “Яав, юу болсон бэ?”

Улаан их уурлаж, ичиж, үнэнэх хэлж чадсангүй. Тэгээд: “Намайг зүгээр орхи! Надад битгий яршиг болоод бай” гэжээ.

Ногоон: “Үгүй, би чамд төвөг болохгүй, би чамд тус болохыг хичээж байна, хамраас чинь цус гоожиж байна шүү дээ. Наашаа хар, би эмчлэх арга мэднэ. Үүнийг тавибал цус зогсож, зүгээр болох бөгөөд хамар чинь урьдынх шигээ буцаад сайхан харагдана. Тэгэхгүй бол чи том сорвitoй болж, эндээ том нүхтэй болно. Энэ чинь дараа нь их муухай харагдана шүү дээ. Би зүгээр л чамайг халамжлахыг хүсэж байна” гэж хэлжээ.

Энэ бүгдийн дараа Улаан уярч: “Тэгье, тэгье” гэж хэлэв.

Тэгээд дотроо онгойтол уйлж: “Ёо, ёо үнэхээр их өвдөж байна. Гуйя, хурдлаач, хурдлаач, хурдан үүнийг гайгүй болгооч өгөөч” гэж хэлж гэнэ ээ.

Мэдээжийн хэрэг, тэд эвлэрчээ, учир нь тэр зодолдохоос залхсан байв. Тэр дайн байлдаан бол сайн биш юм байна гэдгийг ойлгожээ. Ийнхүү тэрээр энх тайвны сургамж авчээ. Үүнээс хойш тэд сайхан хувцсаа өмсөж, өдөр бүр хамтдаа цай ууж, дахин ер дайтахаа болж гэнэ.



ШИДЭТ САНДАЛ

*Д*артээ урьд цагт нэгэн өвгөн амьдран сууж байжээ. Тэрээр уулын бэлд тун ч ядуу амьдардаг байж л дээ. Сүрлэн овоохой нь ганц өмч хөрөнгө нь байж. Харин үнэн хэрэгтээ тэр хүн маш залхуу байсан тул ийм байх нь аргагүй аж!

Нэг өдөр тэр хүссэн болгоноо бүтээх ер бусын хүч чадалтай маш хүчирхэг йогч алс нутагт амьдардаг тухай сонсжээ. Үүнийг сонсоод ажил хийхийг хүсдэггүй тэр маш залхуу хүн ямар ч ажил хийхгүй байхын тулд түүнээс ер бусын хүчээ ашиглан өөрт нь зориулж, ямар нэгэн зүйлийг бүтээж өгөхийг гүйхаар шийдэв. Ийм горьдлого өвөрлөн явлаа.

Тэрээр йогчийн амьдардаг уулын агуйд очих гэж маш хол зам туулжээ. Тэгээд йогчтой уулзан сунаж мөргөв. Тэр йогч их сайхан зантай эелдэг хүн байсан бөгөөд түүнийг зочлон цайлж, хэрэг зоригийг нь асуув. Залхуу эр хэлсэн нь: “Хүндэт хайрт их багш аа, би их ядуу хүн. Би жижигхэн сүрлэн овоохойноос өөр юу ч үгүй. Одоо би хөгшрөөд ажил хийх чадалгүй боллоо. Иймд өрөвдөн хайрлаж, надад туслаач, их багш аа. Амьдралд минь хүрэлцэх хөрөнгө өгөөч. Та бол ер бусын их хүчтэй гэдгийг би мэнднэ. Та хүссэн зүйлээ үтэр түргэн бүтээж чадна шүү дээ. Та надад тусална гэдэгт итгэж байна”.

Тэр йогч нүдээ аниад нэг ч үг хэлэлгүй нам тайван сууж байв. Магадгүй тэр түүний яриаг сонсоод залхсан ч байж мэнднэ. Хөгшин эр түүнээс үргэлжлүүлэн гүйсаар байв. Удтал гүйсны дараа йогч түүнд дурамжхан гэгч нь нэг сандал өгөөд: “Гэртээ харьсны дараа хүссэн зүйлээ бодох үедээ хэдийд ч гэсэн энэ сандал дээр суугаарай. Сандал дээр суухынхаа өмнө гар нүүрээ угааж, усанд ороорой. Тэгээд хүссэн зүйлээ бод. Ингэвэл та түүнийгээ авах нь гарцаагүй” гэж хэлжээ.

Йогчид талархлаа илэрхийлснийхээ дараа хөгшин эр сандлаа аваад даруйхан гэр лүүгээ яаран явлаа! Гэртээ очоод цаг дэмий үрсэнгүй. Тэр дороо гар нүүрээ угаан усанд орж, тэгээд дараа нь сандал дээр суув. Энэ үед тэр их өлсөж байсан тул тэр даруй хоол бодов. Дороо л хоол гараад ирж гэнэ. Хөөх! Ямар гоё, сайхан, элбэг дэлбэг юм бэ. Тэр бүх сайхан хоолыг идээд цадаж, ихэд баярлан баясав.

Идэж дуусаад ядарснаа мэдэж, амрах ор хүслээ. Тэр дороо л зузаан дэвсгэртэй ор гарч ирэв. Унтахаар хэвтсэн боловч мань хүний сэтгэл нь үргэлж л янз бүрийн зүйл, эд мөнгө бодоод үнэндээ амарч чаддаггүй ээ. Тэгээд орноосоо үсрэн босож сандал дээр суув. Одоо тэр сүрлэн овоохойгоо ордон болгож хувиргахыг хүсэн бодож эхэлжээ. Түүнийг дөнгөж бодож эхлэхэд л сүрлэн овоохой нь тэр дороо хувирч өөрчлөгдөв гэнэ!



Хөгшин эрийн ордон нь үнэт чuluугаар бүтсэн үнхээр их үзэсгэлэнтэй аж. Хaalганууд нь алтаар хийгдсэн, мөн тааз, шал, тэр байтугай багана нь ч алтаар хийгдэж, бүгдэд нь үнэт чuluу шигтгэн хээлсэн байв. Тиймээс нэн аж жаргалтай бөгөөд маш тухтай болжээ. Цааш нь үргэлжлүүлэн бодсон нь: “Аа ха! Ийм том ордон зарц наргүйгээр байж болохгүй” гэж бодтол л...

Тэр дороо л олон зарц түүний тушаалыг хүлээж зогсоно. Дараа нь: “Мөнгөгүйгээр зарц нар, ордон байж болохгүй!” гэж бодов.

Тэгээд дэндүү их алт, мөнгө, зоос бодлоо. Тэр бүхэн нь гэнэт л гарч ирэн бий болов. Энэ байдал хөгшин эрийг үнхээр аж жаргалтай болголоо. Гэтэл тэр гэнэтхэн түгшиж эхлэв. Тэр бодсон нь: “Пээ! Хэрэв газар хөдөлбөл миний ийм үзэсгэлэнтэй, ийм их эд хөрөнгөтэй ордон минь яах билээ?” (Багш болон бүгд инээлдэв)

Яг бодож дуустал газар хөдлөв. (Багш болон бүгд инээлдэв) Түүний эд хөрөнгө, орд харш бүгд газар шороонд булагдлаа.


Энэ үлгэр бидэнд юу өгүүлж байна вэ? Бидний бодол санаа юун түрүүн цэвэр ариун байх ёстой. Ер бусын хүч, эсвэл бясалгалын хүчтэй байх нь хангалигүй. Тиймээс бид хүч чадал олж авахаасаа өмнө бие, хэл, сэтгэлээ ариусгах ёстой. Хэрэв бидний бие, хэл, сэтгэл цэвэр биши, мөн сахилаа зөв сахиж чадахгүй бол бид муу юм хийж болно. Өөрийн маань хүч чадал бидэнд хор хөнөөл учруулж болно. Заримдаа энэ хүч бусдад ч хор хөнөөл учруулж болзошгүй. Ийм учраас эрт дээр үеэс их багши нар шавьдаа хүч чадал өгөхийн өмнө түүний бие, хэл, сэтгэлийг бүрэн цэвэр ариун болтол нь удаан хугацаагаар сорьдог байжээ.

Их Багши та нарт ер бусын хүчин дээр бясалгах хэрэггүй гэж байнга хэлдэг. Жирийн хүмүүс ер бусын хүчин дээр хялбархан бясалгаж чаддаг. Тэд ургамал хоолтон байх албагүй, ямар нэгэн удирдамжийг дагаж мөрдөх шаардлагагүй. Бид оюун ухаанаа удирдаж чадахгүй хэвээр байгаа бол муу зүйлийн талаар бодох юм бол тэр даруй гарч ирдэг, учир нь тэр үед бид юу л бодно, түүнийгээ л олж авдаг. Орчлон өртөнцийн хүч асар их боловч бид үүнийг хэрхэн ашиглахаа мэддэг байх ёстой. Эс бөгөөс энэ нь маш их хор хөнөөл учруулж, өөрсдийгөө хорлож, дэлхийг сүйтгэж болзошгүй юм.

Дэлхийд бидний харж байгаа зарим аюул гамишиг нь хааяа гагцхүү хүмүүсийн үйлийн үрээс болдоггүй, харин ер бусын хүчийг хэрэгжүүлдэг хүмүүсээс болох нь бий. Тэд бясалгах дадлаа муу зугт чиглүүлснээс, эсвэл замбараагүй сэтгэлгээнээс нь болж дэлхийд сүйрэл авчирдаг. Ийм хүмүүсийг асуудал үүсгэсэн, эсвэл сөрөг хүчинд автсан гэж хэлж болно. Ийм хүмүүс үнэхээр байдаг.

Иймд бид бясалгахдаа өөрсдийгөө хамгаалахын тулд өдөр бүр Бурханыг, Бурхдын Ариун Нэрийг бодох хэрэгтэй. Заримдаа бидэнд учирдаг саад бэрхшээл нь зөвхөн бидний өөрсдийн үйлийн үрээс болоод зогсохгүй бидний эргэн тойронд байгаа маяагийн сөрөг хүчинээс болж үүсдэг. Бүхнийг Чадагч Бурханы тухай илүү их бодох тусам бидний ухаан бодол цэвэрлэгдэж, дараа нь бид юу ч хүсэхээ болино. Тэр үед бидний хувьд ер бусын хүч ямар ч ашиггүй, учир нь бид Бурхантай нэгдмэл байх тул бидэнд боломжгүй зүйл гэж байхгүй байхсан.

Энэ үед бид дотооддоо маш сэтгэл хангалиун болж, энэ хуурмаг өртөнцийг орхисны дараа буцажс, өөрийн Гэрт очиж, тэнд бүх зүйлтэй болно гэдгээ мэднэ. Тэр газартай харьцуулж үзэхэд энэ хорвоо бол хогийн эд. Бидний сэтгэлийг татах зүйл энд юу ч үгүйг ойлгоно. Бидний сүнс Гэр луүгээ олон удаа буцажс очиж үзсэний дараа бидний оюун ухаан бүгдийг ойлгож, нэн тогтвортой болно. Дараа нь бид юу ч хүсэхээ болино. Бид хүссэн ч, тэр зүйлс зөвхөн бусдын сайн сайхны төлөө байна. Иймд үргэлж сайн зүйлсийг бодвол л зүрх сэтгэл маань маш сайхан байх болно. Зөвхөн эерэг зүйлийн талаар бодоход л эерэг зүйл аяндаа ирнэ.



БУРХАНД ИТГЭХ БИДЧИЙ ИТГЭЛ

*Ж*эг хүн машины осолд оржээ. Тэр машинаасаа шидэгдэн модны мөчирт өлгөгдчихжээ. Аюулд өртөв. Тэр өмнө нь Бурханд хэзээ ч итгэж байгаагүй бөгөөд Их Багшийн нэр болон иймэрхүү зүйлийг хэзээ ч хэлж байгаагүй. (Инээлдэв) Хэцүүдсэн үедээ тусламж дуудсан боловч, эргэн тойронд нь хэн ч байсангүй.

“Өө, Бурхан минь, ядаж л Та энд байна уу? Би урьд нь Танд хэзээ ч залбирч байгаагүй ч өнөөдөр залбирч байна. Ирж надад туслаач, гуйяа. Гуйя!”

Юу ч болсонгүй. Бурхан юу ч хэлсэнгүй, эсвэл Тэр тэнд байгаагүй байх.

Тэгээд дахиад л үргэлжлүүлэн “Өө, Бурхан минь, надад битгий уурлаач дээ. Би амьдралынхаа турш хэзээ ч Таныг дуудаж

байгаагүй гэдгээ мэдэж байна, гэлээ ч гэсэн би өнөөдөр Таныг дуудаж байна. Би Танд итгэж байна, үгүй гэж үү? Итгэж байгаа учраас Таныг дуудаж байгаа биш гэж үү? Хэрэв би Танд итгээгүй бол юу гэж Таныг дуудах билээ? Гүйяа, хурдхан ирж, надад туслаач дээ!” гэжээ.

Юу ч болсонгүй. Бурхан юу ч хэлсэнгүй.

Тэр их ядарснаас бараг л хадан цохион дээр унах шахаж байлаа. Гэтэл хадан цохио нь ч бас ганхаж эхлэв, тэгээд тэр хэлсэн нь: “Өө Бурхан минь, хурдан нааш ирээч! Би бүх л тив дэлхийгээр Таны нэрийг түгээн дэлгэрүүлэхээ амлаж байна. Би санваартан болж, Бурханыг номлох болно. Хэрэв Та өнөөдөр намайг аварвал би үүний гэрч болж, Танд итгэхийг хүн бүхэнд ятган хэлэх болно. Би энэ гайхамшигийг тэдэнд хэлэх юм бол хүн бүр Таныг дагах болно гэдэгт итгэж байна. Таны хүссэн болгон чинь болохоо амлаж байна, Таны зарц, Таны санваартан.”

Гэтэл хaa нэгтэйгээс “Аюулд өртөхөөрөө бүгд л ингэж хэлдэг” гэсэн дуу сонсогдов.

Тэгтэл тэр хүн: “Өө, Бурхан минь үгүй, би тэгэхгүй, би тэгэхгүй. Би үнэхээр Танд итгэж байна. Хэрэв Та надад тусалбал, би үнэхээр итгэнэ. Би амлаж байна” гэж хэлжээ.

Бурхан буюу дуу хоолой: “За, болж байна, би чамд боломж олгоё. Одоо чи мөчрөөсөө унаачих, тэгэхлээр чинь би чамайг аварна” гэж хэлэв.

Тэр хүн: “Юу үү? Намайг солиотой гэж бодоо юу?” гэв.

Тэр хүн Бурханд ингэж л итгэдэг байж дээ.

Энэ нь манай зарим авшигтны хэлдэгтэй тун төстэй сонсогдож байна: Тэд “Би Их Багшдаа итгэдэг, гэхдээ юу гэнэ ээ? Та надад ингэ гэж хэлж байгаа юм уу. Яах гэж?” гэдэг.

БИД ИХ БАГШИЙН ГАДНАХ ҮЙЛДЛИЙГ ДУУРАЙХ ЁСГҮЙ

Уү авь нараа билиг ухаанд сургадаг Их Багш байжээ. Энэ өртөнцөд ирсэн зарим Их Багш билиг ухаанд сургахыг хүсдэг. Ингээд тэр хэлсэн нь: “Тийм ээ, мэдээжийн хэрэг, ирээдүйн Их Багш, ирээдүйн Будда болохын тулд бид дор хаяж хоёр бэлэг хүртэх ёстай. Ирээдүйд Будда болохын тулд олон чухал онцлог чанартай байх хэрэгтэй боловч сүнслэг бясалгал дадалд хурдан дэвшихэд хэрэгтэй хоёр чухал бэлэг байдаг” гэв. Тэгэхэд нь шавь нар нь түүнээс: “Тэр юу юм бэ? Тэр хоёр бэлэг тань юу юм бэ?” гэв.

Их Багш хэлсэн нь: “Эхнийх нь тэсвэр тэвчээрийн хүч. Тэвчээртэй байна гэдэг нь бусад хүний тэсвэрлэдэггүй бүхнийг тэсвэрлэдэг гэсэн үг. Хоёр дахь нь ажиглах хүч – хар, хар, хар”.

Тэгээд үүнийгээ үзүүлэхийн тулд нэн даруй бараа бологчоо гараад саван дотор үнэртсэн даруйд бөөлжмөөр тийм их бохир заваан зүйл дүүргээд аваад ир гэж хэлэв. Гэхдээ тэр Их Багш ямар ч сэтгэлийн хөдөлгөөнгүй байжээ. Та нарын харахыг ч хүсэхгүй, бие засах газраас шууд авчирсан байж магадгүй тийм ой гутмаар бохир зүйлтэй сав руу Их Багш хуруугаа дүрлээ. Тэгээд дүрсэн хуруугаа ам руугаа хийчхэв. Царай нь ер хувирсангүй, яг л та бидний өмнөх хана шиг.

Түүнийг тойрон буй ирээдүйн Будда нар Их Багшдаа шавь нь байх чадвартай гэдгээ үзүүлэхийг хичээж, маш их хүсэж байжээ. Тэгээд бүгд ирж, саванд хуруугаа дүрж аваад дараа нь амандаа хийв, бас нүүр царайгаа хувиргахгүй байхыг хичээж байв. Жигшиж зэвүүцэх ч юм уу, нүүр царай нь өөр ямар нэг байдал илэрхийлж хувирсангүй.



Их Багш инээн хэлсэн нь: “Баяр хүргэе, та нар нэг сорилтыг давлаа, гэхдээ харин хоёр дахийг нь давсангүй. Эхний сорилт болох тэсвэр тэвчээр шалгах сорилтыг үнэхээр давлаа. Ажиглаж чадаагүйгээс та нар хоёр дахь сорилтод уналаа” гэв.

Шавь нар нь: “Яагаад?” гэцгээв.


Тэгэхэд нь Их Багш хэлсэн нь: “Би энэ хуруугаа дүрсэн боловч ам руугаа өөр хуруугаа хийсэн юм”.

Тэр бохиртой сав руу долоовор хуруугаа хийж, ам руугаа дунд хуруугаа хийжээ. (Инээлдэв) Гэтэл шавь нар нь үүнийг ердөө ч ажигласангүй. Тэд сав луу хийсэн хуруугаа ам руугаа хийсэн байна.

Тэгэхлээр, энэ одоо юу болохыг та нар ойлголоо. Эд бол ёстай тэнэг шавь нар байна. Ихэнх шавь нарын байдал ийм. Тэд шууд л Их Багшийг дуурайдаг. Ямар ч юмыг, ямар ч зүйлийг, юуг ч байсан хуулбарладаг. Тэгээд өөрсдийгээ алса салбадай шиг болгодог. Энэ л асуудал юм даа. Иймд бид хэнийг ч хуулбарладаггүй юм. Хэрэв бид Их Багштай адил байхыг хүсвэл хэнийг ч хуулбарладаггүй. Хүн бүхэн бүтээлч сэтгэлгээний хүч чадалтай байдал тул бүгд давтагдашгүй. Хүн бүхэн авьяас чадвар, уран сайхны чиг хандлагадаа нийцүүлбэл юуг ч бүтээж чадна.

Бид хэнийг ч, тэр дундаа Гэгээнтэн, Их Багш, дэлхий дахины Өвөг Багши нарыг ч тэр, дуурайх хэрэггүй. Та нарын мэдэх олон Их Багши өөр хоорондоо адилгүй байдгийн учир нь энэ. Өвөг Багши Хүй Нэн бол Буддатай адил харагддаггүй, үйл хэрэг нь Буддагийнхтай адил биш. Есүсийн үйл хэрэг, Луузынхаас өөр. Лууз бол Криинатай адил төстэй юм юу ч хийж байгаагүй гэх мэт. Тиймээс, хэрэв бид Их Багшийг хуулбарлан дуурайх юм уу, эсвэл Их Багшийг бидний Библиэс унишдаг шиг, эсвэл толгойдоо төсөөлдөг шиг байх ёстой гэж найдаж байгаа бол бид хэзээ ч Их Багшийг олж чадахгүй. Бид хуулбарыг олох шаардлагагүй. Бид жинхэнэйг нь олох ёстой. Их Багши үргэлж давтагдашгүй жинхэнэ байдаг. Бидэнд хуулбар хэрэггүй, тийм биз?

Ийм учраас бид сунслэг бясалгалаа үргэлж сонор сээрэмжтэй байх ёстой. Их Багши юмыг өөр янзаар хийдэг, бүр тэс өөрөөр ч хийх нь бий. Бид зүгээр харчхаад л түүн шиг хийж чадах юм байна гэж боддог - толгойд нь хүрээд л, нүд лүү нь хараад л, чихэр өгөөд л – бид чихэр болон иймэрхүү зүйлийг үүнээс ч илүүг худалдаад авчхаж чадна. Энэ бүхэн нь та нар тэр хүнийг Их Багши мөн эсэхийг дүгнэхчэж болохуйц гаднах үйлдэл төдийхөн биш, энэ бол дотоод үйлдэл юм.



БҮХ ЗҮЙЛ САНАА БОДЛООС ҮҮДЭЛТЭЙ

Олон жилийн өмнө хоёр наиз хамтдаа гадагш гарч орчин тойрноо үзэхээр явжээ. Энэтхэгийн нэгэн сүмийн хажуугаар өнгөрч явтал хүмүүс Бхагавад Гита-г уншиж байхыг нь сонжээ. Бхагавад Гита бол Энэтхэгт их алдартай судар. Найз нарын нэг нь нөгөөдөө: “Алив! Хоёулаа дотогш орж судар сонсьё” гэжээ.

Тэгээд хоёул дотогш орлоо. Гэлээ ч гэсэн зөвхөн нэг нь сонсохоор үлдэж, нөгөөдөх нь зэрвэс харчхаад цэнгээний газрын эмс охидыг хараахаар явжээ.

Эмсийн хүрээлэнд очсон хүн удалгүй уйддаг. Тэр хийсэн зүйлдээ харамсаж, баахан ичиж байв. Тэр: “Иш! Энэ бол үнэхээр тэнэг явдал! Би маш их ичиж байна. Би ариун гэгээн сургаал сонсохын оронд яагаад иймэрхүү дэмий газар ирчхэв ээ? Миний нийз одоо судар сонсох зуураа хязгааргүй буян хишигтэй болж байгаа даа, гэтэл би өөрийгөө доош нь хийгээд биеэ үнэлэгчдийн газар байж байдаг. Ямар ёс суртахуунгүй юм бэ!” гэж боджээ.

Тэр өөрөөсөө ичиж, жигшиж, тэгээд судар сонсохоор сүм рүү буцлаа. Хэдийгээр эргэж ирсэн боловч хэдийнээ дуусчихсан байжээ. Тэр чин сэтгэлээсээ гэмшиж, дараа нь хэдэн өдөр харамсжээ.

Түүнийг цэнгээний газар байгаадаа ичиж байх үед сүмд үлдсэн нийз нь судар сонсож байхдаа сэтгэлээ тайвшруулж чадаагүй аж. (Багш болон бүгд инээлдэв) Түүний бодол санаа нь цэнгээний газар руу чиглэж: “Иш! Энэ үнэхээр уйтгартай юм! Би яагаад судар сонсохор энд үлдэв дээ? Миний нийз намайг энд суугаад судар сонсож байх зуур идэж ууж, цагийг сайхан өнгөрөөж байгаа даа. Ямар уйтгартай юм бэ!” (Багш болон бүгд инээлдэв)

Ингэж бодтол сэтгэл санаа нь тавгүйрхжээ.

Хэзээ хойно найзууд хоёул нас барав. Үхлийн элч судар сонссон нийзиг нь тамд аваачиж, цэнгээний газар очсон нийзиг нь тэнгэрт дэвшигүүлсэн аж. (Багш болон бүгд инээлдэв)

Яагаад гэдгийг нь мэдэж байна уу? Учир нь бүх зүйл бодол сэтгэлээс үүдэлтэй!

Бурхан зөвхөн бидний үйлдлийг хардаг юм биш. Тэр бидний зүрх сэтгэлийг хардаг! Заримдаа бид тухайн хүний төрх байдлыг хардаг ч тэр хүнийг яг тийм эсэхийг нь таньж мэдэж чаддаггүй. Бид дотоодоосоо хэмжисж чадахгүй л бол хүний дотоод сэтгэлийг үнэлж цэгнэнэ гэдэг маш хэцүү. Тэр хүн нинжин сайхан сэтгэлтэй харагдаж магадгүй ч зүрх сэтгэл нь тийм биш байж мэднэ, эсвэл тэр үнэхээр хайрлангүй зүрх сэтгэлтэй байж магадгүй ч гадна төрх байдал нь тийм биш шиг байж болно.

Энэ нь бидний зарим номын нохөдтэй адил юм. Тэдний өнгөрсөн амьдрал нь тийм ч ариун буянтай байгаагүйг та нар мэднэ, зарим нь том дээрэмчин юм уу, зарим нь хатагтай дээрэмчид байсан. (Багш болон бүгд инээлдэв) Зарим нь бусдын амийг хөнөөсөн, эсвэл нийгэмд хулээн зөвшөөрөгдөөгүй үйлдлүүд хийсэн. Гэвч тэд гэмисэнхийээ дараа чин сэтгэлээсээ өөрийгөө сэнхруулж, бясалгал хийж, бас өөрийгөө ариусгахаар шийдсэн

хэрэг. Эцсийн эцест тэдний нүгэл хилэнц цэвэрлэгдэх нь зайлшигүй.

Гэтэл зарим нь амьдралынхаа турийн ямар ч гэмт хэрэг хийгээгүй байж магадгүй боловч тэд энэ тэнүүгээр тэнүүчилж, бясалгалд суралцахыг юман чинээ бодохгүй, мөн Их Багшийг дөнгөж зэрвэсхэн харчхаад юу ч мэдрэхгүй өнгөрдөг. Тэд өөр их багшийг хайхаар явдаг биз. Тэд дандаа л дэлгүүр хэсэж байгаа юм шиг байдаг. Бид тэднийг “ууланд дэлгүүрээр хэсдэг” гэж хэлж магадгүй, яагаад гэхээр ихэнх гэгээрсэн Их Багши ууланд амьдардаг шүү дээ. (Багши болон бүгд инээлдэв) Тэд нэг уулнаас нөгөө уул руу үсэрч, нөгөө нь илүү ногоон, үзэсгэлэнтэй мэт санагддаг. Тэд сүнслэг бясалгал дадалдаа чин сэтгэлээсээ ханддаггүй болохоор хийж байгаа юм нь амжилтад хүрдэггүй.

Тиймээс бид Бурханыг сайхан мэт санагдах гаднах төрхөөрөө хуурч чадахгүй. Бид Бурханыг хуурч чадахгүй, учир нь Бурханыг мэхлэх нь өөрсдийгөө хуурахтай адил. Бид юу хүсэж байгаагаа, ямар юмыг хийж байгаагаа бүрэн ухаарч байдаг. Бид чин сэтгэлтэй байна уу, үгүй юу гэдгээ өөрсдөө тов тодорхой мэдэж байдаг.

Та нар бас эрт үеийн их багши нарын ярьсан зарим нэг үүх түүхээс унишсан. Тэдний зарим нь Жийдаан богд (хятадын их багши) шиг тун хачирхалтай байсан. Бид түүнийг мах иддэг, дарс уудаг, дандаа согтуу, бас уучлаад намбагүй унаад өгдөг гэж сонссон. Бас амьд гэгээнтэн Чин-Шан байсан. Тэр бас л сонин хувраг байсан. (Багши болон бүгд инээлдэв) Тэр үргэлж л маш эмх цэгцгүй, ёс журамгүй байсан. Гэвч тэд бясалган дадуулж, өөрсдийн хүрсэн сүнслэгийн түвшинг мэдэж байсан тул тэднийг Гэгээнтэн гэдэг байв. Тийм учраас үүнийг гадна талаас нь шүүн хэлэлцэх нь хялбар биш боловч сүнслэг бясалгал дадуулагчид бид чин сэтгэлтэй байгаа эсэхээ дотроосоо мэднэ. Бид мэдэхгүй байсан ч Бурхан мэднэ. Бусад хүн бидэнд итгэх нь бидний гаднах үйлдлээс шалтгаалахгүй, тэгэх албагүй! Шүүлтийг Бурхан хийдэг.

Жинхэнэ чин сэтгэлтэй байх нь сүнсний бясалгал дадалд хамгийн чухал зүйл. Нийтийн бясалгалд хүмүүс нам гүм суусан ч тэдний бодол санаа нь төвлөрөөгүй байж болно. Ийм учраас Багши нь та нарыг нийтийн бясалгалд очихдоо бие, хэл, сэтгэлээ цэвэр байлгаарай гэж дандаа хэлдэг юм. Тэгэхгүй бол та нар тэнд сууж байлаа ч буян хишиг хүртэхгүй, энэ нь гэртээ чин сэтгэлээсээ бясалгаж байгаа хүнийхээс ч дор юм. Тэд маш их чин сэтгэлтэй, төлөв төвшийн байж, өдөр бүр бясалгаж байгаа учир илүү их буян хураадаг.

Гэхдээ мэдээжийн хэрэг, бид ямар ч байсан нийтийн бясалгайл оролцож л байвал буян хураах болно, учир нь бусдын чин сэтгэл бидэнд нөлөөлнө. Жишээлбэл, бид энд ирээд их олон, үй түмэн хүнийг хичээнгүйлэн бясалгаж, буурь суурьтай сууж байгааг хараад санаа зовно, ингээд тэр бүх хугацаанд нам гүм суухыг хичээх болно. Тэгээд сэтгэлээ цэвэрлэн төвлөрүүлснээр маш их буяныг аяндаа хураах нь ойлгомжтой.

СҮНСЛЭГ ДАДУУЛАГЧИД ӨӨРСДИЙНХӨӨ ХЭРЭГЦЭЭГ ХАНГАДАГ БАЙХ ЁСТОЙ

Ж эгэн эр үзэсгэлэнтэй сайхан газар үзэх ч юм уу, эсвэл бага сага ажил хийхээр ч юм уу ойн гүн лүү явжээ. Тэгээд нэг өдөр санамсаргүй дөрвөн хөлгүй үнэгийг олж харав. Тэр үнэг энэ ширэнгэн ойд хөлгүйгээр яаж амьдарч байгааг гайхжээ. Тэгээд үргэлжлүүлэн ажиглав. Дараа нь барыг харлаа. Бар ангаа авчраад түүнийгээ идсэний дараа нь үнэг үлдэгдлээр нь хооллодог ажээ. Одоо ингээд тэр үнэг хэрхэн амь зуудгийг мэдлээ.

Дараагийн өдөр нь дахиад л Бурхан бас л бараар дамжуулан үнэгийг хооллов. Тэр эр үүнийг хараад өөрийгөө жаахан гэгээрлээ гэж боджээ, тэгээд өөртөө хэлсэн нь: “Аа хaa, бид Бурханд найдах хэрэгтэй юм байна. Бид Бурханд итгэх ёстой. Тэгвэл Тэр биднийг бүхнээр хангах болно.”

Тиймээс тэрээр ажил төрлөө орхин эхнэр хүүхдээ мартаж, бүр Шихү төвд нийтийн бясалгалд очихоо ч болжээ. (Инээлдэв) Тэр шуудхан л ойд суугаад Бурханы төлөө бүхнээс татгалзахыг хичээж, мөн Бурхан түүний хэрэгцээг хангах байх гэж найджээ. Тэр суугаад Бурханыг бясалгасан бөгөөд тэр Ариун Нэрсийг ердөө ч уншаагүй гэнэ.

Тэрээр “Би зөвхөн Бурханд л найдах болно. Би яагаад хэн нэгний нэрийг дуудах ёстой гэж? Би Бурханд л итгэнэ, Бурханд л хайртай, Бурханыг л шүтнэ, Бурханыг л хүндэтгэж, түүнээс л эмээнэ, энэ л миний хувьд хангалттай. Би бүх зүйлээ Бурханд даатгаж байна” гэжээ.

Ингээд тэр тэнд сууж байв. Тэр цөцгий, дүүфүү, бялуу, талх, бяслаг хүрч ирэхийг хүлээж байсан ч байж мэднэ.

Эхний өдөр юу ч ирсэнгүй, тэгсэн ч үргэлжлэн суусаар байв. Тэр: “Бурхан миний итгэлийг сорьж байна” гэж боджээ.

Дараагийн өдөр нь ч сууж л байлаа.

Хоёр дахь өдөр дүүфүү гарч ирэх байтугай хамар доорх газраас



нь байцаа ч ургасангүй. Юу ч болоогүй тул: “Өө, Бурхан миний зориг, сүжиг бишрэлийт шалгаж байгаа байх. Мэдээж би Түүнд итгэлээ харуулна, өөрийгөө бүрэн даатгах чадвараа, мөн Түүнд миний итгэл гүйвшгүй, мятаршгүй болохыг үзүүлнэ” гэв.

Ингээд тэр дараагийн өдөр ч суусаар л, хүлээсээр л.

Гурав дахь өдөр боллоо. Юу ч тохиолдсонгүй, цөцгий, талх, бяслаг, дүүфүү, байцаа, лууван, борооны ус ч хүртэл байдаггүй. Хонн, хонн. Одоо тэр сорилтыг заавал Бурханаас биш, хоолойнооскоо, ходооднооскоо, бүх үе мөчнөөсөө мэдрэх болов. Хамаг бие нь түүнийг өршөөхгүй байх гэж хичээх болжээ. (Багш болон бүгд инээлдэв) Ийнхүү тэр машид шаналж, юу болсныг бодохыг хичээв. Тэр Бурханд залбирч: “Намайг үүнээс илүү бүү сориоч; би Танд үнэхээр итгэж байна, би үнэхээр Таны төлөө бүгдээс татгалзаж байна. Танд итгэх миний итгэл гүйвшгүй, энэ хэзээ ч мөхөшгүй” хэлэв.

Ингээд тэнгэрээс ч юм уу, эсвэл түүний ходоодноос ч байж магадгүй, би мэдэхгүй байна, нэгэн дуу хоолой сонсогдлоо. (Багш болон бүгд инээлдэв) Тэр хоолой нэг иймэрхүү юм хэлжээ: “Өө, чи тэнэг муухаг юм, чи юунд эрэмдэг үнэгний байдалд суралцаад байгаа юм бз? Сэрээч ээ. Барын замаар яв.”

Яах вэ, бид лам болж болно, гэхдээ бид ажил хийх, эсвэл ямар нэгэн байдлаар өөрсдийнхөө амьдралыг залгуулах ёстой. Бидэнд багаж зэмсэг, оюун ухаан байгаа учраас амьжиргаагаа залгуулах ёстой гэж би та нарт хэлдгийн учир нь энэ. Бид бол эрэмдэг үнэг биши. Хэрвээ бид тийм байсан бол Бурхан биднийг харах байсан байх. Гэвч бид эрэмдэг биши байтлаа юунд эрэмдэг амьтдын замаар явах билээ? Бид арслан, бар, заан, морь шиг явах ёстой. Бид хэрэгцээгээ хангагч болохоос биши, гүйлгачин биши, юм унаад ирэхийг хүлээгчид биши. Энэ бол амьдралын хэв маяг. Бид энэ хуурмаг өртөнцөд байх хугацаандaa өөрсдийгөө тэжээж, сургаж, энэ бүх багаж зэмсээр тоглож, чадвар болон ухаанаа туршиж үзэх хэрэгтэй. Амьдрал юу өгөхийг харцаа. Маргааш юу авчрахыг харцаа.

Оюун ухаан, авьяас чадвараараа бид амьдрал бидний дотор ёсч хөгжисж байгааг хардаг; бид цаг улирлын байдлаас хамааран амьдрал хэрхэн өөрчлөгдөж байгааг ажигладаг; бид багаж зэмсээ ашиглан бидэнд, гэр бүлд маань, нийгэмд ямар ач тус хүргэж болохыг харж байдаг. Бид оюун ухаантай; бид түүнийгээ ашиглах ёстой. Билиг ухаан бол нэг зүйл, харин оюун ухаан болон авьяас чадвар бол бас өөр зүйл.

Билиг ухаан бидэнд байдаг, билиг ухааныг хэзээ ч биднээс булааж авч чадахгүй. Билиг ухааныг хөгжүүлэх боломжгүй, бохирдуулах, багасгах, нэмэгдүүлэх боломжгүй. Оюун ухаан, эрдэм мэдлэгийг бид энэ эгэл өртөнцийг дэх өдөр тутмын амьдралдаа ашиглах хэрэгтэй. Билиг ухааныг бид бусад хүнийг гэгээрүүлэх, эсвэл их илүү хүчийг олж авах гэх мэт бүүр агуу, эрхэм дээд зорилгоор ашиглах болно – жишээлбэл, эмчлэхгүйгээр эмчилж, мэдэхгүйгээр мэдээж, туслахгүйгээр тусалж, бидний зүгээс ихэмсэг зангийн ул мөргүй, ариун журмын шинж тэмдэггүйгээр өртөнцийг адислах хэрэгтэй. Бид ийм л байх ёстай.

Иймээс л бид өнөөдөр, маргааш, эсвэл өдөр бүр бясалгадаг. Энэ нь барын замаар явахтай адил юм. Бид хэрэгцээгээ хангана, бид адисална, бид асуухгүй, бид гүйлгачлахгүй. Бурхан, тэнгэрийн элчis, гэгээрэгсэд аль хэдийнээ үүргээ гүйцэтгэж байгаа гээж би бодож байна. Тэд ажлаа хийж байна. Одоо бид тэдний мөрөөр явж, тэдний ажлыг хийх ёстай – үргэлж өөрсдийнхөө төлөө залбирах, эсвэл энэ түр зуурын амьдралынхаа төлөө гүйлга гүйх биш. Бидэнд ямар нэг зүйл үнэхээр хэрэгтэй болбол үүний төлөө залбирч болно. Зөвхөн сүнслэг амьдралаа үргэлжлүүлэхийн тулд, гэхдээ сүнслэг хаант улсад үүрд битгийг гүйлгачин байгаарай.

ТОМ ГУТЛЫН АРГА

*Ө*нэтхэгт олон жилийн өмнө их сайн, маш сайхан нинжин сэтгэлтэй хаан байжээ. Тэр албатууддаа их хайртай. Тиймээс ард түмнээ хайраар, энэрэн нигүүлслэлээр, анхаарал халамжаар захирч байв. Гэвч албатуудаа харах бүртээ тэдний хөл рүү нь үргэлж санаа зовон хардаг байлаа. Эрт цагийн энэ үед хүмүүс гутал гэдгийг мэддэггүй байснаас хөл нь чулуу, өргөснөөс болж, үргэлж шалбардаг байжээ. Бут соөгний өргөс заримдаа гудамжинд унадаг. Тэгээд хүмүүсийг үүгээр явахад хөлд нь зоогчихно. Энэ нь шалбархай үүсгэж, цус гарах, бас халдварт ч үүсэх нөхцөл болдог байжээ.


Энэ байдалд хаан ихэд эмзэглэдэг байжээ. Тэр цэрэг, армийнхандаа үхсэн амьтдын арьс, үслэг эдлэлийг олж авчраад зам болгонд дэвс гэсэн тушаал буулгасан бөгөөд ингэснээр албатууд нь түүн дээгүүр явж, шархдахгүй байж болохоор болов. Зөвхөн зам ч гэлтгүй, улс орныхоо бүх газар дээр арьс шир дэвсэх тушаал өгчээ.

Түүнд их хөгшин мэргэн сайд байжээ. Тэр хаанд илүү сайн санаа байгаагаа хэлсэн нь: “Бүх газраар нэлд нь арьс дэвсэхэд цаг, хүч, менгэ их орно, түүний оронд хүн бүрийн хөлд бэхэлбэл тэд хүссэн газар руугаа явж болно” гэжээ.

Энэ нь их хөгтэй үлгэр боловч зарим зүйлийн бэлгэдэл юм. Ихэнх хүн буюу бид өөрсдөө ч гэсэн заримдаа энэ ертөнцийг тэгши эрхтэй, эв найртай, хөгжингүй, баян чинээлэг, нөхөрсөг, хайраар дүүрэн гэх зэрэг байдалтай болгохыг хүсдэг, гэвч энэ нь хүссэнээр болдоггүй. Энэ нь өнөөх чулуу, өргөстэй адил, тэд зам дээр унасаар л байх болно. Заримдаа буур тэнгэрээс газрын өндөрлөг орой дээр ч унана. Та нар газраар хэчнээн дэвссэн ч бай хамаагүй, арьсан дээр нь чулуу, өргөс ахин дахин унах болно. Иймд бид хөлдөө л анхаарал тавьсан нь илүү дээр.

Арьяабалын арга бол яг та нарын хөлд зориулсан гуталтай адил. Хэдийгээр энэ ертөнц янз бүрийн асуудлаар дүүрэн, чулуутай, өргөстэй байсаар байгаа боловч бид түүн дээгүүр явж чадах төдийгүй, агуулгүй байгаагаа мэдэрнэ. Олон хүн Арьяабалын аргаар бясалгахгүй байгаа нөхцөлд энэ ертөнц янз бүрийн асуудалтай байсаар байх болно. Тиймээс бид гай

зовлонгоос ангид байхыг хүсвэл өөрөө өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй. Тэгвэл асуудалгүй. Асуудал байсаар байжс магадгүй ч бидний хувьд тийм ч их биш байна. Та нар энэ ертөнцийн асуудлаас болж сэтгэл өвдөх нь багассаар байгаагаа мэдрэх болно. Зарим үед, хэрвээ бидний сэтгэл хөндүүр болбол тэр нь зовлонд нэрвэгдсэн хэн нэгнийг хайллан энэрсэнтэй холбоотой байдал.



БУРХАНД ӨРГӨХ ЖИНХЭНЭ ӨРГӨЛ



Ж нэ бол сэтгэлийн мөргөл үйлдэх тухай түүх. Сэтгэлийн мөргөл гэдэг нь сүсэгтэн, дагалдагч нь мөргөлдөө зориулж цэцэг, утлага сан, бөмбөр, хэнгэрэг, хөшөө баримал, эсвэл идээний өргөл гэх мэт гаднах өнгөн талын ямар ч зүйл хэрэглэхгүйгээр Бурхдын эрдмийг сэтгэлдээ санаж, бишрэл төрүүлэхийг хэлнэ.

Бхагавад Гитад өгүүлдэг Эзэн Кришнаг дагагч Аржуна га та нар санаж байна уу? Аржуна Бурханыг шүтэхдээ гаднах өнгөн талын зүйлийг удтал сүр жавхлантайгаар үйлдэх дуртай байжээ. Түүнд тоо томшгүй олон гэрэл гэрэлтүүлсэн цэлгэр том шүтлэгийн өрөө байсан билээ. Тэндээ алт, мөнгөн сав суулга

хэрэглэнэ. Тэрээр Эзэн Шиваг шүтэх ёслол үйлдэлдээ өчинөөн цаг зарцуулдаг байжээ. Олон цагийн турш Эзэн Шивагийн дүр зураг луу тэрэг тэргээр дүүрэн цэцэг авчуулан шидэн сууж чадна. Браhma, Вишну, Шива зэрэг Хинду бурхадын нэг Эзэн Шиваг та нар мэднэ дээ. Шива нь сөнөөгч Эзэн байх учиртай. Үнэндээ тэр чөтгөрийг сөнөөдөг болохоос сайн хүмүүсийг устгадаггүй.

Мөн Аржуунагийн дүү Бхима гэдэг хүн байжээ. Тэр хэзээ ч мөргөл үйлдэхээр сууж байгаагүй. Хэзээ ч сүм рүү явдаггүй, үргэлж л Миаоли руу явна. (Инээлдэж алга ташив) Зөвхөн оройн хоолны өмнө цөөн хэдэн минутыг нүдээ анин Их Эзэнд сэтгэлийн мөргөл үйлддэг байжээ. Магадгүй тэр өргөл өргөж, Ариун Нэрсийг унших, эсвэл үүнтэй адил ямар нэг юм хийдэг байсан байх.

Аржуна өөрийгөө Эзэнийг асар их биширдэг, мөн өндөр дээд хэмжээний шүтлэг бишрэлтэй гэж боддог байжээ. Тэр дүү Бхимагаа ямар ч шүтлэггүй гэж боддог учраас түүнийг үл тоомсорлон хардаг байв. (Инээлдэв)

Эзэн Кришна Аржуунагийн энэ хандлагыг олж мэдээд түүнийг саруул ухаантай болгох сайн сургамж өгөхийг хүсжээ. Тэгээд Эзэн Шиваг тахидаг Кайлас уул руу аялахыг Аржуунад санал болгов.

Тэгээд тэд замдаа ороод явж байтал олон янзын цэцэг ачсан тэрэг түрээд явж байгаа хүнтэй тааралдаж гэнэ. Аржуна цэцгийг хаашаа авч явж байгааг асуухад тэр эр ажилдаа ихэд автаж, маш их төвлөрч байсан тул дуугарсангүй гэнэ. Тэгэхэд Эзэн Кришна Аржуунад хэлсэн нь: “Энэ эрийг дагаж яваад ямар учиртайг олж мэдье”.

Аржуна зөвшөөрч, хоёул нөгөө эрийг дагалаа. Тэгж явсаар Шихү төвийн дов толгод шиг том овооны хажууд өнөөх тэргийг хоосолж байхыг харлаа. Цаашлаад тэнд цөмд нь цэцэг ачсан хэдэн зуун тэргэнцэр нэг газар дөхөж ирэн доторх юмаа тэнд хоосолж байхыг харав. Тэнд шинэ цэцгийн томоос том уул босжээ.

Аржуунагийн сониуч зан улам нэмэгдэж гэнэ. Сониуч зангаа хянаж дийлэлгүй нэг эрээс: “Энэ цэцэгтэй тэрэгнуудийг хаанаас авчирсныг хэлж өгөөч” гэж асуужээ.

Тэдний хэн нь ч хариулахыг завдсангүй. Гэтэл нэг эр Аржуунаг ахин дахин асуусны дараа хэлсэн нь: “Эрхэм хүндэт ноёнтон минь, сайн санаж бидэнд битгий саад болооч, бид хэтэрхий завгүй ажилтай байна. Бидэнд хэн нэгэнтэй ярилцах цаг алга. Бид зөвхөн долоон зуун тавин цэцэгтэй тэргийг авчраад

байна. Гэтэл дахиад сүмд долоон зуун тавин тэрэг байж байгаа. Энэ нь өчигдөр Пандугийн хүү Бхимагийн бидний Эзэнд мөргөж барьсан цэцгэг юм” гэв.

Энэ нь цэцгийн уул бол авчрах ёстой зүйлийнх нь зөвхөн хагас нь, үлдсэн хагас нь сүмд байгаа гэсэн үг. Энэ бүх цэцгэг Бхимагаас иржээ, Аржунаагийн дүү тэр залхуу нэгэн, тэр сүмд хэзээ ч очдоггүй нэгэн, Эзнийг хэзээ ч шүтдэггүй, юу ч хийдэггүй, Эзэнд хэзээ ч цэцгэг өргөж, утлага сан уугиулдаггүй, Аржунаагийн эртнээс дорд үзэж байсан хэрэггүй нэгэн, шашинд үл сүсэглэгч нэгэн, Бурхан шүтдэггүй түүнээс шүү.

“Өнөөдрийн залбирал эхлэхэд дөрвөн цаг дутуу байна, одоо энэ хугацаанд амжиж бүх цэцгийг бид хураах ёстой. Өдөр бүр түүний мөргөл бишрэлээс цэцгийн уул үүсдэг”. Ингээд тэд өдөр бүр ийм их цэцгийг хураах шаардлагатай болдог байна.

Аржуна гайхсанаасаа болж, цочирдон асуусан нь: “Чиний яриад байгаа чинь Бхима юм уу, Аржуна юм уу? Та андуураагүй гэдэгтээ итгэлтэй байна уу? Та Аржуна г хэлж байгаа биз дээ, тийм үү? Аржуна бол Бхима биш?! Найз минь энэ тухай бод доо, чи андуурч байгаа байх. Түүний нэр Аржуна, Аржуна, А-р-ж-үн-а. Тийм байх ёстой!”

Тэр эр хариулсан нь: ”Пээ, Аржунаагийн тухай бүү ярь. Биш, биш, биш! Огт биш, огт биш! Ийм сүр жавхлант шүтлэгийг Бхима л чин бишрэлтэйгээр үйлддэг болохоос биш, зүгээр л мөргөж байгаагаа гаднаас нь харуулдаг түүний ах Аржуна биш” гэв.

Тэгж байтал өөр нэг эр багц цэцэгтэй ирлээ. Эзэн Кришна үүний учрыг мэдээгүй юм шиг зориуд тэр эрээс асуусан нь: “Өө, найз минь, энэ цэцгийг хэн өргөж байгаа юм бэ?”

Мэдээж та нар хариултыг мэдэж байгаа.

Тэр эр хэлсэн нь: ”Энэ бол дэлхий дээрх хамгийн сайрхуу эрийн өчигдрийн өргөл юм. Түүнийг Аржуна гэдэг. (Инээлдэв) Тэр жинхэнэ хайр бишрэлгүйгээр шүтлэгээ үзүүлбэр болгодог юм”. Тийм болохоороо цэцгийн ганц багц өргөсөн ч үүнийхээ тухай дэндүү их ярьдаг.

Аржуна ичингүйрэн толгойгоо намс хийлгэж, Эзэнд хэлсэн нь: “Ээ, Кришна, Чин Хай Ву Шан Ши (Инээлдэв) та нар яагаад намайг энд авчирсан юм бэ? Энэ газрыг орхиё. Та намайг гэртээ байхад миний дутагдал, бардам зан, хоёр нүүр гаргадаг, сайрхуу байдлын талаар сэрэмжлүүлэн энэ бүх зовлон зүдүүр, төвөгт удсан байдлаас хэлтрүүлж байхгүй дээ. Би шүтлэг, сүсэг бишрэлийнхээ талаар маш их боддог байснаа хүлээн зөвшөөрч байна. Би

Бхиматай жигшин зэвүүцэж харилцдаг байсан. Харин одоо би Бхимагийн чин сэтгэлтэй богинохон бясалгал нь миний бүхэл өдрийн турш шүтлэг бишрэлээ гайхуулсан үзүүлбэрээс илүү үнэ цэнтэй гэдэгт итгэлээ”.

Эзэн Кришна инээмсэглэн дуугүй л байсан гэнэ.

Тиймээс, энд, манай сүм бии сүмд бид цэцэг, хүж, бөмбөр, хэнгэрэг болон бусад зүйлтэй хутгалдаггүй гэдгийг та мэдэж авлаа. Та нар зөвхөн чин сэтгэл болон дотоод бишрэлдээ л санаа тавь. Тийм учраас би та нарыг төвлөр, бясалга, гаднах үйлдэл тийм ч чухал бии, надад байтугай өөр ямар ч гэгээрсэн Их Багшид мөргөх хэрэггүй гэдгийн учир энэ.

Хэрэв та нар гэгээрсэн Их Багшийг дотооддоо хараад хүсвэл Тэдэнд мөргөж болох юм. Гэвч гэгээрсэн Тэд ийм зүйлийг хүлээгээд байдаггүй. Тэд таныг Би – дээ үнэнч байхын тулд Төрөлх чанараа олж, Гэгээнтэн болох, эсвэл Бурхантай нэгдмэл болохыг л хүлээдэг. Өөрийн гайхамшигт Төрөлх чанараа олж, өөртөө болон бусад олонд тус болоорой. Үүнийг л Бурхан биднээс хүлээдэг юм.

ГҮЙЛГАЧИН ЭМГЭНИЙ БИЛИГ УХААН



*М*эддэг ихэнх хүн ярьдаггүй, харин мэддэггүй хүмүүс нь ярьдаг. Мэдээжийн хэрэг, Будда, эсвэл Есүс шиг Их Багши нар явж, ном айлдаж байсан боловч энэ нь өөр хэрэг байсан. Тэд үүнийг хийх ёстой байсан; тийм бишсэн бол Тэд ингэхийг хүсэхгүй байх байсан. Хэдийгээр Тэд зовж шаналж байсан ч Тэдний даалгавар ийм байсан. Тэд үүнийг хүсээгүй. Гэвч энэ нь тэднийг үргэлж мэтгэлцэх сайхан боломж хайж, гадаги явах дуртай гэсэн үг биши. Энэ бол ялгаатай шүү. Тэд иймэрхүү мэтгэлцээнийг жигшииж, холхон явахыг боддог. Тэд зүгээр л өөрсдөө нь ирсэн шавь нарыг сургах ажилтай байсан. Гэхдээ Тэд мэдлэгээ гайхуулах гэж гадуур гарч, бусадтай мэтгэлцээд байдаггүй.

Одоо Дилав гэгээнтний тухай ярья. (Дилав бол гайхамшигтай,

аугаа Их Багш бөгөөд Мял Богдын Их Багш нь билээ) Тэр номын мэдлэгээ гайхуулан Энэтхэг даяар явж байсан хүмүүсийн нэг. Хaa ч явлаа гэсэн тэр л ялдаг. Түүний номын талаарх мэдлэг нь асар өргөн цар хүрээтэй байсан тул хэн ч, хэзээ ч ялж байгаагүй. За тэгээд Дилав хутагт гэлтгүй олон оронд ийм хүмүүс байлаг.

Нэг өдөр тэр гэртээ байхдаа тухайн үеийн хамгийн алдартай, үнэ цэнэтгий номын нэгийг уншиж байлаа. Тэгтэл маш туранхай, өлөн, хир буртаг болсон гуйлгачин эмгэн хажуугаар нь өнгөрөхдөө нэг иймэрхүү юм хэлжээ: “Чи үнэхээр хичээнгүйлэн унших юм, гэвч чи жаахан ч болтугай ойлгож байна уу?” (Инээлдэв)

Юу? Дилав хутагт ихэд цочирдов. Ийм нэг хөгшин гуйлгачин над шиг эрдэмтэн, судлаачийн өмнө ингэж ярьж яаж зүрхэлж байна аа? Тэр бага зэрэг аиж, яаж хариу өгөхөө мэдэхгүй байв. Тэгтэл өнөөх гуйлгачин эмгэн ном луу нь нулимчхаад яваад өгчээ.

Ариун ном луу нулимж зүрхэлсэнд нь маш их уурлав. Ингээд араас нь хөөлөө. Араас нь хөөж явтал эмгэн ердөө л амандаа нэг юм бувтнах төдийд тэр гэнэтхэн тайвширч, ямар ч уурласан шинжгүй болчихжээ. Тэгээд тэндээ зогсоноо буцаж, гэртээ хариад бодож эхэлжээ. Магадгүй энэ бүх номоос сурч байгаа аргад нь ямар нэг буруу зүйл байна гэж боджээ. Тиймээс тэр бодсоор байв, маш нухацтай боджээ. Бүх Энэтхэг даяар олон мянган жил дээдэлж ирсэн ариун нандин ном луу гуйлгачин эмгэн яаж нулимж зүрхлэв ээ? гэж тэр нэлээд боджээ.

Энэ номыг шүтдэг хүмүүс номд мөнгө өргөдөг байжээ. Одоо хүртэл Энэтхэг зэрэг зарим улс оронд ингэсээр байна. Би мэнднэ, харсан юм. Тэд номд мөргөж, мөнгө, цэцэг өргөдөг, тэгээд энэ бүгд нь эрдэм мэдлэг, билиг ухаан мөн гэж итгэдэг. Гэвч ном л бол ном шүү дээ. Чи бол чи. Та нар номд мөргөөд л түүнээс ямар нэг юм авна гэж яаж боддог байна аа? Гэвч олон хүн үүнд итгэдэг.

Ингээд Дилав хутагт улам бодсоор байв. Тэр сүл дорой эмгэн ганц хоёр өгүүлбэр бувтнангутаа л түүний гал мэт уур хилэнг нь усаар дарсан мэт унтрааж байсныг бас их гайхаж байв. Хэсэг хугацаанд бодож үзсэний эцэст тэр дахин мэтгэлцэхээ больж, ажлаа орхижээ. Тэр гуйлгачин эмгэнийг хаа сайгүй хайж, өөрийнх нь ойлгоогүй зүйл юу болохыг олж мэдэхийг хичээнгүйлэн хүсжээ.

Нэг өдөр эмгэнийг ширэнгэ ойн дунд ганцаараа байхад нь олжээ. Тэр түүнтэй мэтгэлцэж, хамаг л цэцэн цэлмэг үг, мэдлэг чадвараа ашиглан давж гарахыг оролдсон байна. Гэвч энэ нь амжилт олсонгүй, түүнийг хэчинээн хичээх тусам л тэр эмгэн

үргэлж ялаад байв. Тэр хөгшин, муухай, ядуу, өлөн гүйлгачин үргэлж л ялж байлаа. (Багш болон бүгд инээлдэв) Эцэст нь эмгэн хэлсэн нь: “Миний ойлгодог, надад байгаа билиг ухаан номд байдаггүй. Чи үүнийг олж чадаагүй, тийм учраас надтай мэтгэлцээд хэзээ ч дийлхэггүй”.

Эцэст нь Дилав хутагт эмэгтэйд мөргөж, түүнийг Их Багш хэмээн хүлээн зөвшөөрч, өөрийг нь сургаж өгөхийг хүсжээ. Эмгэн ч зөвшөөрчээ. “Чиний мэдэхийг хүссэн бүхэн номд байхгүй, бас энэ дэлхийд ч байхгүй. Зааж сургах диваажингийн төрөлтнүүдийг чи заавал олох хэрэгтэй” гэж эмгэн түүнд хэлсэн аж.

Ингэх зам бол авшиг авах явдал юм. Бид дотоод луугаа явж, тэр диваажингийн төрөлтнүүдийг олох явдал. Үүний утга нь энэ л юм. Тэгээд бид түүнээс суралцаана.

Би та нарт заасан ч, аль нэг өөр Их Багши заасан ч энэ бол амаар, зөвхөн физик байдлаар зааж байгаа хэрэг. Хэрэв та нар илүү сайн зүйл сурахыг хүсч байгаа бол бие махбодтой нэгнээс биши, харин дотоод дахь ухамсырхаяа өндөр дээд түвшинд хүрч, дотоодын Их Багшаасаа, хaa сайгүй оршигч Их Багшаасаа суралцах хэрэгтэй. Энэ махран биетэй нэгэн бол та нарыг оюун ухааны өндөр түвшинд хүргэх шат л юм. Тэнд та нар ухамсын илүү өндөр, нарийн түвшинд Дээд Багшаас, одооны энэ Их Багшаас, эсвэл өөр нэг Их Багшаас суралцах болно.

Хожим нь Дилав хутагт бүхнийг хаяж, тэнгэрийн оронд очиж, энэ диваажингийн төрөлтнүүдтэй уулзаж, тэднээс суралцах гэж шаргуу мэрийжээ. Тэр диваажингийн төрөлтнүүдэд хүрэх зам нь урхи занга, саад бэрхшээлээр дүүрэн байсан ч бүгдийг даван туулж чадсан юм.

Тэр бол Дилав хутагт. Хэдийгээр алдар цуутай, эрдэм мэдлэгтэй хүн боловч явж явж, хөгшин, муухай, өлсгөлөн, гүйлгачин эмэгтэйд билиг ухааны төлөө мөргөсөн юм. Иймд биднийг чөлөөлөх замыг мадаггүй харуулж чадах, билиг ухаантай хэнд ч очиж мөргөх нь бидний хувьд хэтэрхий дор орсон зүйл биши.

Дээр үеийн ихэнх Их Багши ядуу байсан. Есүс мужсаан байсан; Тэр хэзээ ч хөрөнгөтэй байгаагүй. Бууда дэндүү их хөрөнгөтэй байсан ч Тэр бүгдийг орхисон. Тиймээс Түүнд бас юу ч байгаагүй. Энэтхэг даяар хэрэн явж, идэх юм гүйдэг байсан. Тэр яаж ийгээд л бас гүйлгачин болжээ. Ихэнх Их Багши эзэмших юу ч үгүй байв. Хэрэв тэд ингэхийг хүсч байвал энэ ч бас зүгээр.

Сикх Их Багши нарын нэг, аравдугаар Сикх Их Багши маш их алдартай байв. Тэр өмч хөрөнгөтэй байжээ. Тэр маш баян

харагдаж байсан бөгөөд ханхүү шиг л олон үнэт эдлэл өмсдөг байв. Тэр хэзээ ч уунээс татгалзаагүй. Гэтэл бусад Сикх Их Багши улс орон даяар хоол гүйж явдаг байлаа. Тиймээс Их Багши нарыг тийм ийм байх ёстой гэж ярих хэрэггүй. Үүнд асуудал байхгүй.

Та нар Арьяабал Бодьсадва-г харж байна, Тэр маш их голт чимэглэлтэй, ус нь их урт сайхан, бас Тэр сайхан хувцас өмсдөг. Тэнгэрийн хүмүүс их үзэсгэлэнтэй. Тэдний голт нь угаас зяасан, буянд нь тохирсон байдал.

Иймд Их Багши нар үргэлж ядуу байдаг гэж ярьж болохгүй. Энэ нь заавал ийм, тийм байна гэх албагүй. Ихэнх Их Багши дотоод ухамсынхаа ачаар эгэл амьдралыг сонгодог учраас ийм байдал. Гэхдээ Их Багши үргэлж үүнийхээ дагдуу ажилладаг. Энэ нь үргэлж ийм байх ёстой гэсэн уг биш юм, яагаад гэвэл хэрэв Их Багши ядуу, эгэл амьдрах, эсвэл эгэл жирийн хувцаслахыг хүсдэг байвал энэ нь бас нэг төрлийн хулээс юм. Үргэлж нэг юм уу, нөгөөт туйлишралтай зууралдах нь ер сайн зүйл биш. Их Багши бол дотооддоо л огоорсон байх ёстой болохоос биш, гадна тал нь хамаагүй. Энэ нь та нарын нөхцөл байдал, язгуур гарлаас шалтгаална, эсвэл хамаг амьтны тусын тулд юу хийх ёстой зэргээс шалтгаална.

ЯЛГАВАРГҮЙ ХАЙР



*Ж*эгэн цагт тийм ч баян биш, бага гарын бизнесч эр байжээ. Түүний бизнес тийм ч амжилттай байгаагүй ч тэр дажгүй, болоод л байж гэнэ. Тэр байгаа байр байдалдаа сэтгэл хангалаун, гэр бүлдээ анхаарал халамжтай байжээ.

Гэтэл түүний хөрш нь Үнэнийг бясалгагч ядуу эр байж. Хөрш бизнесч нь болон бусад хөрш нь түүнийг өвөл, зарим хүнд хэцүү үеийг даван туулахад нь нэмэр болж, хүнс болон материалын тусламж үе үе өгдөг байлаа. Ер нь өгөхдөө маш жаахан, бүр өчүүхэн, түүний орлогын мянганы нэгтэй тэнцэх хэмжээний ч байж магадгүй – жижигхэн талх, заримдаа жигнэмэг, байцаа, багц лууван, будаа гэх мэт нэг их үнэ хүрэхгүй зүйлийг л Үнэнийг бясалгагч хөршдөө өгдөг болсноос хойш түүний бизнес, гэр бүл, эрүүл мэнд нь сайжирч, хүүхдүүд нь илүү дуулгавартай болж, бас илүүхэн мөнгө олдог болжээ.

Ингээд тэрээр илүү их мөнгө олох тусам хөрш бясалгагчдаа

илүү ихийг өгдөг болжээ, учир нь тэр одоо илүү их мөнгтэй болсон шүү дээ. Өгөх тусам ихийг олж, бизнес нь цэцэглэн хөгжиж, бүх зүйл улам сайжирсаар байв.

Дараа нь тэр сайжирсан бүхнээ хөршдөө буян болсонтойгоо холбон бодож эхэлжээ. Энэ нь ч зөв байж. Тэр дотроо ингэж бодож эхлэв: “Аан, энэ залууд би хэчинээн их өгөх тусам миний бизнес төчнөөн их сайжрах юм байна. Би түүнийг их багштай гэж сонссон; тэр их багшийгаа өөрөөсөө сая дахин аугаа хүчтэй гэж хэлж байсан”. Тэгээд тэрээр бизнесч хүний сэтгэлгээгээр ингэж бодов: “Аан хaa! Олон саяар илүү. Хэрэв би зүгээр л нэг муу шавьд нь өглөг өгөхөд миний бизнес хэд дахин нэмэгдээд байгаа юм чинь түүнээс зуу, сая, тэрбум дахин илүү аугаа гэж хэлсэн их багшид нь өгвөл миний бизнес...”

Тэр дотроо юу гэж бодсоныг та нар төсөөлж байгаа биз дээ. (Бүгд инээлдэв) Тэгээд тэр хураасан мөнгөнөөсөө гаргаж, маш нандин сайхан бэлэг бэлдэж, хөршийнхөө их багшийг хайн холын замд гарлаа.

Ингээд тэрээр зөвхөн их багшид нь өргөл өргөж, хөршдөө юм өгөхөө больж гэнэ. Сонссоныхоо дагуу аугаа их багшид өргөл өргөдөг болсноос хойш түүний бизнес муудаж, өдрөөс өдөрт дорджээ. Их Багшид илүү их өгөх тусам түүний ашиг багасаж, тэр цаашид тэвчих аргагүй боллоо. Бараг дампуурав. Гэртээ ч юу ч үгүй болж. Бүх гэр бүлээрээ өлбөрч үхэх дээрээ тулжээ.

Тэрээр аугаа их багшийн өөдгүй шавь гэгч хөрштэйгөө ярилцахаар очлоо. Тэгээд түүнээс асуусан нь: “Чиний их багш чамаас олон дахин илүү гэж чи надад яаж хэлж чадав аа?”

Шавь хэлсэн нь: “Тийм ээ, мэдээж би үнэнийг л хэлсэн, миний их багш тайлбарлаж хэлснээс минь ч илүү тийм аугаа. Энэ бол зуун сая дахин илүүгээс ч илүү. Би түүний ямар аугаа болохыг тайлбарлаж чадахгүй. Иймд би танд хэлэхдээ надаас зуун тэрбум дахин илүү гэсэн. Гэхдээ тэр түүнээс ч аугаа шүү”.

Бизнесч хэлсэн нь: “Гэвч би түүнийг чамаас илүү агуу, илүү гайхалтай, илүү буянтай, илүү нэр хүндтэй гэж бодоод түүнд өргөл өгөхөөр явсан юм; түүнээс хойш миний бизнес уналтад орж, би бараг өлбөрч үхэх нь, одоо хамаг гэр бүлийнхэнд минь ч идэх юм алга. Яахаараа ингэдэг байна?”

Шавь хэлсэн нь: “Өө, урьд нь та надад сайхан сэтгэлээр, хайр энэрлээрээ өргөл өргөж байсан. Би гачигдаж байсан учраас хариуд нь юу ч нэхэлгүй зүгээр л өгдөг байсан. Та хайраар, ямар ч хүлээлтгүйгээр өгдөг байсан. Та санаандгүй байдлаар,

ерөөсөө ялгаж салгахгүй, надад өгөх нь ашигтай эсэх талаар юу ч бодолгүйгээр өгдөг байсан. Та хайлаж байсан учраас л өгдөг байсан.

Бурхан бас чөлөөтэй өгдөг. Тэр яг тань шиг, хэнд өгснөө ялгаварлаж үздэггүй. Та надад өгөхдөө намайг сайн уу, муу юу, зохистой юу, үгүй юу гэж ялгаж үзээгүй. Гэвч дараа нь, та намайг болон миний их багшийг ялгаварлаж, их багшийг маань буянтай, ашигтай, эрхэм хүндэтгэл хүлээсэн ариун эр гэж бодон түүнийг сонгож, буяны өргөл өргөсөн. Бурхан ч гэсэн адилхан ялгаварласан байна. Тэр бас зөвхөн буянтай, зохистой, бас ариун явдалтайд нь өгсөн. Яагаад гэхээр та ялгаа гаргасан учраас Бурхан бас ялгаа гаргасан байна” хэмээжээ.

Тиймээс та нар гэр лүүгээ хариудаа хайр чинь ялгаваргүй байгаа эсэхийг шалгаарай. Таны хүүхдүүд маш муу, нөхөр тань олиггүй, хөрши чинь аймшигтай байж магадгүй, гэвч тэднийг хайлрахыг хичээ. Бүгдийг ижил хайраар биши, гэвч тохирсон хайраар боломжийнхoo хэрээр хайлра. Чадах чинээгээрээ, зөвхөн хэрэгтэй үед нь хайлра; тэгвэл та нар тусалж чадах болно. Үгүй бол зүгээр л бүгдэд нь ижил тэнцүү, ялгаварлалгүй, зүрх сэргэлдээ нөхөрсгөөр, үзэн ядалтгүй хандаж бай, учир нь та нар хүн болгоныг ижил хайлаж чадахгүй байгаа шүү дээ.

Бурхан биднийг хүн бүхнийг адилхан хайлра гэж албаддаггүй, тийм байтал бид яагаад тэгэх ёстой гэж? Бид үүнд хүчлэх хэрэгтэй; гэвч бид тэднийг хайлрадаг, өөрөөр хэлбэл тэдэнд бидний хэрэг гарах бүрт, хэдийгээр тэд өмнө нь биднийг хохигоож байсан ч хамаагүй, бид эргэж тоирч, нэн даруй туслах хэрэгтэй. Тэднийг хайлрах гэдгийн утга нь бид тэднийг үзэн ядахгүй, ямар ч муу санаа, эсвэл сөрөг зүйл хүсэхгүй, харин сайныг өрөөж, тэдний төлөө залбирч, тэдний төлөө бясалгах хэрэгтэй гэсэн үг юм.

ХУЛГАЙЧ БЯСАЛГАЛ ДАДУУДАГЧ БОЛСОН НЬ



Ж эгэн хулгайч ордоос юм хулгайлах гэж байгаад санамсаргүй хоёр тайганы яриаг сонсчихжээ: “Манай хаан гүнжээ Ганга мөрний эрэгт бясалгал хийдэг лам нарын нэгэнтэй гэрлүүлэхийг хүсэж байна. Чи үүнийг юу гэж бодож байна?”

Нөгөө тайган хэлсэн нь: “Сайхан санаа байна! Энэ маш сайн! Гүнж бол манай улсын хамгийн эрхэм хүн, харин Ганга мөрний хөвөөнд бясалгагчид бол энэ өртөнцийн хамгийн буянтай,

хамгийн эрхэм дээд хүмүүс. Үнэндээ би энэ санааг зөвшөөрч байна, тун сэтгэл хангалуун байна!” гэв.

Үүнийг сонсоод хулгайч хийх ажлаа орхиж, оронд нь лам болохоор сэмхэн гэрдэг буцжээ. (Инээлдэв) Хурдхан үсээ хусаж, ламын нөмрөг нөмрөв. Тэгээд гүнж түүний эхнэр болно гэсэн бүрэн итгэлтэйгээр бясалгаг хийж байгаа лам нарын дунд орж суув.

Хэдэн өдрийн дараа хаан үнэхээр Ганга мөрний хөвөө рүү лам нараас гүнжтэй гэрлэх хүсэлтэй лам байгаа эсэхийг асуулгахаар тайганаа илгээжээ. Тайган хүн нэг бүрээс асуув. Хүн нэг бүрээс асуусан боловч үргэлж л татгалзсан хариу сонсож байж.

Тэр сайн бясалгагчдын сонирхлыг гүнжийн тухай яриа өчүүхэн ч татаагүй бөгөөд бүгд л татгалзав гэнэ. Зөвхөн нөгөө хулгайчаас л асуух үлдээд байсан бөгөөд тэрээр тэнд хүлээн сууж байхдаа зүрх нь галзуурсан мэт цохилж байв. Тэр бодол санаагаараа бархирч: “Би энд байна! Наашаа хурдан ир” гэж байлаа. (Инээлдэв)

Эцэст нь тайган түүнээс асуухаар ирлээ. Тайган түүнээс асуух үед тэр дуугүй л байж, (инээлдэв) нэг ч үг хэлсэнгүй. Бусад нь бүгдээрээ л хүсэхгүй байна гэж хэлсэн байтал тэр юу ч хэлсэнгүй. Энэ нь аль хэдийнээ асар их ялгаа шүү дээ.

Тайган үүнд маш баярлаж, хаанд илтгэсэн нь: “Гангын хөвөөнд бясалгагч нэг л лам гүнжтэй гэрлэх санаатай юм шиг байна. Би түүнээс асуухад тэр дургүйцээгүй бөгөөд дуугүй байна гэдэг нь тэр зөвхөн зөвшөөрснөө шийдэмгий хэлээгүй л болохос ерэн хувь зөвшөөрч байна гэсэн үг. Миний асуусан бүгдээс зөвхөн тэр л “үгүй” гэж хэлээгүй”.

Сайхан мэдээнд баярласан хаан их хэмжээний бэлэг аваад өөрийн биеэр тэнд очьё, тэгвэл тэр лам гүнжтэй лавтай суух байх гэж боджээ.

Тэгээд хаан бүхий л зөвлөх, жанжин, тайганаа дагуулан хулгайчийн бясалгаж байгаа Ганга мөрнийг зорилоо. Тэр маш их хүндэтгэлтэйгээр “лам”-аас гүнжтэй гэрлэхийг хүсэв. Хаан сүнслэг бясалгаг дадуулагч байсан тул гүнжийг ердийн хүнтэй гэрлүүлэхийг хүсээгүй аж. Тэрээр охиноо сүнслэг бясалгаг дадуулагчтай гэрлүүлэхийг эрмэлзэж байгаа нь охин нь сайн нөхөр, сайн багшийн нөлөөнд сайн бясалгах байх гэж бодсоных юм. Хаан гүнжид яаж бясалгахыг зааж өгч чадах, гүнжийг буянтай хүн болгож чадах тийм л хүргэнтэй болбол сая сэтгэл хангалуун байж чадна. Иймд Ганга мөрний эрэгт бясалгаж буй бясалгагч

гүнжтэй гэрлэж болох тухай сонсоод их баярлаж байлаа. Тэрээр түүнийг нэн их хүндэтгэж, түүнд мөргөн охинтойгоо гэрлэхийг гүйв.

Хулгайч их л маадгар болж бодсон нь: “Намайг дөнгөж сая лам, сүнслэг бясалгал дадуудагч дүртэй болж, зүсээ хувирган үсээ хусаж, хуврагийн нөмрөг нөмөрсөн байтал хаан болон түүний хамаг зөвлөх надтай ийм их хүндэтгэлтэй харилцаж, ийм үнэт зүйл, хөрөнгөөр өргөл барьж байна. Хэрэв би жинхэнэ лам, жинхэнэ сүнслэг бясалгагч болвол юу болохыг төсөөлж чадашгүй нь!”

Ингэж бодсон тэр гэнэт гүнжтэй гэрлэх хүсэл өчүүхэн ч үгүй болов! (Инээлдэв) Үүний оронд жинхэнэ ёсоор бясалгаж эхэллээ. Бясалгагчийн дүр эсгэн энэ газарт анх ирж байснаа бодоход тэр одоо жинхэнэ лам болов, яагаад гэхээр тэр сүнслэг бясалгальн ач тусыг мэдэрсэн байж. Үүнээс хойш тэр хулгайч нэн чин сэтгэлээр бясалгах болов. Аажмаар тэр гэгээрэлд хүрч, агуу Гэгээнтэн, алдар цуутай сүнслэг бясалгал дадуудагч болжээ.

БҮХНИЙГ ЧАДАГЧ БУРХАН БҮГДИЙГ ЗОХИЦУУЛДАГ

Ж эгэн цагт ухамсар нэн сайтай Энэтхэг йогч бясалгагч тэр баяртай нь аргагүй их танхим руу гүйж очив. Тэгээд сөхрөн сууж, Бүхнийг Чадагч Бурханд, эсвэл дотоодын Их Багшдаа ч байж магадгүй, баярласнаа илэрхийлэв. Тэр хэлсэн нь: “Бурхан минь Танд баярлалаа. Та надад хэдийнээ агуу их адислал өгсөн учраас би Танд залбирч гүйх юм алга. Одоо эх минь Таны хажууд очсон болохоор би маш чөлөөтэй болж, өдөр бүр сэтгэл хуваагдалгүй Таны тухай чин сэтгэлээр үргэлж бодох боломжтой боллоо. Танд баярлалаа!” гэв.

Тэгээд хөгжилтэй нь аргагүй дуулж бүжиглэв. Хөршүүд нь энэ байдалд нь ихэд хачирхан “Яаж ингэж болох билээ? Эх нь нас барчхаад байхад ганц дусал ч нулимын унагаагүйгээр барахгүй, бүр бүжиглэж, дуулж байх шив” гэцгээв.

Бүжиглэсний учир нь Бурханд бүжгээр өргөл өргөдөг ёс байдаг болохоор тэр караоке руу яваагүй. Түүний ингэж байгаа нь караоке-д очихтой адилгүй! Эдгээрийн ижил төстэй зүйл нь - гадна талын хөдөлгөөн л байж магадгүй. Эх нь ч бас түүн шиг шүтлэгтэй, сүсэг бишрэлтэй бясалгагч байсан учраас бас нас барах үедээ гунигтай байгаагүй. Энэ өртөнц бол мөнх бус гэдгийг хоёулаа мэдэж байсан хэрэг. Иймд эх нь яввахдаа баяр баясгалантай байсан төдийгүй, тэр өөрөө ч эхийгээ явсанд баярлаж байлаа. Тэр хоёр тун хачирхалтай хүмүүс байж шүү!

Эхийгээ оршуулсны дараа Ганга мөрний хөвөөнд очиж, өдөр бүр Ариун Нэrsийг уншиж, Бүхнийг Чадагч Бурхантай харилцахаар бясалгах болов. Тэгээд гурван өдөр юу ч идэж уусангүй. Бүүр идэж уухаа ч мартчихжээ. Ганга мөрний эрэгт бусдаас хол, хажуугаар өнгөрөх мөргөлчин ч байхгүй газарт ганцаар сууж, идэх ч юмгүй байв.

Бүхнийг Чадагч Бурхан энэ байдалд эмзэглэн хажуудах хүмүүстээ хандан: “Хөөрхий минь! Ямар өрөвдмөөр юм бэ! Тэнд миний шавь олссонөөсөө болоод үхэх гэж байхад, түүнд идэх юм юу ч өгөхгүй байгаа болохоор Би өөртөө тийм ч хариуцлагатай биш шиг санагдаад байна. Тэр тэнд өдөржин, хором бүр намайг дурсаж байдаг, гэтэл Би энд түүнийг хамгаалахаа ч мартчихсан

байдаг” гэж хэлэв.

Тэгээд Бурхан хажуудаа байсан тэнгэрийн элчдээ бясалгагчид зориулж, нэг хэсэг сайхан хоол аваад мөрний эрэгт хүргэжөггэхэлэв. Чапати, сүү, алим гэх зэрэг нэлээд их адислалтай хоолыг алтан тавганд тавьж, нөгөө хүн рүү илгээжээ. Тэр тэнгэрийн элч өмнө нь хүн төрөлхтнийг, тэр тусмаа эрэгтэй хүнийг ерөөс хараагүй байжээ. Охин элч маань эр хүнийг хараад бага зэрэг ичингүйрч, тавагтай хоолоо сэмээрхэн хажууд нь тавьчхаад буцаад нисэв.

Тэр хүн хажууд нь хоол байхыг харсан боловч ойр орчим хэн ч харагдсангүй. Иймд үүнийг Бурхан л илгээсэн байх ёстой гэж бодоод Түүнд талархал илэрхийлэв. Тэгээд хоолоо идэж дуусаад үргэлжлүүлэн Бурхдын нэрийг уншиж, бясалгалаа хийн самадид оржээ. Гэнэт олон хүн түүнийг бүчин авч, сэрээв. Түүнийг баривчлан авч явах гэж сэлмээр хатгалан байв. Тэр учрыг нь олохгүй гайхан “Яаж байна аа? Юу болоо вэ?” гэж асуув.

Тэд хэлсэн нь: “Чи муу хулгайч. Чи Бурханы сүмээс энэ алтан тавгийг авч зүрхэлнэ гэнэ ээ. Бид чамайг хаанд аваачиж, шийтгүүлнэ дээ” гэв.

Тэр тайлбарлахыг хичээсэн ч цэргүүд түүнд итгэхгүй учраас ямар ч ашигтгүй байв. Тэд энэ муу ноорхой хувцастай ядуу хүүг голын хажууд сууж байхыг хараад тэр ийм үнэтэй алтан тавгийг эзэмшдэг гэж төсөөлж ч чадахгүйгээс хулгайч гэж тааварлажээ. Энэ таваг бол сүмд өргөл өргөхөд хэрэглэдэг нэг тавагтай адилхан байсан тул тэд түүнийг аваачиж шийтгүүлнэ гэж бодсон байна.

Ингээд түүнийг аваачихад хаан түүнд ихэд уурлаж, өөрийн захиргаан доорх хүмүүстээ зодож жанчихыг тушаалаа. Түүнийг тун хэрцгийгээр удаан гэгч нь зодсон боловч йогч маань энэ зодуурыг мэдэрсэнгүй, зүгээр л инээгээд байв. (Багш болон



бүгд инээлдэв) Над шиг инээгээгүй, гэхдээ иймэрхүү адилхан. Тэр зүгээр инээгээд байгаагүй, харин хэн нэгэнд гижигдүүлж байгаа юм шиг инээдээ барьж дийлэхгүй байлаа. Зодсоор байгаад тэд ядарч, бас гар нь өвджээ. (Багш болон бүгд инээлдэв) Тэгэхлээр нь түүнийг зодохoo больж, явулахаас өөр аргагүй болов. Хаанд ч бас Бурхан түүнийг хамгаалаад байгаа юм шиг хачин санагдсанаас үргэлжлүүлэн зод гэж хэлж зүрхэлсэнгүй. Хаан ихэд сониучирхан ийм таваг хулгайд алдагдсан эсэхийг мэдэхээр сүм рүү гүйв.

Тэрээр сүмд очоод Бурханы баримлаас цус урсаж байхыг харав. Хаан ихэд цочирдон “Ийм юм гэж яаж байж болох билээ? Яагаад шүтээнээс маань цус урсдаг билээ?” гэв.

Үүгээр зогсохгүй баримлын цус гарж байгаа хэсгүүд нь яг өнөөх зодуулсан хүний биеийнх нь тэр хэсэгтэй давхцан таарч байлаа. Гэсэн хэдий ч хаан ямар нүгэл үйлдсэнээ ч ойлголгүйгээр сөхрөн сууж наманчлав. Хожим нь тэр хүн гэм зэмгүй байж магадгүй, түүнийг зодох нь Бурханыг зодохтой адил гэдгийг ойлгосон байна. Тиймээс л Бурханы баримал цус алдсан юм байна гэдэгт итгэв.

Үүнд итгэснээс хойш хаан болон түүний сайд нар бүгд аижээ. Цөм голын эрэг рүү яаран очиж, өвдөг сөхрөн тэр өчүүхэн ядуу йогчийн өмнө үйлдсэн гэм нүглээ наманчлав, энэ үеэс тэд өдөр бүр түүнд хоолоор өргөл барих болжээ. Дараа нь тэднийг буцаж сүмд очиход Бурханы баримлаас цус гоожихоо нь зогссон байлаа. Ингэж тэд энэ явдлын учрыг ойлгож, гэмшил юм.

Энэ хүн чин сэтгэлтэй бясалгагч байсан бөгөөд зөвхөн Бурханыг өдөр бүр бодож, идэх юм юу ч үгүй байсанд нь Бурхан гэмшил байна. Хоолноос болж тэр зодуулсан бол мэдээж энэ нь Бурханы алдаа байх байсан. Ийм учраас Тэр ингэж шийтгэлийг өөртөө хүлээжсээ. Үнээс үзэхэд та нар Бурхан, эсвэл гэгээрсэн Будда болсныхоо дараа юунд ч санаа зовох хэрэггүй болно гэж бодож болохгүй. Хэрэв бид чин сэтгэлээсээ бясалгах юм бол Бурхан бүхнийг зохицуулах болно.

МӨНХ АМЬДРАХ НУУЦ АРГА


Эрт урьдын нэгэн цагт Хятадад мөнх амьдрах нууц аргыг мэддэг гэж дандаа ярьж явдаг нэгэн хүн байжээ. Ян улсын эзэн хаан нууц аргыг нь сурахын тулд түүнийг олж ордондоо авчурулахаар бараа бологчоо илгээв. Хэдий тийм ч тэр нь миний бараа бологчтой, эсвэл манай

Гуан Инь элчтэй маш адилхан байжээ! Тэр их удаан явж гэнэ. Мерседес Бенц юмуу, Бьюик жолоодохын оронд Ю Лон унаснаас болж их удаан явж л дээ. Өө! Тэр ер нь Ю Лон ч жолоодоогүй юм байна, сүйх тэрэг жолоодсон юм байна. Тэгээд үүнийгээ хэтэрхий тансаг байна гэж бодоод морь унасан байх. Дараа нь тэгээд морио ч гэсэн арай дэндэх юм байна гэж бодоод ердөө л явган явжээ! Ингэхээр дэндүү удаан, их удаан байсан хэрэг!

Аяллынхаа туршид тэрээр янз янзын таашаал эдэлж, Парис болон бусад олон газраар аялан замаасаа хазайж явжээ. Тийм учраас мөнх амьдрах нууцыг мэддэг тэр хүний байгаа газар хүрэхийн тулд тун их хугацаа шаардагдсан байна. Тэр хэтэрхий удаан явж, дэндүү оройтсон учраас нөгөө хүн маань хэдийнээ үхчихсэн байж. (Инээлдэв)

Ян улсын эзэн хаан үүнд ихэд хилэгнэжээ. Та нар мэднэ дээ, энэ нь миний уурлан чанга хашхирахтай адил байсан ч тэр Арьяабалын аргаар бясалгадаггүй учраас над шиг сайн байгаагүй. (Инээлдэв) Яагаад гэвэл би Арьяабалын аргаар бясалгаад ци-энергитэй болчихсон, иймээс тэр над шиг чанга хашхирч чадахгүй. Би түүнээс илүү чанга хашхирч чадна. Ийм маягаар уурлах нь үнэхээр хөгжөөнтэй шүү. (Инээлдэв)

Эзэн хаан их уурласнаас бараа бологчоо цаазаар авахыг хүсжээ. Тэгэхэд нь шадар түшмэл нь бараа бологчийг училж, амийг нь хэлтрүүлэхийг эзэн хаанаас гүйж гэнэ. Тэр эзэн хаанд



хэлсэн нь: “Энэ ертөнцөд бүх хүн амьдралын төлөө тэмцэж, үхлээс айдаг юм. Хэрэв та мөнх амьдралд хүрэх аргаас болж, түүнийг алах гэж байгаа бол энэ нь бидний үзэл санааны эсрэг зүйл болно. Түүнээс гадна тэр мөнх амьдрах нууцыг мэддэг гэж сайрхдаг хүн чинь үхчихсэн байна. Тэр өөрийгөө ч аварч чадсангүй. Энэ нь түүний нууц бол ашиггүй зүйл гэсэн үг! Иймд тэр ашиггүй хүнээс болж өөрийн ашигтай хүнээ бүү хөнөөгөөч дээ” гэв.

Тэгэхэд Ян улсын эзэн хаан түүний ухаалаг үгийг ойлгож, Ариун Нэрсийг магтан дуулж эхэлсэн бөгөөд Таван Сахилыг сахиж, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бүү хөнөө гэсэн зарчмыг дагасан байна. (Инээлдэв)

Тэр үед Ци нэртэй өөр улс байжээ. Тэнд мөн л нөгөө мөнх амьдрах нууцыг мэддэг хүний тухай сонсож, түүнийг нь сурч авахыг ихэд хүсэмжилдэг Хузу нэртэй нэг хүн байж. Тэгээд тэр хүнийг үхсэн тухай сонсоод сэтгэл нь ихэд гонсойж, харамсан уйлжээ. Ингэхэд нь түүний найз Фузу чангаар инээж хэлсэн нь: “Чи яасан мулгуу тэнэг юм бэ! Тэр мөнх амьдрах нууцыг мэддэг гэж ярьсан хүн чинь одоо үхчихсэн байна. Тэр үнэндээ тэнэг хүн юм гэдгийг чи харахгүй байна уу? Юундаа уйлаад байгаа юм бэ? Энэ байдал чинь чамайг ямар ч билиг ухаангүйг, мөн суралцахыг хүсээд байгаа юмныхаа талаар ямар ч ойлголтгүй байгааг чинь харуулж байна” гэжээ.

Хузу найз Фузудаа хариулсан нь: “Чи их андуурч байна! Зарим хүн зарим нэг нууц аргыг мэддэг боловч тэд түүнийгээ хэрхэн ашиглахыг мэддэггүй учраас ашиглаж чаддаггүй юм. Бас зарим хүн нууц аргыг хэрхэн ашигладгийг мэддэг боловч жинхэнэ аргыг хаанаас өгч байгааг мэддэггүй юм.

Жишээлбэл, урьд цагт Вэй улсад тоонд гарамгай нэг хүн байжээ. Тэр нас бараахынхаа өмнө хүүдээ тооцооны бүх аргаа хэлж өгч л дээ. Хүү нь бүгдийг нь сонссон боловч тоо бодохдоо эцэг шигээ сайн байж чаддаггүй байлаа. Гэтэл өөр нутгаас нэг хүн хүүг зорин ирж, too бодох аргаа зааж өгөхийг гүйжээ. Too заалгаж аваад мань хүн гэртээ ирээд яг л хүүгийн эцэгтэй нь адил тооны асуудал бүхэн санаанд нь багтаж, бодож, тооцоолж чадаж байв. Хүү тооны талаар мэдэхгүй боловч зөвхөн эцгийнхээ үгийг дамжуулж өгөхөд л тэр хүн бүхнийг хялбар үйлдэж, алхам алхмаар туршлагажив. Ур дүнд нь тэр өөд болсон эцгээс нь илүү сайн болсон байжээ.

Тэр мөнх амьдралын нууцыг мэддэг хүн ч гэсэн өөрөө тэр аргыг мэддэг байсан байж магадгүй ч ашиглаагүй юм уу, эсвэл зохих ёсоор нь хэрэгжүүлээгүй байх. Хэрэв бид түүнээс нууц

аргад суралцаад өөрсдөө хэрэгжүүлж үзсэн бол гайхамшигтай байх байлаа!” гэжээ.

Арьяабалын аргын хувьд ч мөн адил. Та нарудаан хугацаагаар хөдлөхгүйгээр 10 цаг зохих ёсоор нь сууж, сайн ахуй ойлголттой болж байвал энэ нь тэр аргыг хамгийн зөв арга гэдгийг харуулж байна. Энэ нууц арга нийтэд зөвшөөрөгдсөн байдал. Тиймээс, хэрэв та нар Их Багшийн заавруудыг даган бясалгаж чадвал буруудахгүй! Заримдаа би та нарыг сургахаар Гуан Инь элчийг илгээхэд та нар тэдний аман зааврыг даган бясалгадаг. Энэ үед би тэнд байхгүй байх нь хамаагүй. Зааж байгаа бясалгах аргыг л яг дагавал та нар маш сайн ахуй ойлголттой болж чадна.

Тэр Гуан Инь элч нар сүнслэг бясалгал дадлын хувьд та нараас илүү биш байж магадгүй тул та нар тэднийг шутэх шаардлагагүй. Үүний оронд өөрсдийнхөө жинхэнэ Мөн чанараа шут. Биднээс далд байгаа дотоод дахь жинхэнэ, бүхнийг чадагч Их Багшийн хучийг шут. Гуан Инь элч нараар дамжуулсан Их Багшийн заасан аргыг зохих ёсоор хэрэгжүүлснээр бид хүсэн эрмэлзэж байгаа тэр зорилго болох Үнэнд хүрэх нь эргэлзээгүй. Хэдий тийм ч бид үүнийг ярихдаа, энэ арга бол хамгийн чухал нь гэдэггүй! Амьд энериgi дотоод руу дамжин орж ирэх үед л бидний дотоодын маань хүч идэвхэжэдэг юм.

Энэ үлгэрт тэр хүн нууц аргыг мэдэх учрал тохиосон, эсвэл Үнэнийг олсон Их Багшаас сурсан байж магадгүй гэвэл хамгийн зөв болно. Тийм болохоор бусад хүн ч гэсэн түүнээс суралцсан бол зүгээр хэрэг. Тэр нууц арга нь хаанаас ч хамаагүй олдог эд биш. Яагаад Ян улсын хөгшин эрээс гадна өөр хэн нэгэн хүн мөнх амьдрах нууцыг мэддэггүй билээ? Тэгээд өөрөө мэдсээр байж яагаад үхчихсэн юм бэ?

Үнд хоёр тайлбар байна. Нэгдүгээрт: Ян болон Ци улсын тэр хүмүүс мөнх амьдралын тухай хэлсэн түүний угийг буруу ойлгосон байж магадгүй. Мөнх амьдрал гэдэг нь бидний бие махбод үүрд байна гэсэн уг биш, харин бидний сүнс мөнхөд чөлөөлөгдөх болно гэсэн уг юм. Бид хэзээ ч үхэхгүй, төрөхгүй, бүтээл угүй, сүйрэл угүй, цэвэр угүй, бохир угүй ийм түвшинд хүрэх үедээ л үнэхээр мөнх байх болно. Хэдий тийм боловч ердийн хүмүүс мөнх амьдралын тухай сонсох үедээ материаллаг талыг л боддог. Тиймээс тэдний зарим нь тэр хүнийг ухсэнийг мэдээд сэтгэл нь гонсойсон, зарим нь түүнээс мөнх амьдралд суралцахыг хичээсэн бусдыг шоолон хөхөрч, “Хэрэв тэр багши чинь өөрөө үхчихсэн юм бол яаж та нар түүнээс суралцах юм бэ?” гэж байжээ. Энэ бол хамгийн зөв тайлбар гэж би бодож байна.

Өөр нэг тайлбар нь: Тэр хүн нууц аргад суралцсан боловч түүндээ түрилагажсаагүй байх. Эсвэл тэр арга нь үнэхээр хүмүүсийг хэдэн мянган жилээр байтугай, хэдэн арван мянган жил хөгширөлгүйгээр амьдруулах арга байсан байх. Бид юу байгаа, юу байхгүй талаар яаран дүгнэлт хийж болохгүй. Бид үнэхээр мэдэхгүй бол мэдэхгүй гэдгээ л хэлнэ. Хэрэв бид мэдэж байгаа бол “Тийм ээ, би мэднэ” л гэж хэлнэ.


Хэрэв энэ хүн мөнх амьдралд хүрэх аргыг мэддэг байсан бол яагаад үхэх ёстой гэж? Их Багшийнхаа зааж өгсөн арга барилыг үргэлжлүүлээгүй, эсвэл энэ аргыг нухацтай хэрэгжүүлээгүйгээс ямар ч үр дүнд хүрээгүй юм болов уу. Энэ ч бас боломжийн л тайлбар.

Жишээ нь, ихэнх хүн Тай Чи Чуан яаж хийхийг мэддэг, эсвэл танго, румбо, ча ча зэргийг яаж бүжиглэхийг номоос уншиж байгаад л сурчихдаг. Эхний алхмыг баруун хөлөөс, дараа нь зүүн, буруу эргэ, дараа нь баруун, урагшаа, хойшиоо гэх мэт. Тэр энэ бүгдийг мэднэ, бас бүжгийн алхмуудыг ч дүрслэн үзүүлнэ. Хэдий тийм ч тэр үүнд дадлагажихгүй бол, эсвэл зөвхөн ганц хоёр өдөр бэлтгэл хийгээд бүжгийн клубт байнга явахгүй бол тэгээд л мартана.

Хэрэв бид түүнээс энэ бүхнийг дүрслэн үзүүлсэн зурагт номыг олж авбал бид ч бас сурч чадна. Эхэндээ энэ нь үнэхээр төгс биши байж болох ч нэгд, бид үндсэн алхмуудад суралцаад дадлагажсвал улам сайжирна. Эсвэл түрилагатай хүнтэй дадлага хийж чадвал бүр сайжрах нь мэдээж. Хожим үүн дээрээ бид оюун ухаанаа нэмж, авьяас чадвараа дайчилбал ер нь илүү сайн бүжиглэж сурна.

Яагаад тэр үед Хятадад мөнх амьдрал нууц аргыг зөвхөн тэр хүн л мэдээд өөр ганц ч хүн энэ аргыг яагаад мэдэхгүй байв? Энэ нь манай Гуан Йиң элч газар бүрт хэд хэдээрээ байдаггүйтэй адил байсан байж магадгүй. Жишээ нь, Их Багш бол ганц хоёрхон л байдаг, тэдэнд арга дамжуулах чадвартай шавь олон байхгүй бол газар бүрт хэд хэдээр нь илгээгээд байх боломжгүй шүү дээ. Тиймээс тэр үед, тухайн улсад үүнийг мэддэг ганцхан хүний тухай л хүмүүс сонссон байсан биз ээ. (Алга ташилт)

ӨГЛӨГИЙН УРХИ ЗАНГА



Энэ бол Шукла гэлэнмаагийн тухай үлгэр. Нэгэн удаа Ертөнцийн Эзэн, Шагжамуни Будда Сарасвати-д байх үедээ Четавана Ашрамд saatаж байжээ. Тэрээр дөрвөн булэг сүсэгтэн олонд (эрэгтэй, эмэгтэй, лам хувраг болон энгийн сүсэг бишрэлтэй хүмүүс гэсэн үг) Дээдийн сургаалын талаар айлдаж байв. Тэр үед үзэсгэлэн төгс охинтойгоо амьдардаг нэг их баян хөгшин байжээ. Тэр охинд нь нэг үнхээр онцгой зүйл байсан нь эхээс мэндлэх үедээ охин ам цагаан даавуугаар биеэ ороож төржээ. Үүнд гайхсан эцэг, эх нь үзмэрчээс учрыг нь асуухад үзмэрч хэлсэн нь: “Та нар санаа зовох хэрэггүй, охин чинь адислал буянаар дүүрэн юм байна. Би түүнд Шукла гэдэг нэр хайлдлаа” гэж гэнэ.

Охин өсөхийн хэрээр түүний бие дэх цагаан даавуу түүнтэй хамт томорч байв. Мөн улам л хөөрхөн, дэгжин болжээ. Удам угсаа сайтай, чинээлэг айлын охин болохоор гэрлэхийг санал болгогчид олон байлаа. Гэсэн ч охин хэнийг нь ч сонирхож байсангүй.

Нэг өдөр эцэг нь хамгийн чадварлаг дархчуулыг дуудан ирүүлж, охины инжиннд зориулан сайхан гоёл чимэглэл хийлгэх болов. Охин эцгээсээ: “Энэ бүх чимэглэлийн зүйлийг юунд зориулаа вэ?” асуужээ.

Эцэг нь хэлсэн нь: “Чи одоо насанд хүрлээ, би чиний

гэрлэлтэд бэлтгэх хэрэгтэй!” гэв.

Охин эцэгтээ хэлсэн нь: “Гэрлэлт бол богино хугацаанд л үргэлжлэх зүйл. Энэ нь нэг их хэрэгтэй зүйл биш төдийгүй, ер нь бидэнд гай зовлон л авчирна. Би гэрлэхийг хүсэхгүй байна. Харин гэлэнмаа болмоор байна. Гэлэнмаа болох нь илүү сайн бөгөөд тэгж байж л чөлөөлөгдөх болно” гэлээ.

Тэрээр эцэг, эхийнхээ ганц хүүхэд нь байв. Нэгэнт түүнийг ятгаж чадаагүй тул дахин эсэргүүцэж, шахаж шаардалгүй, гэлэнмаа болохыг нь зөвшөөрөв. Дараагийн өдөр эцэг нь хэсэг даавуу худалдаж авахаар гадагш явах болов. Охиндоо зориулж хийдэд хэрэглэгддэг даавуу авахыг хүсжээ. Охин: “Би гэлэнмаа болох гэж байхад та бас юунд ийм их даавуу бэлдсээр байгаа юм бэ?” гэж асуув.

Эцэг нь: “Би чамд гэлэнмаагийн нөмрөг л бэлдэж байна” гэхэд охин толгойгоо сэгсрээд хэлсэн нь: “Тэгэх хэрэггүй ээ, миний биен дэх ам даавуу л хангалттай” гэв.

Эцэг, эх нь эргэлзэж юу хэлэхээ ч мэдсэнгүй. Ингээд охиноо аваад Буддад бараалхахаар авчирчээ. Мэдээж, Шукла Буддагаас түүний үсийг хусаж, хийдийн хүн болгож өгөх зөвшөөрөл хүссэн байна. Тэр Буддад хандан: “Эрхэм Ертөнцийн Эзэн минь ээ, хүний биеийг олж аваад Үнэний тухай сонсож, амьд Буддатай учирна гэдэг олдошгүй аз завшаан бөгөөд энэ бол их хэцүү билээ. Одоо би нэгэнт хүмүүний биеийг олж аваад Үнэний тухай сонсож, Буддатай учирлаа. Иймд нигүүлсэнгүй Эзэн минь гуйя, өөрийгөө сүм хийдэд авч, үсээ хусуулж, үхэж төрөхийн хүрднээс чөлөөлөгдөх боломж олгооч дээ... гэх мэт” гэж хэлжээ.

Тэгэхэд нь Будда юу хэлсэн бэ? “Маш сайн байна, гэлэнмаа” гэжээ.

Буддаг хэлж дуусангуут түүний үс нь тэр чигээрээ уначхав, (Багш болон бүгд инээлдэв) түүний биен дэх ам даавуу нь бас нөмрөг болон хувирчхав. Сайхан юм! Ингэх нь үнэхээр цаг хугацаа



хэмнэх юм байна! Ингэвэл бид ч бас сахлын тонгорог, хувцас болон бусад бүх зүйлээ хэмнэж чадна. (Бүгд инээлдэв) Үүний дараа Будда Үнэнийг заалгуулахаар гэлэнмаа Махапражатид шавилуулжээ. Тэр маш хичээнгүй бясалгаснаар удалгүй Архадын зэрэгт хүрч гэнэ. Үүнд Ананда ихэд сониуч зантай тул сөхрөн сууж алга хавсран Буддагаас асуусан нь: “Эрхэм хүндэт Ертөнцийн Эзэн минь ээ, гэлэнмаа Шукла өнгөрсөн амьдралдаа ямар буянтай үйлс үйлдсэнээс түүнд язгууртан гэр бүлд, тэр тусмаа ам даавуун ороолттой төрөх боломж олдож, түүнчлэн сүмд орсныхоо дараахан удалгүй Архадын зэрэгт яагаад хүрэв? Эзэн минь, Та мэдэж байгаа шүү дээ, надад хэлж өгөөч?” гэв.

Будда Анандад хэлэхдээ: “Энэ ертөнцөд аль эрт үед нэгэн Будда бууж ирсэн юм. Түүний нэрийг Випашин (Vipasyin) гэдэг байжээ. Тэр үргэлж шавь нартайгаа хамт явж, хүмүүсийг ухааруулахыг зорьдог байв. Хaa ч явсан хаад түшмэд, хотын иргэд ихэд хүндэтгэнэ. Тэд түүнд өргөл өргөж, сүнслэг цуглаан зохион байгуулж, Үнэний талаар тайлбарлан ярьж өгөх хүсэлт тавьдаг байжээ.

Тэр үед хүмүүстэй танилцах дуртай нэгэн их уужим ухаантай гэлэн байж. Бас тэрээр өдөр болгон гадагш явж, айл өрх, байшин болгоноос бадар барьж, хариуд нь адис өгдөг байлаа. Тэрээр мөн Үлэмж үзэхүй-гүн үзэл (Vipassana)-ийн жинхэнэ номыг хүн бүрт номлож, танилцуулдаг байв.

Гэр бүл нь туйлын ядуу нэгэн залуу эмэгтэй байжээ. Тэр эмэгтэй нөхөртэйгээ дундаа биеэ халхлах ганцхан даавуутай юм байж. Нөхөр нь гуйлга гүйхаар гадагш явбал тэр түүнд даавуугаа өгчхөөд өөрөө гэртээ өмсөх юу ч үгүй үлдэнэ. Эхнэрийнх нь гуйлга гүйх ээлж болвол нөхөр нь гэртээ үлдэж, хэсэг өвсөн дээр суугаад хүлээж байдаг байв.

Нэг өдөр гэлэн бадар барих замдаа тэдний гэрийн хажуугаар өнгөрч явж. Тэгээд залуу эмэгтэй хараад түүнд хэлсэн нь: “Өө, залуу хатагтай! Хүмүүний төрлийг олж авах, Үнэний тухай сонсох, Буддатай уулзах нь олдошгүй хувь заяа гэдэгт итгэх хэрэгтэй. Одоо энэ ертөнцөд амьд Будда ирээд шашны судар болон Үнэнийг үргэлж номлож байна. Чи очиж Үнэнийг сонсох юм бол хязгааргүй буян хариуллыг олох нь гарцаагүй. Чи одоо ядуу зүдүү



байна. Яагаад ийм болов гэхээр чи өмнөх төрөлдөө их харамч байж, ямар ч өглөг өгдөггүй байснаас одоо энэ шийтгэлийг хүлээж байна. Хэрвээ энэ амьдралдаа өргөл өргөх юм бол ирээдүйд хөрөнгө бэлтэй болох нь эргэлзээгүй” гэв.

Үүнийг сонсоод залуу эмэгтэйн сэтгэл нь их догдолжээ. Эмэгтэй гэлэнг гадаа түр хүлээж байхыг гүйгаад өөрөө дотогш орж нөхөртөө хэлсэн нь: “Гадаа байгаа тэр шраманаг (самгарьд: çramana-гэлэн) хар даа. Тэр биднийг явж, амьд Буддатай уулзаж номлолыг нь сонс гэж зөвлөж байна. Бас биднийг өргөл өргөх юм бол хожим нь буян заяагаа эдэлнэ гэж байна. Бидний энэ амьдралын ядуу тарчиг байдал нь урьдын амьдралдаа өглөг өгөөгүй, хязгааргүй хомхой сэтгэлтэй байсан зэрэг алдаа дутагдлын үр дүн гэж байна. Одоо бид дараагийн амьдралдаа илүү сайхан амьдрахын тулд сайн сайхны бага ч гэсэн үрийг суулгах ёстай” гэжээ.

Түүний яриаг сонссоныхоо дараа нөхөр нь хэлсэн нь: “Тэгээд бид юу хийх вэ? Бид гэртээ юу ч угүй шүү дээ. Бид маргааш идэх юмтай эсэхээ ч мэдэхгүй шүү дээ. Бид ямар өргөл өргөж чадах билээ?” гэлээ.

Тэгсэн хэдий ч эмэгтэй өөрийнхөөрөө зүтгэн хэлсэн нь: “Гэсэн ч би хэдийнээ юм өгөхөөр шийдчихсэн, би өгөх ёстай! Хэрэв бид энэ удаа л өгөхгүй юм бол дараагийн төрөлдөө буцаж ирэхдээ одоогийнх шигээ хөөрхийлөлтэй амьдрах юм уу, эсвэл бүр дор ч байж мэднэ” гэв.

Тэгэхлээр нь нөхөр нь бодож байна аа: “Аан, манай хүн бага зэрэг юм сэмхэн надаас нуучхаад түүнийгээ хэлээгүй байх нь!” Ингээд тэр эхнэртээ: “За тэгье! Хэрэв чи өгөх гэж үнэхээр хүсээд байгаа юм бол хүссэнээ л өг!”

Эхнэр нь хэлсэн нь: “Ашгүй дээ! Нэгэнт чи зөвшөөрснөөс хойш би, бидний ганц өмч болох даавуугаа гэлэнд өргөл болголоо. Надад хурдхан өгөөдөх!”

Ингэхэд нөхрийнх нь сэтгэл зовж хэлсэн нь: “Өө, угүй! Бид хоёр гадагш гарч гуйлга гүйхад энэ даавуу л хэрэг болж байгаа учир бидний байдал энэ даавуунаас хамаарч байна. Хэрэв үүнийг гэлэнд өргөчих юм бол одооноос эхлээд бид яах болж байна аа? Бид эндээ суугаад өлссөнөөсөө болж үхэх болж байна уу?”

Тэгэхэд эхнэр нь хэлсэн нь: “Хань минь, бид өргөл өргөх эсэхээс үл хамааран эрт орой нэгэн цагт үхэх л болно. Иймд яагаад одоо өгч болохгүй гэж? Биднийг үхсэний дараа ирээдүйд энэ очүүхэн өглөг маань бага ч атугай буян хариулалтай болгох

юм биш ю?”

Нөхөр нь бодоод үзтэл эхнэрийнх нь яриад байгаа нь бас ч гэж үндэслэлтэй санагдаж, эцэст нь зөвшөөрч: “Чи одоо түүнд даавуугаа өргөл болго доо, энэ чинь сайн юм болох болтугай” гэжээ.

Эхнэр даавуугаа өргөл болгохын өмнө гэлэнг байшингийнхаа дээвэр дээр авирч гаргахыг гүйхаар болов. Учир нь тэр даавуугаараа өргөл өргөхдөө ямар ч хувцасгүй харагдахаасаа ичсэн хэрэг. Тэр хэлсэн нь: “Буянтан минь, та байшингийн дээвэр лүү авирахгүй ю? Би танд нэг зүйлээ өргөл болгой”.

Тэгэхэд гэлэн ихэд гайхан: “Хэрэв та нар ямар нэгэн юмаар өргөл өргөх гэж байгаа бол энд л өгчих. Яах гэж дээвэр өөд гаргах гэж гүйгаад байгаа юм бэ?” гэхэд

Эмэгтэй хэлсэн нь: “Буянтан минь, ойлгож хайрлаач. Нөхөр бид хоёр дундаа ганц даавуутай юм, түүнийгээ танд өргөл болгох гэж байна. Иймд үүнийгээ танд өгчихөөр таны нүдний өмнө ямар ч хувцасгүй байх нь бидний зүгээс дэндүү ээлдэг бус явдал болно. Хэрэв та дээвэр дээр байвал би гэртээ биеэ халхална, тэгээд өргөлийг маань аваад та буувал таныг эвгүй байдалд оруулахгүй байх болно”.

Ингээд гэлэн дээвэр өөд гарах зуур эмэгтэй гэртээ орж хаалгаа хаажээ. Тэгээд цонхoo онгойлгоод түүнд өргөх даавуугаа дээвэр лүү дээш нь шидчихлээ. Хэдийгээр тэр даавуу бохир, хуучирсан, ямар ч үнэгүй эд байсан ч тэрээр эр, эм хоёрын чин сэтгэлийн өргөлийг ойлгон дуртайяа хүлээн авчээ. Тэр хос залууг адислаад даавууг авч, Буддад өргөхөөр буцав.

Удалгүй Випашин Буддагийн байгаа газарт эргэж ирэхэд Будда тэр даруй түүнд хэлсэн нь: “Гэлэн минь, наад ам даавуугаа надад өгөөч” гэж гуйв.

Буддаг даавууны талаар мэдэж байгааг гадарласан гэлэн хэлсэн нь: “Тэр хосын чин сэтгэлийн өргөлийг хүлээж авна уу?” гэлээ.

Випашин Будда даавууг хүлээж авсныхаа дараа тэр даавуу руу нэг тийм их ээлдэг зөөлөн харцаар харжээ. Яг тэр үед Тэрээр хаан, шадар түшмэл, цэргүүд, зарим баян язгууртан болон олон нийтийг хамарсан томоохон чуулганд номлолоо айлдаж байжээ. Хүн бүр Буддагийн айлдварыг хүндэтгэлтэй, анхааралтай сонсож байв. Гэнэт тэд Буддаг юм арчдаг даавуу шиг бохир, хуучин, элэгдсэн ам даавуу барьж байгааг болон Тэр түүн лүүгээ үргэлжлүүлэн тас ширтэн байгааг ажиглажээ. Хүн бүрт хачин

санагдаж бүгд гайхав. Будда тэдний бодлыг мэдээд хэлсэн нь: “Энэ цуглаанд хүмүүсийн өгсөн бүх өглөгөөс энэ ам даавууг надад өргөсөн хүнээс давж гарах чин сэтгэлтэй нэг ч хүнийг би олж чадахгүй байна” гэжээ.

Буддагийн айлдвартыг сонсоод бүгд гайхав. Хатан тэр даруй өмсөж байсан бүх хувцсаа, гоёл чимэглэл, үнэт эдлэл гэх мэтээ өргөв. Тэгхэд хаан ч бас бүх хувцсаа тайлж, бараа бологчийнхоо болон өөрийнхөө авч явсан хамаг мөнгөө өгчээ. Дараа нь тэр бүх зүйлийн хамт хэдэн хүнийг ядуу хос руу илгээж, тэднийг энэ бүх өргөлийг хүлээж аваад чуулганд нэгдэхийг урьжээ. Тэд ядуу хосыг өмсөх юм юу ч үгүйг мэдээд тэдэнд зориулан бүх хувцсаа тайлж өгсөн аж. Энэ агшинд Випашин Будда энэ боломжийг ашиглан хүн бурийн чин сэтгэлийн өргөлийн буян хариултыг тайлбарлаж, харамч байх, хомхой сэтгэлийн цээрлэлийн тухай хүн бүрт сануулан сээрэмжлүүлэв.

Шагжамуни Будда Анандад сануулсан нь: “Ананд, тэр ядуу зүдүү эмэгтэй бол одоо энэ Шукла гэлэнмаа юм гэдэгт чи итгээ биз. Түүний чин сэтгэлийн ариун өглөгөөс үүдэн тэр дараагийн ерэн нэгэн галавын турш хаана ч төрсөн үргэлж биеэ ороосон ам даавуутай байсан. Тэр бас үргэлж хөрөнгө чинээтэй, тохитой, мөн амгалан амьдралтай байв. Тэр амьд Буддагийн сургаалыг сонсож, чөлөөлөгдөхөөр хатуу шийдсэнээс надтай учирч, Архадын зэрэгт хүрэх чадалтай болсон юм. Та нар бас үүнээс санаа авч, хичээнгүйлэн бясалгаж, бас өглөг өгөхийг хүсэмжилж бай” гэлээ.

Буддагийн энэ айлдвартын дараа олон хүн өргөл өргөж, өглөг буян үйлдэхээр шийджээ. Бүгд сэтгэл хангалаун болж, Үнэний баяр баяслаар дүүрэн болжээ.

Энэ үлгэрийн талаар та нарт ямар нэг эргэлзээ, бодол санал, сэтгэгдэл байна уу? Та нар ямар нэг зүйл өгөх, эсвэл санал болгохоор шийдэв үү? Энэ чуулганд байгаа бүх хүн өргөл өгч, ингэснээр бүгд Архадын зэрэгт хүрэхээр шийджээ! Энэ ам даавуу хачирхалтай санагдахгүй байна уу? Энэ даавуу үнэхээр тэр хоёрынх байсан, тийм үү? Зүгээр л ийм зүйл болж, тэр эмэгтэй өргөлд зориулахыг нөхрөөсөө гүйсан байна. Ийнхүү тэр



эмэгтэй ерэн нэгэн галавын турши даавуутай байжээ. Бохир, элэгдсэн хуучин даавууг өргөлд өргөснөөр эмэгтэй эргээд цагаан даавуутай болсон төдийгүй, хожим нь бүр Архадын зэрэгт хүржээ. Энэ үнэхээр итгэмээргүй шүү.

Даавуу эхнэр, нөхөр хоёрынх байтал яагаад эхнэр нь буян заяа эдэлсэн юм бз? Бид нөхөр нь ямар ашиг тус хүртсэн талаар сонссонгүй. Яагаад гэвэл өргөл өргөхийг эхнэр нь санаачилсан бөгөөд тэр үед нөхөр нь үнэндээ өргөл өгөхийг хүсээгүй. Тэр суулд нь санаагаа өөрчилсөн! Нөхрийнх нь бэлэн байдал бага зэрэг удаан байжээ. (Бүгд инээлдэв) Иймд хэрэв та нар ямар нэг юм хийхийг хүсвэл хурдан шийдээд шууд хийвэл үр дүнд нь хамгийн сайн буян заяа эдлэх болно.

Амьд Буддагийн шавьд чин сэтгэлээсээ өргөл өргөхөд л тэр ерэн нэгэн галавын турши төрөл бүрдээ цагаан даавуунд ороолттой байж, үргэлж чинээлэг гэр бүлд төрсөн байна. Эцэст нь амьд Буддатай учирч Архадын зэрэгт хүрсэн нь Анандаас ч хурдан байсан төдийгүй, Ананд ч түүнтэй энэ зэрэгцэхээргүй юм. Гэлэнмаа авшигийн дараах цөөн хэдэн сард амжилт олж, Архадын зэрэгт хүрсэн байхад Ананд Шагжамуни Буддаг Нирваан дүр узуулсний дараа л дөнгөж Архадын зэрэгт хүрсэн юм.

Хэдий тийм боловч өргөл өргөх нь сайн гэж та нар бодож байна уу? (Танхимаас: энэ бол хамгийн сайн нь биши.) Хамгийн сайн нь биши! Тэр ам даавуунаас болж ерэн нэгэн галавын туршид ухэх төрхийн сансрын хүрдэнд эргэлдэнэ гэдэг үнжээр аймшигтай! Үнэндээ тэр эмэгтэй тухайн цагт өргөл өргөх биши, оронд нь чөлөөлөгдөхийг хүссэн бол нэг амьдралдаа чөлөөлөгдөх байлаа. Дараа нь түүнд энэ бүх буян хариуллыг хүртэх ч хэрэггүй байсан. Харамсалтай нь өргөл өргөх үедээ хамгийн чухал нь болох чөлөөлөгдөхийг гүйгаагүй аж. Ирээдүйд хөрөнгө бэлтэй амьдралыг хүссэн учраас л өглөг өгсөн.

Тэгэхлээр энэ хэний гэм буруу байв аа? Энэ нь эмэгтэйн өөрийнх нь алдаа юу? Үгүй! Энэ бол Буддагийн шавь тэр гэлэнгийн алдаа. Тэр түүнд хамгийн дээд аргын тухай хэлсэнгүй. Тэр зөвхөн гурван өртөнцийн доторх буян хариуллыг л таниулсан байна. Хэрэв өргөл өргөвөл чи буцаад буяныг нь хүртэх болно гээж л хэлсэн, улмаар тэдний доторх шуналыг нь дэвэргэжсээ. Хэрэв тэр эмэгтэйд хэлэхдээ: “Та нар одоо ядуу байна, гэвч үүнд санаа битгий зов. Энэ өртөнцөд амьд Будда байдал. Хэрэв чи Түүнийг даган бясалгаж гэтэлж чөлөөлөлтөд хүрэхийг шийдвэл эрдэнэсийн зүйл төрөл төрлөөрөө дүүрэн байдал Бурханы оронд төрөх болно. Чөлөөлөгдсөнийхөө дараа чи хүссэн болгоноо авч

чадна. Та нар энэ хорвоод байгаа цагт баян байсан ч энэ нь Бурханы орон, Нирвааныг гүйцэхгүй” гэх ёстай байсан.

Хэрэв тэр хэлэхдээ ингэж хэлсэн бол илүү сайн байх байсан биш үү? Багши нь та нарт дотоод дахь хөрөнгө мөнгөнд шунах сэтгэл гарч ирэхээс айж, буяны өглөгийг онцгойлж үздэггүй учир энэ. Би хаана ч явсан буяны үйлийг онцолж үздэггүй. Хэрэв би ер нь ингэх юм бол доромжсолтын эсрэг хүлцэл тэвчээрийг, хичээнгүй зүтгэл, самади, билиг ухааныг харгалzan хийдэг. Энэ бол нэг бүхэл юмны зөвхөн нэг л хэсэг нь бөгөөд тийм чухал зүйл биш. Бид энэ өртөнцийд юу ч угүй ирээд хожим нь юу ч угүй орхин явах учраас буяны өглөг бол агуу зүйл биш гэдгийг би та нарт үргэлж хэлдэг шүү дээ. Бид энэ өртөнцийд их өртэй. Бид бусад хүнд багахан юм өгөх үедээ өрнөөсөө төлж байна л гэж ойлгох хэрэгтэй. Үнийг буяны уйл гэж үнэндээ тооцож болохгүй.

Тиймээс бид эндээс хамгийн дээд арга болон энгийн аргын хоорондох зөрөөг мэдэж чадна. Энгийн арга нь хүмүүст ирээдүйд буянаа эдлэхийн төлөө өглөг буян үйлдэж бай, тэгж аажсим аажсмаар нирваан руу дөхөх болно гэх мэтийг зөвлөдөг байна. Ерэн нэгэн галав! Амитаба! Ерэн нэгэн галав гэдэг нь хэр удаан хугацаа болохыг та нар ойлгож байна уу? Бид ерэн нэгэн галав битгий хэл, ерэн нэгэн удаагийн амьдралыг ч ер нь тэвчих аргагүй.

Та нар төрөх болгондоо хэр баян байхаасаа ул хамааран төрөх, хөгширх, өвдөх, ухэх зовлонтой байдаг. Бид төрөх бүртээ, хөгшин болохдоо, өвдөх үедээ зовиуртай байдаг бөгөөд ялангуяа ухэх болон салах үедээ бүр их шаналдаг. Тэгээд төрөх, ухэхийн хооронд ихээхэн шударга бус явдал, ихээхэн хүнд хөнгөн зовлон, ихээхэн гэнэтийн сэтгэлийн хөдлөл болон таагуй учрал байсаар байдаг. Үнэндээ ийм байдаар ерэн нэгэн галавын турши амьдрах ямар ч хэрэг алга.

